

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
10 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

<b>№</b>	<b>Баримтын агуулга</b>	<b>Хуудасны дугаар</b>
1	Хуралдааны товч тэмдэглэл	1-8
2	Дэлгэрэнгүй тэмдэглэл	9-139
	1.Зэвсэгт хүчний Жанжин штабын даргыг томилох тухай /зөвшилцөх/	11-25
	2.“Монгол Улсын 2018 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2019.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/	26-51
	3.“Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг	51-101
	4.Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2019.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	102-111
	5.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2019.09.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	111-138

**Монгол Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы  
10 дугаар сарын 04-ний өдөр /Баасан гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 75 гишүүнээс 38 гишүүн ирж, 50.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 35 минутад Төрийн ордны Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ж.Бат-Эрдэнэ, Ц.Гарамжав, Б.Жавхлан, Д.Мурат, М.Оюунчимэг, Д.Хаянхярваа, Д.Цогтбаатар, Н.Цэрэнбат, Б.Энх-Амгалан, Л.Энх-Амгалан, Л.Энхболд;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Н.Оюундарь;

Тасалсан: Б.Наранхүү, Н.Номтойбаяр, Д.Сумъяабазар;

Хоцорсон: Ж.Батзандан -44 минут, Б.Батзориг -50 минут, Х.Болорчулуун -35 минут, Ж.Мөнхбат -1 цаг 36 минут, З.Нарантуяа -10 минут, Я.Содбаатар -1 цаг, О.Содбилэг -10 минут, Н.Учрал -30 минут, Б.Чойжилсүрэн -10 минут, Ж.Энхбаяр -59 минут, С.Эрдэнэ -44 минут.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Ёс зүйн дэд хорооны дарга Б.Бат-Эрдэнэ үг хэлэв.

.....

**Гурав. “Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Хууль, эрх зүйн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга Н.Цогтсайхан, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Э.Түвшинжаргал, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх А.Солонго, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх М.Үнэнбат, зөвлөх Б.Хонгорзул нар байлцав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийн талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцсэн талаарх Хууль байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Ганболд, Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат нар танилцуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хориг болон Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар, С.Эрдэнэ, Л.Болд, Б.Бат-Эрдэнэ, Т.Аюурсайхан, Ж.Энхбаяр, Д.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт, Хууль зүйн

байнгын хорооны дарга Х.Нямбаатар, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга Н.Цогтсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Нямдорж, О.Батнасан, Ж.Батзандан, Д.Эрдэнэбат, Х.Нямбаатар, Х.Баделхан, О.Баасанхүү, Т.Аюурсайхан, С.Эрдэнэ, Л.Болд, Д.Лүндээжанцан, С.Бямбацогт, З.Нарантуяа, С.Жавхлан, Д.Оюунхорол нар үг хэлэв.

**Г.Занданшатар:** Төрийн байгуулалтын байнгын хорооны саналаар “Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	19
Татгалзсан	34
Бүгд	53

35.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	23
Татгалзсан	27
Бүгд	50

46.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн М.Билэгт, С.Жавхлан, Д.Эрдэнэбат нар “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах дээрх санал хураалтыг хүчингүй болгох нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн М.Билэгт, С.Жавхлан, Д.Эрдэнэбат нарын гаргасан, “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалтыг хүчингүй болгох нь зүйтэй гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	25
Татгалзсан	26
Бүгд	51

49.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, Я.Санжмятав нар “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах дээрх санал хураалтыг хүчингүй болгох нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, Я.Санжмятав нарын гаргасан, “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалтыг хүчингүй болгох нь зүйтэй гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	28
Татгалзсан	24
Бүгд	52

53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг санал хураалтыг хүчингүйд тооцов.

Дээрх горимын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Нямдорж үг хэлэв.

Мөн Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга Н.Цогтсайхан тайлбар хийв.

**Г.Занданшатар:** “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн	30
Татгалзсан	21
Бүгд	51

58.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /18:29/

*Уг асуудлыг 18 цаг 29 минутад хэлэлцэж дуусаав.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ТАМГЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
10 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН  
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая. Гишүүдийн ирц 50.7 хувьтай байна.

Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 4-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргыг томилох саналыг зөвшилцөх тухай асуудал.

2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2018 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

3.Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэнэ.

4.Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл.

5.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг хэлэлцэнэ.

6.Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

.....

**Гурав. Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэнэ.**

Ерөнхийлөгчийн хоригийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд танилцуулна. Энхболд даргыг индэрт урьж байна.

**З.Энхболд:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын шийдвэрт хориг тавьсан тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг танилцуулъя. Хоригийг 2019 оны 9 сарын 20-ны өдрийн албан бичгээр мэдэгдсэн байгаа.

Ард нийтийн санал асуулга явуулах тухай, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Улсын Их Хурлын 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолыг 2019 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Ерөнхийлөгчийн Тамгын газарт ёсчлон ирүүлсэнтэй танилцлаа.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагааг хууль зүйн зөрчил маргаангүй явуулбал зохих талаар миний бие 2019 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Е/37 тоот дугаар албан бичгээр Улсын Их Хуралд сануулан, удаа дараа анхааруулсан боловч үл ойшоон, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийг илэрхий зөрчсөн байдлаар Үндсэн хуулийн асуудалд хандсаныг хүлээн зөвшөөрөх аргагүй байна.

Хууль ёсыг чанд баримталж, нийгмийн зөвшилцөл, ойлголцлын хүрээнд явуулах ёстой Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудалд нэг нам хүч түрэмгийлэн дур зоргын байдлаар хандах нь сайн зүйл авч ирдэггүйг 2000 оны нэмэлт, өөрчлөлтүүд бүрэн харуулсан. Тодруулбал, 2000 оны нэмэлт, өөрчлөлтийг олон нийт дордуулсан долоон өөрчлөлт хэмээн нэрлэж, Үндсэн хуульд орсон цагаас нь хойш өнөөг хүртэл шүүмжилж ирлээ. Энэ удаагийн оролдлого ч мөн дордуулсан долоон өөрчлөлтийг засна гэсэн уриа лоозонтойгоор эхэлж, үл бүтэх байдлаар өрнөлөө.

Монгол Ардын нам Улсын Их Хуралд үнэмлэхүй олонхын суудал авч, төрийн эрхийг дангаар барьж байх үедээ Үндсэн хуульд дордуулсан долоон өөрчлөлтийг оруулсан байдаг бөгөөд уг өөрчлөлт улс орны хөгжил, улс төр, нийгмийн амьдралд сөрөг муу нөлөө үзүүлсэн тухай шүүмжлэл өнгөрсөн хугацаанд тасраагүйтэй адил тухайн өөрчлөлтийг оруулах үед явагдсан хууль тогтоох байгууллагын хуулийн зөрчил бүхий үйл ажиллагаатай холбогдсон маргаан бас тасраагүй гэж хэлж болно. Тодотговол Улсын Их Хурал хууль болон тогтоол гаргаж байхаар заасан тухайн үеийн хуулийн тодорхой зохицуулалтыг зөрчиж, 2000 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хууль хэлбэрээр батлаагүйтэй холбогдон үүссэн маргаан Үндсэн хуулийн цэцийн хэмжээнд олон жил өрнөсөн байх бөгөөд үүний үр дүнд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль батлагдсан хэмээн дүгнэж болохоор байна.

2010 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан энэхүү Журмын тухай хууль нь зарим маргааныг бүрэн цэглэсэн. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдсон харилцаа, аливаа үйл ажиллагааг нэг бүрчлэн зохицуулсан чандлан мөрдвөл зохих хууль болсон. Тиймээс Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагааг энэ хуульд бүрэн нийцүүлж, хууль зүйн зөрчил маргаангүйгээр шийдвэрлэх нь зүй ёсны шаардлага болно. Харамсалтай нь Улсын Их Хурлын 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолоор батлагдсан ард нийтийн санал асуулгад оруулах Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эх нь Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн зохих шаардлагыг хангаагүй. Уг хуулийг илэрхий зөрчсөн байдалтай байна. Тухайлбал,

1. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4-т Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэр нь зөвхөн хууль байна гэж заасан бол тус хуулийн 6 дугаар зүйлийн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачлах, 7 дугаар зүйлийн Ерөнхийлөгч Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачлах, 8 дугаар зүйлийн Улсын Их

Хурлын гишүүн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачлах, 9 дүгээр зүйлийн Засгийн газар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачлах, 10 дугаар зүйлийн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тавих шаардлага, 11 дүгээр зүйлийн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэх зэрэг зохицуулалтууд нь бүхэлдээ Үндсэн хуульд зөвхөн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулна гэдгийг бататган, холбогдох харилцааг хоёрдмол утгагүйгээр туйлын тодорхой зохицуулжээ.

Хуулийн ийм тодорхой шаардлага, зохицуулалтуудыг Улсын Их Хурал илэрхий зөрчиж, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хууль хэлбэрээр хэлэлцэн шийдвэрлээгүй бөгөөд энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн. 70 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино гэсэнд огт нийцэхгүй байгаагаас гадна улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа болсон гол хуульд хууль зөрчсөн байдлаар өөрчлөлт оруулж, нийгмийн зөрчил, маргааныг улам дэвэргэх шалтгаан нэмж буй нь туйлаас зохимжгүй үйлдэл мөн гэж дүгнэж байна.

Түүнчлэн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад баримтлах ёстой гол хуулийг илэрхий зөрчсөн Улсын Их Хурлын энэхүү ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуульд байгуулалд халдсан хэрэг болох тул нийгэмд тодорхой томоохон эсэргүүцэл тэмцэл бий болгож, улс орныг бүхэлд нь хямрааж мэдэх эрсдэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт энэ хуулиас гадуур Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг завдах, хуйвалдаан оруулах аливаа үйлдлийг Монгол Улсын Үндсэн хуульд байгуулалд халдсан хэрэг гэж үзнэ гэж маш тодорхой заасныг Монгол Ардын нам, түүнээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд онцгойлон үзэж анхаарвал зохино.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4-т заасан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэр нь зөвхөн хууль байна гэсэн шаардлагыг зөрчсөн. Үүнээсээ улбаалан тухайн хуулийн олон зүйл, заалтыг мөн зөрчөөд байгаа Улсын Их Хурлын үйл ажиллагааг хуулиас гадуур үйлдэл гэж үзэхээс өөр аргагүй бөгөөд хууль ёсыг үгүйсгэсэн Үндсэн хуульд байгуулалд халдсан ийм үйл ажиллагаанд нийт ард түмнээ татан оролцуулахыг хүлээн зөвшөөрөх боломжгүй юмаа.

2.Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэр нь зөвхөн хууль байна гэсэн хуулийн шаардлагыг зөрчиж, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл өргөн мэдүүлсэн Д.Лүндээжанцан нарын гишүүд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4 дэх заалтаас гадна 6 дугаар зүйлийн 6.1, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг тус тус зөрчсөн бол хууль зүйн шаардлага хангаагүй төслийг хүлээн авч хэлэлцсэнээр Улсын Их Хурал мөн Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 10 дугаар зүйлийг зөрчсөн гэж үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 10 дугаар зүйл нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тавих шаардлагыг тогтоосон бол тус зүйлийн 10.1 дэх хэсэгт Улсын Их

Хуралд өргөн мэдүүлсэн төсөл нь дор дурдсан нийтлэг шаардлагыг хангасан байна.

10.1.1-д Үндсэн хуулийн зохих зүйл болон энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчимд бүрэн нийцэж байгаа буюу харшлаагүйг нотолсон тайлбар хавсаргасан байна гэж заасан байдаг. Мөн тухайн хуулийн 5 дугаар зүйл Улсын Их Хурал болон хууль санаачлагч Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагааны бүх үе шатанд 3 үндсэн зарчмыг баримтална. Эдгээр 3 зарчмын нэг нь Үндсэн хуулийг дээдлэн сахих, түүний тогтвортой байдлыг хамгаалах зарчим байна гэж заасан бөгөөд энэ зарчмыг Үндсэн хууль зөвхөн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг заавал хэрэгжүүлэхийг шаардсан 4 төрлийн арга замаар хангаж, хэрэгжүүлэхээр хуульчилсан.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдсон Улсын Их Хурлын үйл ажиллагааны хүрээнд хуулийн дараах, дээрх зарчим, шаардлагууд бүрэн зөрчигдөөд байна. Тиймээс төсөл өргөн мэдүүлэх, хүлээн авах болон хэлэлцэн шийдвэрлэхтэй холбогдсон Улсын Их Хурлын үйл ажиллагааг бүхэлд нь хууль бус буюу хууль бусаар явагдсан гэж дүгнэхээс өөр аргагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.1-д Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилга, үйл ажиллагаанд дур зоргын шинжтэй байж болохгүй гэж заажээ.

3. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачилж болно гэж заасан бол мөн хуулийн 10 дугаар зүйлээр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тавих шаардлагыг, 11 дүгээр зүйлд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэх журмыг тус тус хуульчлан тогтоожээ.

Хуулийн эдгээр зохицуулалт Үндсэн хууль зөвхөн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулна гэдгийг маргаангүй илэрхийлсэн бол ард нийтийн санал асуулгаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмыг тогтоосон Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 17 дугаар зүйл улам бататгасан байна. Тухайлбал тус хуулийн 17 дугаар зүйлийн 17.8 дахь хэсэгт Ард нийтийн санал асуулгад сонгогчдын нэрсийн жагсаалтад хууль ёсоор бичигдсэн нийт иргэдийн олонхи нь оролцож, тэдгээрийн олонхи нь уг хуулийг “зөвшөөрнө” гэж санал өгсөн бол Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль батлагдсанд тооцно. 17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсэгт Ард нийтийн санал асуулгаар батлагдсан хуулийг албажуулах, нийтлэх, хүчин төгөлдөр болсонд тооцох асуудлыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо зохион байгуулна. 17 дугаар зүйлийн 17.10 дахь хэсэгт Ард нийтийн санал асуулгаар батлагдсан хуульд Улсын Их Хурал ямар нэгэн засвар өөрчлөлт оруулах, Үндсэн хуулийн цэц хянан хэлэлцэхийг хориглоно гэж тус тус заасан.

Эдгээр зохицуулалтууд Ард нийтийн санал асуулгаар Улсын Их Хурал хэлэлцсэн хуулийн төслөө оруулж, дэмжигдсэн тохиолдолд тухайн төсөл нь хууль болон батлагдана гэдгийг тодорхой зааж байгаа бөгөөд Улсын Их Хурлын 2019 оны



9 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолоор батлагдсан Ард нийтийн санал асуулгад оруулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт эх нь хуулийн энэ тодорхой шаардлагыг огт хангасангүй ээ.

Ард нийтийн санал асуулгыг хууль зүйн ийм илэрхий зөрчилтэйгөөр явуулж, ард түмнээ хууль бус үйл ажиллагаанд татан оролцуулах нь Үндсэн хуулийн дархлааг үгүй хийх, хууль дээдлэх ёсыг устгах, улмаар улс орны аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх муу үр дагавартай тул зөвшөөрөх аргагүй юм.

4.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэгт Улсын Их Хурал хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр гаргах бөгөөд бусад шийдвэр нь тогтоолын хэлбэртэй байна гэж заасан. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4-н Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэр нь зөвхөн хууль байна гэсэн заалт зөрчигдсөнөөр хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэсэн Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, түүнчлэн дээр дурдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг тус тус зөрчигдсэн гэж үзэж байна.

5.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт Улсын Их Хурал энэ хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар хэлэлцээд тухайн нэмэлт, өөрчлөлтийг ард нийтийн санал асуулгаар оруулах нь зүйтэй гэж Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар тогтвол Үндсэн хуулийн Хорин тавдугаар дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дахь заалт, Жаран наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ард нийтийн санал асуулга явуулах тухай тогтоол гаргана гэж заажээ. Гэтэл Улсын Их Хурал 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолыг батлахдаа Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дахь заалтыг үндэслэхгүй орхиж, зөвхөн Жаран наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэсэн, мөн түүнчлэн Ард нийтийн санал асуулгын тухай хуулийг огт үндэслээгүй орхигдуулсан байгаа нь хууль зүйн зөрчилтэй төдийгүй цаашид гарах сөрөг үр дагавар ихтэй шийдвэр гэж үзэхээр өөр аргагүйд хүрч байна.

Ард нийтийн санал асуулгыг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 3 дугаар бүлгээс гадна Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн хүрээнд зохион байгуулж явуулах шаардлагатай гэдгийг "Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дахь заалт, 68 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Ард нийтийн санал асуулга явуулах тухай тогтоол гаргана." гэсэн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг бүрэн тодорхой илэрхийлсэн байна.

Иймд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон ард нийтийн санал асуулга явуулах үйл ажиллагааг хуульд нийцүүлэх шаардлагатай гэж үзэн Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын 2019 оны 9 дүгээр сарын 11-ний 73 дугаар тогтоолд бүхэлд нь хориг тавьж байна. Энэхүү хоригийг зохих хууль, журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ үү.

Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга. Танилцуулж дууслаа.

**Г.Занданшатар:** Одоо Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын эрхэм гишүүн Ганболд танилцуулна.

**Д.Ганболд:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр баталсан ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгч 2019 оны 9 сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан.

Хууль зүйн байнгын хороо 2019 оны 10 сарын 3-ны өдрийн хуралдаанаараа дээрх асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан журмын дагуу хэлэлцэж, гишүүд асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх буюу 66.7 хувь нь ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах боломжгүй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын эрхэм гишүүн Дондогдоржийн Эрдэнэбат танилцуулна.

**Д.Эрдэнэбат:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр баталсан ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Монгол Улсын Их Хурлын 73 дугаар тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгч 2019 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан болно.

Төрийн байгуулалтын байнгын хороо Ерөнхийлөгчийн хоригийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт заасны дагуу 2019 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Ерөнхийлөгчийн хоригийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Д.Эрдэнэбат нар Ерөнхийлөгчийн хоригтой холбогдуулан асуулт асууж, хариулт авсан болно. Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Лүндээжанцан Монгол Улсын Үндсэн хуулийн

68, 69 дүгээр зүйлд Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг нэрлэх асуудлыг тусгайлан тодорхой зааж өгсөн бөгөөд ингэхдээ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль гэсэн бичилт, ойлголт байхгүй. Харин Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт гэдэг нэр томъёоллоор бичигдсэн. Түүнчлэн 69 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн нэгэн адил хүчинтэй байна гэж маш тодорхой зааж өгсөн байна.

Мөн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль гэж нэрлэсэн тохиолдолд ердийн хуулиар, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар болж энэ нь Үндсэн хуулийн үзэл баримтлал, суурь зарчимд нийцэхгүй төдийгүй Улсын Их Хурал Үндсэн хуулийн дээр дурдсан зүйл, хэсэг заалтыг зөрчих нь хууль зүйн үр дагавар үүсэх эсэхээр үүсэхээр байсан. Харин Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэр нь зөвхөн хуульд байх, хуулийн шаардлага хангасан талаар түүнчлэн Улсын Их Хурлын 73 дугаар тогтоолыг батлахдаа Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэсэн бөгөөд Хууль тогтоомжийн тухай хууль, бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг иш татах, хуулийн заалтыг давтахгүй байх гэж заасны дагуу тогтоолын үндэслэл хэсэгт хуулийн утга агуулгыг давхардуулалгүйгээр Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн хуулийн зөрчил гэж үзэх үндэслэлгүй. Ерөнхийлөгч Улсын Их Хурлын 73 дугаар тогтоолд бүхэлд нь хориг тавьсан, тавьсан хоригийг үндэслэлдээ үндэслэлийг дурдсан бөгөөд Улсын Их Хурал Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах, Ард нийтийн санал асуулга явуулахаар тогтохдоо Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд заасан бүхий л зарчим шаардлагын хүрээнд боловсруулж хэлэлцүүлсэн тул эдгээр үндэслэлийг бүхэлд нь хүлээн зөвшөөрөх боломжгүй талаар байр сууриа илэрхийлсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах нь зүйтэй, ард нийтийн санал асуулга явуулахад олон нийтэд тайлбарлан таниулахад ч, зохион байгуулахад ч цаг хугацааны хувьд боломжгүй болсон тул Улсын Их Хурал өөрөө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Хаянхярваа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн болон Ерөнхийлөгчийн хоригийг Хууль зүйн үндэслэлийг сайтар нягтлан үзэх, хамгийн гол асуудал нь хууль зүйн зөрчилгүй, үндэслэлтэй байхад анхаарах.

Ерөнхийлөгчийн хоригийг дэмжих боломжгүй талаар. Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат Үндсэн хууль бол нийгмийн гэрээ гэдэг утгаар нь Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авч төслийн хэлэлцүүлгийг дахин хийж, Үндсэн хуульд орхигдсон тусгах шаардлагатай зарим зохицуулалтыг нэмж тусгах боломжийг ашиглах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Ерөнхийлөгч 73 дугаар тогтоолд бүхэлд нь хориг тавьсан нь тогтоолын хавсралтаар баталсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг хүчингүй болгох түүнчлэн сүүлийн 10 жилийн судалгаа, ажлыг бүхэлд нь зогсоох эрсдэлтэй байгааг анхаарах.

Иймд Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах боломжгүй талаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат ард нийтийн санал асуулга явуулах хугацаа болон хуулийн зохицуулалтын хооронд зөрчил гаргахгүй байх, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлын агуулга, үйл явц, олон нийтэд хууль зүйн эргэлзээ төрүүлэхээргүй, улс орны нийгэм, эдийн засагт саад дарамт учруулахааргүй, ирээдүйн Монгол Улсын сайн сайханд чиглэгдсэн байх үүднээс нийтийн зөвшилцлийг хангах нь зүйтэй талаар саналаа илэрхийлцгээсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Улсын Их Хурал 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг баталсан бөгөөд уг нэмэлт, өөрчлөлт өнөөдрийг хүртэл 19 жилийн турш хүчин төгөлдөр үйлчилж байгаа түүнчлэн үе үеийн Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд өргөн мэдүүлж байсан төслүүд нэрийн хувьд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл нэртэй байсан. Мөн ард нийтийн санал асуулга явуулах хугацааны талаар товч мэдээлэл хийсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг хүлээн авахыг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 38.5 хувь нь дэмжсэн тул Ерөнхийлөгчийн хоригийг Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулан та бүхэнд хүргэлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийн талаар тус Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн Ерөнхийлөгчийн хоригийн тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Ерөнхийлөгчийн хориг болон Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байвал нэрээ бүртгүүлнэ үү. Хурууны хээгээр биш кнопоор. Батзандан гишүүнээр тасаллаа. Эрхэм гишүүн Хишгээгийн Нямбаатар асуулт асууна.

**Х.Нямбаатар:** Би бол их харамсаж байна. Энэ маш удаан хугацаанд, олон хүний хүч хөдөлмөрөөр Үндсэн хуулийн өөрчлөлтийг хийх ажил явж байгаад энд хүрээд ингээд зогсож байх шиг байна. Энд бас манай намын хэсэг бүлэг нөхдүүд сөрөг хүчинтэй хуйвалдаж энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг энд хүрээд ингээд оршуулахаар төлөвлөсөн гэж би ойлгож байгаа. Би Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Бямбацогтоос нэг хэдэн асуулт асууя.

Ард нийтийн санал асуулга явуулъя гэдэг санаачилгыг Улсын Их Хуралд суудалтай аль намаас анх энэ санаачилга гарсан юм. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Зандаахүүгийн Энхболдоос би бас асууя. Монгол Улсын Үндсэн хуульд 68 дугаар зүйл, 69 дүгээр зүйлд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндсэн суурь зохицуулалтыг хийсэн. Энд Үндсэн хуулийн өөрчлөлт гэдэг нэр томъёогоор явж байгаа. 2010 онд батлагдсан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулиар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл гэсэн ийм 2 хуулийн зөрчил үүссэн. Хууль зүйн шинжлэх ухаанд зөрчил үүссэн тохиолдолд Үндсэн хуулиа барьдаг ийм тогтсон журамтай. Хэрэв 62-ын бүлэг анх Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл гээд ороод ирсэн бол яг өнөөдрийн хавх яг л адилхан байсан. 7 дугаар сарын 16-ны өдөр та Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндсэн хуульд оруулах төсөл санал гэсэн ийм бичгийг ирүүлж байсан. Өөрөөр хэлбэл өнөөдрийн тавьж байгаа хоригийнхоо яг эсрэг утгатай ийм саналыг ирүүлж байсан. Би энд нэг хүнд маш их харамсаж байгаа. Бид 6 сараас хойш тасралтгүй энэ дээр суусан. Энэ 6 сараас биш бүр 2 жилийн өмнөөс энэ ажил эхлээд судалгаа хийгдээд, хэлэлцүүлэг зохион байгуулаад явсан. 6 сард Үндсэн хуулийг хэлэлцэж эхлээд Хууль зүйн сайд Нямдорж сайд бүлэгт байнга

өөрийн зөвлөгөөг өгч, МАН-ын бүлэг Нямдорж сайдын хэлсэн болгоноор бүлгийн шийдвэрийг гаргаж явсан.

Үндсэн хуулийг сөрөг хүчинтэйгээ ард түмнээр сонгогдсон Ерөнхийлөгчтэйгөө зөвшилцөж явахгүй бол болдоггүй баримт бичиг шүү залуучуудаа гэж бидэнд хэлээд, бид Ерөнхийлөгчөөс саналыг нь авч, АН-ын зөвлөлөөс саналыг авъя гэдэг ийм шийдвэрт хүрсэн. Зөвшилцөх санал комисст Нямдорж сайд орж ажилласан. Зөвшилцлөө гээд зөвшилцлийн саналуудаа оруулж ирж бидэнд танилцуулсан. Төд удалгүй зөвшилцлөөсөө өөрөө энэ зөвшилцлийг ерөөсөө хүлээж авахгүй ээ гээд дараагийн бүлгийн хурал дээр санал хэлээд, санал хураалгаж өөрийнхөө талд шийдүүлсэн. Одоо болохоор ард нийтийн санал асуулгаар энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг явуулах шаардлагагүй ээ. Ерөнхийлөгчийн хоригийг авах ёстой гэсэн ийм агуулгаар асуудалд хандаад байгаад туйлын харамсаж байна. Энэ Үндсэн хуулийн өөрчлөлт засаглалыг тогтвортой байлгах, өрийг Улсын Их Хурал дур зоргоороо нэмэгдүүлэхгүй байх, шүүх эрх мэдлийг улс төрөөс салгах, хараат бус болгох, Ерөнхийлөгчийн эрх хэмжээг хязгаарлах гээд энэ 27 жилийн хугацаанд бидний энэ алдсан алдаа ононд дүн шинжилгээ хийсэн 34 ийм том зүйл, заалт байсан. Энэ өөрчлөлтийг эсэргүүцэж байгаа би хүмүүст энэ номыг нэг харуулмаар байгаа юм. Энэ 27 жилд Монголын ард түмэн супермаркетаас илүүг хүссэн шүү. Супермаркетаас илүү хүссэн. Яг энэнтэйгээ бахь байдгаараа явбал сонирхол өнөөдөр энд байна.

**Г.Занданшатар:** Энэ асуулт шүү дээ тиймээ. Төрийн байгуулалтын байнгын хороо нь Бямбацогт дарга асуултад хариульъя.

**С.Бямбацогт:** Нямбаатар гишүүний асуултад хариульъя. Ард нийтийн санал асуулгаар Үндсэн хуулийг баталъя гэсэн санаачилгыг хэн гаргасан бэ гэсэн асуулт асуусан. Тэгээд 2016 онд МАН сонгуульд мөрийн хөтөлбөр дэвшүүлж оролцсон. Одоо төрөө засах, ард түмнээ ядуурлаас гаргах, төр шиг төртэй болох, улс шиг улстай болох энэ асуудлыг бид нар шийднэ. Энийг шийдэхдээ бид нар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийнэ. Хийхдээ ард түмнээсээ асууж байж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийнэ гэсэн МАН-ын мөрийн хөтөлбөр дэвшүүлсэн. МАН Улсын Их Хуралд 65 суудал авсан. Засгийн газраа байгуулсан. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт яг энэ заалт, энэ амлалт бол яг энэ чигээрээ туссан. Өөрөөр хэлэх юм бол ард түмнээсээ асууж байж, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийнэ гэдэг заалт туссан.

Үүний дагуу 2016 оноос хойш Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулж, Лүндээжанцан гишүүнээр ахлуулж, бүтэн 2 жил гаруй хугацаанд ажилласан. Олон нийтийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан. Зөвлөлдөх санал асуулга зохион байгуулсан. Нийтдээ ард иргэдийн дунд 5 сая 700 орчим мянган саналыг цуглуулсан. Ингэж байж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг Улсын Их Хуралд 2019 оны 6 сард өргөн барьсан. Улсын Их Хурлын 62 гишүүн. Лүндээжанцан нарын тэргүүтэй. Энэ 62 гишүүний өргөн барьсан төслийг Улсын Их Хурал хэлэлцээд ард түмнээр бас хэлэлцүүлээд, хоёр дахь хэлэлцүүлгийн явцад өөрөөр хэлэх юм бол хоёр дахь хэлэлцүүлгийн явцад АН-аас, АН-ын бүлгийн дарга Эрдэнэбат гишүүн бланкан дээрээ ард нийтийн санал асуулга явуулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна. Үүнийг одоо Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өг өө. Та бүхэн 2016 онд сонгуульд ялахдаа ард түмнээсээ асууж байж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батална гэсэн энэ амлалтаа биелүүлээ гэдэг шаардлага тавьсан.

Нэг талаасаа бас сөрөг хүчин Улсын Их Хуралд сөрөг хүчин Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэлэлцүүлэгт оролцох явцдаа ард түмнээсээ асууж байж баталъя Үндсэн хуулиа гэсэн шаардлага, саналыг тавьсан. Нөгөө талаасаа Улсын Их Хурлын гишүүд бас 62 гишүүнээс чуулганы хуралдаанд оролцоод 94.8 хувь буюу одоо 3-ны 2-оос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулгыг улс орон даяар явуулъя гэсэн тогтоолыг баталсан. Өөрөөр хэлэх юм бол энэ бол МАН-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрөө биелүүлж байгаа хэлбэр. Нөгөө талаасаа бас Улсын Их Хуралд сөрөг хүчин АН-ын бас тавьсан шаардлага, санал хүсэлтийг хүлээж авч ийм одоо хоёр талаасаа харилцан ярилцаж байж ард нийтийн санал асуулга явуулахаар ийм тогтоолыг баталсан.

Тогтоолын нэг дэх заалт нь бол ард нийтийн санал асуулга явуулъя. Хоёр дахь заалт нь бол ард нийтийн санал асуулгад оруулах Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг хавсралтаар баталсугай гэсэн ийм хоёр заалттай тогтоол л доо. Энэ дээр хориг тавигдсан. Хориг тавигдсан үндэслэлийн тухайд бол хууль зүйн үндэслэл байхгүй ээ. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2000, 1999 оны 12 сард сард хэлэлцэж эхлэхээс авхуулаад 2000 онд хэлэлцэж байсан, дараа нь 2000 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах өөрчлөлт оруулах журмын тухай хууль батлагдсан. Энэ хууль батлагдсанаас хойш 2015 оны 12 сард Улсын Их Хурлын дарга З.Энхболд дарга одоо Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Их Хурлын дарга байхдаа Батбаяр нарын гишүүд, Баттулга Ерөнхийлөгч Их Хурлын гишүүн байхдаа бас гарын үсэг зурж өөрчлөлтөө өргөн мэдүүлсэн. Энд бас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг Их Хуралд өргөн мэдүүлж байсан.

Мөн одоо Лүндээжанцан нарын 62 гишүүн бас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг Их Хуралд өргөн мэдүүлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгч ч гэсэн 7 сарын 16-нд 2019 оны Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Их Хуралд өргөн мэдүүлсэн. Ингээд аваад үзэх юм бол энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал дандаа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл хэлбэрээр Их Хуралд өргөн мэдүүлэгдэж, Үндсэн хууль.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Энхболд дарга асуултад хариулна. Байнгын хороод Ерөнхийлөгчийн хоригтой холбогдуулж асуулт асууж, хариулт авна.

**З.Энхболд:** Нямбаатар гишүүний асуултад хариулъя. 1999 онд Улсын Их Хурал Үндсэн хуульд одоо дордуулсан долоо гэж хоч авах хүртлээ явсан энэ 7 өөрчлөлтийг хийсэн л дээ. Тэгээд түүнээс хойш Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт хийхдээ дур зоргоороо хандаж болохгүй юм байна. Ийм ийм зүйлийг зайлшгүй харгалзаж үзэж ёстой гээд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль 2010 оны 12 сарын 23-нд баталж гаргаад, тэгээд Ерөнхийлөгч бол тэр хуульд нийцүүлж тухайлбал 11.3.4-т чуулганаар урьдчилан тогтсон зөвхөн нэг төсөл хэлэлцэнэ. Өөр өөр үзэл баримтлалаа хоёр буюу хэд хэдэн төслийг саналын төсөлд харгалзаж үзэж болох ба харин бие даасан байдлаар зэрэгцүүлэн хэлэлцэхийг хориглоно гэдэг заалтын дагуу хэлэлцэж байгаа хуулийн төсөлд хажуугийн санал оруулсан болохоос бие даасан хуулийн төсөл эсвэл нэмэлт, өөрчлөлтийн төсөл бол өргөн бариагүй ээ. Тийм учраас энийг төсөл санал гээд хоёр үгээр нэрлэсэн байгаа.

Одоо 2000 оны 1999 оны өөрчлөлтийг тэр жил нь Үндсэн хуулийн цэц хүчингүй болгоод, дараа жил нь Улсын Их Хурал өөрөө батлаад, түүнээс хойш одоо энэ маргаан тасрахгүй байгаа юм л даа. Тэгээд энэ нэг ийм хууль гаргаад, энийгээ мөрдөөд, хэрвээ Улсын Их Хурал дараагийн өөрчлөлтийг оруулах бол мөрд гээд гаргачихсан хуулиа одоо доод хүчин чадалтай, тийм хүчин чадалтай гэж ярилгүйгээр хэрвээ энэ хууль болохгүй байвал энийгээ эхлээд цэгцэлж, ойлгомжтой болгоод, Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийг хийх боломж Улсын Их Хуралд байсан, гишүүдэд байсан. Тэрийгээ хийлгүйгээр одоо хавх гэнэ үү, юу гэнэ вэ ингээд нэр хоч өгөөд байх нь бол буруу л даа.

Тэгээд Ерөнхийлөгч бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжиж байгаа. Тэгэхдээ энэ процессынхоо хуулийг зөрчөөд баталж байгаа чинь энэ нэмэлт, өөрчлөлтийг чинь хүчингүй болгоход хүргэх нь байна шүү. Эцэслэж батлахаасаа өмнө энэ алдаагаа засчихна уу. Нийлээд одоогийн Улсын Их Хурлаас энэ текстээс өөрөөр нэмэлт, өөрчлөлт орох боломжгүй юм байна гэдэг бодит байдлаа бол хүлээн зөвшөөрөөд, Улсын Их Хуралд тус болох гээд тэр нэг нэмэлт, өөрчлөлтийг нь явчхаасай гээд ийм хориг тавьж байгаа. Тэрнээс одоо нэмэлт, өөрчлөлтийн текст буруу байна, тэрэн дотор ийм юм таалагдахгүй байна, энийгээ зас, миний тэр санал орсонгүй. Тэрийг заавал оруул гэдэг юм огт яриагүй. Сая миний уншсан 4 хуудас цааснаас бол харагдаж байгаа.

Тэгэхээр Улсын Их Хурал бол одоо процессын хууль зөрчсөн зөрчилтэйгөө цаашаагаа эцэслэн батлаад Цэц дээр очиж унах алдаанд орох уу, эсвэл энэ дээр тормозоо татаад, ямар ч байсан энэ Журмын тухай хуулиа нэг бол мөрдье эсвэл өөрчлөлт оруулаад, өөрчлөлт оруулсан хуулийнхаа дагуу саяын тогтсон текстээ батлаад хурдан шуурхай гарах боломж бас байгаа. Тэгээд саяын тогтсон текст бол ямар ч гэсэн нэг сүүлийн 2 жил нэлээн олон зуун сая төгрөг зарсны үр дүнд гарсан олон хүний хөдөлмөр учраас хүндэтгэх ёстой гэдэг ийм байр суурьтай байгаа юмаа. Болсон.

**Г.Занданшатар:** Нямдорж сайд үгэн дээрээ саналаа хэлчих. Асуултад Ерөнхийлөгчийн Тамгын газар, Байнгын хороо хоёр л хариулах болчихоод байна. Нэр чинь байна. Нэрийг чинь оруулчихсан. За С.Эрдэнэ гишүүн асуулт асууна.

**С.Эрдэнэ:** Баярлалаа. Би бас Нямбаатар гишүүнтэй адилхан туйлын их харамсаж байна. Үнэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага зүй ёсоор байгаа юу гэвэл байгаа. Өнөөдөр бас энэ хууль батлагдаад 20 гаруй жил хэрэгжээд яваад ирсэн. Энэ хууль нь мэдээж төгс төгөлдөр гэж юм байхгүй. Тэгэхээр хуульд бол удирдах төвийн одоо нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага ч гардаг, тодорхой урт, богино хугацааны дараа ч гэсэн оруулах шаардлагууд гардаг л даа. Өнөөдөр энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагын асуудлыг ярьж байгаа гишүүдийг хараад байхад жишээ нь Нямбаатар гишүүн, Бямбацогт гишүүн эд нар нэг намын нэг одоо тухайн намын өөрийн эрх ашгийн үүднээс юм ярьж байгаа юм шиг юм яриад байх юм. Энэ Үндсэн хууль гэдэг чинь уг нь Монгол Улсын нийт ард түмний эрх ашгийн асуудал болохоос аль нэг эрх барьж байгаа МАН-ын асуудал биш шүү дээ. Тэгээд одоо нэг 2016 онд сонгуулийн мөрийн хөтөлбөрт оруулсан тэр амлалтаа хэрэгжүүлэх үүднээс энэ одоо Үндсэн хуулийн өөрчлөлтийг оруулж байгаа юм шиг юм яриад байх юм. Тэгээд тэрийгээ хэрэгжүүлэхийн тулд юу ч хийсэн яадаг юм гэсэн утга санаатай юм л манай Бямбацогт яриад байна л даа. Би бол ийм хариуцлагагүй байж болохгүй ээ гэж хэлмээр байгаа юм нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Нямбаатар гишүүн их сөрөг хүчин өөрийнхөө намын одоо танай олонхын намын нэг хэдэн нөхдүүдтэй хуйвалдаад, зохион байгуулалттай Үндсэн хуулийг унагаад байгаа юм шиг юм яриад байх юм. Та нар өөрсдөө л унагаасан шүү дээ. Анхнаасаа л Үндсэн хуулийн анхны хэлэлцүүлэг яваад эхлэхэд чинь АН-аас шаардлага тавьсан. Энэ Үндсэн хуулийн хэлэлцүүлэг чинь хууль бус эхэлж байна шүү. Үндсэн хуулийн хэлэлцүүлэг чинь өөрөө Үндсэн хууль зөрчсөн байдлаар эхэлж байна. Энийгээ зогсоо, боль оо. Наадахаа тэр ард түмнээсээ асуу. Танай мөрийн хөтөлбөрт байгаа. Өнгөрсөн хойно нөгөө ниргэсэн хойно хашхирав гэдэг шиг юм болчих вий гэдэг анхааруулгыг бид нар удаа дараа өгсөн. Харамсалтай нь үнэмлэхүй олонхдоо эрдээд л хүч түрээд явсан шүү дээ тэгээд. Тэгээд одоо өнөөдөр болохоор ингээд нэг сөрөг хүчин хамаг юмыг нь гацаачихсан юм шиг. Та нар манайхтай, манайхгүй угаасаа шийдээд явах бүрэн эрх чинь та нарт хангалттай л байгаа шүү дээ. Ард түмэн танай намд бол хангалттай санал өгсөн. Тэгээд одоо энэ бүрэн боломжтой хүч чадалтай нам тэгээд ямар нэгэн юм болохгүй болохоор л сөрөг хүчин рүүгээ аваачиж хамаг муу муухайгаа чихчхээд суугаад байж болохгүй л дээ.

Тэгэхээр би бол өнөөдөр энэ анх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж эхлэхээс эхлээд та нар зөвлөлдөх санал асуулга гээд хуульд байхгүй зүйл гаргаж ирээд, баахан аймаг, орон нутгийн өөрсдөө томилсон төрийн албан хаагчдын дунд зөвлөлдөх санал асуулга нэртэй баахан юмнууд зохион байгуулалттай явуулсан. Тэгээд өнөөдөр оруулж ирээд одоо Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн чинь хоёр дахь төсөл, хоёрдугаар төсөл ямар юм болчихоод байж байгаа билээ. Та нар өөрсдөө мэдэж байгаа шүү дээ. Жинхэнэ холион бантан болсон шүү дээ. Анхны тэр, Лүндээжанцан гишүүдийн оруулж ирсэн 62 гишүүний оруулж ирсэн төсөл чинь тэр төслийнхөө мөн чанарыг алдаад, одоо бол мэдэхгүй одоо ерөөсөө будаг шунх нь холилдоод юу ч болчихсон юм бүү мэд нэг ийм бантан шиг л юм болчихсон байгаа шүү дээ. Ийм юмыг тэгээд өнөөдөр Их Хурлаар батлах боломжгүй байдал үүсэнгүүт л ард нийтийн санал асуулгаар батлуулах ийм л заль хэрэглэж байгаа шүү дээ. Тэгээд ард нийтийн санал асуулгаар баталсан гэдэг юмыг дараа нь ярих гэж байгаа байхгүй юу. Хариуцлагаас зугатаагаад дараа нь юу гэж хэлэх гэж байгаа вэ гэхээр ард түмэн л баталсан шүү дээ. Та нар сонгогчид өөрсдөө баталсан биз дээ. Бид нар батлаагүй шүү дээ гэж хэлэх гэж байгаа байхгүй юу.

Ийм улс төрийн явуургүй заль хэрэглэдгээ боль оо. Одоо би бол өнөөдөр шулуухан хэлэхэд бол Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг хүлээж аваад, харин энэ хоригоор тавьсан гарч байгаа боломжийг ашиглаад, Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийн алдаа завхралыг засаад явбал илүү оновчтой байх байхаа л гэсэн ийм саналыг хэлмээр байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Бямбацогт дарга.

**С.Бямбацогт:** Асуултад хариулна гэсэн байгаа л даа Дэгийн хуулиараа. Тэгээд асуултад хариулъя. Тэгэхээр сөрөг хүчин маань бас гацаахын тулд гацаадаг, муу хэлэхийн тулд муу хэлдэг. Зүгээр л ерөөсөө нэг үгүйсгэхийн тулд үгүйсгэдэг байх жаахан зохимжгүй л дээ. Тэгээд таны гарын үсэг зурсан 2015 онд гарын үсэг зурж өргөн барьсан 47 гишүүний дотор өргөн барьсан үзэл баримтлал, зүйл заалтыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийе гэсэн санаа бол 62 гишүүний төсөл бол бүрэн байсан. Одоо ч гэсэн бас 80, 90 хувь нь хадгалагдаад байж байгаа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг зөвхөн одоо энэ удаагийн парламент ярьж байгаа юм биш та бидний одоо сүүлийн 3, 4 жил



дамжсан парламент ярьж байгаа. 2010 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд оруулах Журмын тухай хууль батлагдсанаас хойш Их Хурлын нэр бүхий гишүүд Дамба-Очир, Сүхбаатар нараас авхуулаад та бид нар тэгээд одоо ингээд 62 гишүүн гээд 3 парламент дамжиж яригдаад, энэ төрийн одоо алдаа завхрал, төрийн одоо гажуудал, энэ хаана байна энэ Үндсэн хуульдаа байгаа юм байна. Тийм болохоор Үндсэн хуулиа засъя гэдэг асуудлыг та эх барьж байх олонх байх үедээ ч ярьж байсан. Таны олонх байх үедээ ярьж байсан зүйлийг бид нар бас үргэлжлүүлж авч яваад, гарцаа байхгүй засах шийдэх ёстой асуудал учраас шийдье гээд л явж байгаа, ингээд явж байгаа.

Ганцхан одоо яг шийдье гээд явж байсан зүйл, заалт, үзэл баримтлал нь хэвээрээ явж байхад зөвхөн одоо бидний ярьж байсан, миний бодож байсан зүйл, заалтууд тусгагдсангүй гэдэг байдлаар одоо мушгиж гуйвуулж, харлуулж, гүтгэж ярих хэрэггүй л дээ. Яах аргагүй одоо АН-ын нөхдүүд маань бол холимог тогтолцоо, намын жагсаалтаар сонгодог болох асуудлыг оруулаач ээ гэсэн асуудал эхнээсээ ярьсан. 76 гишүүнийг 108 болгоё гэдэг асуудал ярьсан. Ерөнхийлөгчийг парламентаас сонгодог больё гэсэн асуудал ярьсан. Яах аргагүй энэ ярьсан асуудлууд нь удаа дараа бичгээр өгсөн асуудал л даа. Бүгд надад энэ бичгүүд нь энд байж байна тийм. Бүгдэнг нь би үзүүлж болно бас тийм. Ингээд ярьсан. Ярьсан асуудлуудыг нь бид нар үнэхээр оруулах гээд зүтгээд чадаагүй, бас зөвшилцөөд ойлголцоод чадаагүй. Тэгээд яах аргагүй одоо юу гэдэг юм ард түмэн дэмжихгүй байгаа. Холимог тогтолцоо, намын жагсаалтаар сонгогдохыг ард түмэн дэмжихгүй байна. Их Хурлын гишүүдийн тоог нэмэхийг дэмжихгүй байна. Их Хурлын гишүүд 4 жилийг, 5 жилийг дэмжихгүй байна. Тийм учраас бид нар өөрчлөлтөө хийж чадахгүй л явж байна. Ингээд явсан юмыг одоо бидний хүсэж байсан зүйл, заалтыг оруулсангүй гэдэг байдлаар мушгиж гуйвуулж ярьдаг энэ нь жаахан зохимжгүй байна тийм.

Дээрээс нь одоо бичиг юу нь байж байна шүү дээ одоо энд. Ард нийтийн санал асуулгаар явуулаа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг. Одоо ингээд явчихлаа. Бид нар оролцлоо, бидний саналыг аваагүй ч гэсэн та бүхэн ард нийтийн санал асуулга явуулаа гэсэн бичгүүд чинь байж байна бүгдээрээ. Ингээд байж байхад ард нийтийн санал асуулгаар явуулъя гэхэд нь үгүй ээ, одоо наадах чинь ёстой болохоо больчихсон. Тийм болохоор ард нийтийн санал асуулгаа битгий явуулаа гэдэг байдлаар битгий мушгиж яриа ч ээ. Бас байгаа юмыг байгаагаар нь яриа ч ээ. Тантай бас зөвшилцье гээд зөндөө л юм болсон. Одоо тэгээд харамсалтай нь ийм л байдалтай болчихоод байж байна. Та улс төр хийж болдог, би хийж болдоггүй юм уу. Харин ч бас жаахан даруухан байна шүү би бас тиймээ.

**Г.Занданшатар:** За одоо эрхэм гишүүн Цэндийн Нямдорж гишүүн асуулт асууна, үг хэлнэ.

**Ц.Нямдорж:** Би нэг тайлбар хийх ёстой юм болов уу гэж бодож байна л даа. Би энэ Үндсэн хуулийн тэр 62 гишүүний бичигт гарын үсэг зурсан нь үнэн. Тэр үед бол энэ санаачилж байгаа, голлож ажиллаж байгаа хүмүүс нь энийг аваад гарах юм байлгүй дээ гэж бодоод би нэг их идэвхтэй оролцоогүй нь бас үнэн. Тэгээд зөвшилцлийн хаалга хаагдсан. АН-ын Их Хуралд суудалтай оролцоогүйгээр, Ерөнхийлөгчийн оролцоогүйгээр шийдвэр гаргах гэж яваад түгжээнд орсон учраас энэ зөвшилцлийн замаар явуулах ёстой байдаг анхны байр сууриа хатуу баримталж ажилласан. Би өөрөө хүсээгүй байхад намайг тэр зөвшилцлийн ажлын хэсэгт оруулсан. Одоо ч гэсэн эсэргүүцээр байхад хоёр дахь ажлын хэсэгт намайг

оруулчихаад байж байгаа. Тэгээд тэр зөвшилцлийн явцад чинь бол Энхтүвшин дарга байсан, Бямбацогт байсан, Эрдэнээ дарга, Эрдэнэбат, Батзандан гишүүд байсан. Хоёр, гурван асуудлаар Их Хурлын олонхын бүлэг дээр оруулаад хэлэлцүүлээд үзье гэж тохирсон юмаа. Одоо өөд өөдөөсөө хараад сууж байна.

108 байсан. 5 жил байсан. Ашигт малтмалын асуудал байсан. Тэрэн дээр 108-аар батлуулна гэж тохиролцоогүй, унагана гэж тохиролцоогүй. Бүлэг дээр оруулаад хэлэлцүүлээд үзье гэж тохирсон юмаа. Тэгээд бүлэг дээр ирсэн чинь тэр 108, 5 жил унасан. Холимог тогтолцоо унасан. Тэр ашигт малтмалтай холбоотой асуудал дээр нэг юм болсон. Ингэж л явсан шүү дээ.

Тэр 108, 5 жил хоёрыг чинь ард түмэн эсэргүүцээд байсан учраас өөрснөө тэр дэмжиж байсан гишүүд нь ер нь болохгүй юм байна гэж үзээд бүлгийн хурал дээр яриад байхгүй болгосон шүү дээ. Одоо энийг надтай холбоод байх шаардлагагүй л дээ. Зөвшилцлийн ажил одоо хүртэл үргэлжилж байна. Үргэлжилж байгаа учраас Ерөнхийлөгч хориг тавьчихаад хоригийг хүлээж аваад энэ Их Хурлаар хоёрдугаар хэлэлцүүлгээр дэмжигдсэн асуудлыг Их Хурлынхаа журмаар хэлэлцээд явах юм бол цаашаа хориг элдэв эсэргүүцэл байхгүй гэдгээ хэлсэн. Тэрийгээ Байнгын хороон дээр Энхболд дарга өчигдөр хоёр, гурван удаа илэрхийлж хэлсэн шүү дээ. АН бас болсон болоогүй энэ зөвшилцье гээд бичиг ирүүлчихсэн байгаа шүү дээ. Энэ буруу юу. Ийм хэрэг явдал болсон. Энийгээ зөв ойлгох талаас нь би тайлбар хэлж байгаа. Нэг юман дээр би хатуу зогсож байгаа. Энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг Ерөнхийлөгч, Их Хуралд суудалтай Ардчилсан намын оролцоогүйгээр шийдвэрлэж огт болохгүй. Улс төрийн тогтворгүй байдал үүснэ. Тэр тогтворгүй байдлыг нь төр даахгүй. Энэ намуудын чинь цаана сонгосон хүмүүс нь байдаг. Энэ Ерөнхийлөгчийн цаана сонгосон дэмжигчид нь байдаг. Ийм оролцоогүй Үндсэн хуулийн өөрчлөлт цаашдаа ямар ч засгийн үед, ямар ч намын эрх мэдлийн үед шийдвэрлэх бололцоо байхгүй. Энийг л би харсан юм байгаа юм.

Бас Хууль зүй, дотоод хэргийн сайд байвал надад хүлээсэн үүрэг байна. Энэ 3 сая ард түмнийг гудамжинд гаргачихгүй, амгалан байдлыг нь сахих үүргийг цагдаа хариуцдаг юм. Би энийгээ бас давхар бодож байгаа, бодож байгаа. Зөвхөн би биш энд сууж байгаа бүх гишүүд миний, чиний энэ тэр нам гэж хэлэлгүй энэ амгалан байдлын нь баталгааг хангаж өгөх ёстой юмаа. Энийгээ бодоорой. Тэрнээс би хүчлээд алтан загасны эмгэн шиг.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Одоо Батнасан гишүүн асуулт асууна.

**О.Батнасан:** Баярлалаа. Үндсэн хууль бол нийгмийн олон талт оролцоог хангаж оролцуулна, зөвшилцөнө гэдэг нь зөв л дөө. Гэхдээ одоо энэ чинь цастай байхад эхлээд цэцэг хагдраад дууслаа шүү дээ тэгээд. Зунжингаа л зөвшилцөнө гээд явцгаалаа шүү дээ. Тэгээд одоо дээрдсэн юм байхгүй байна. 108 болгосонгүй гишүүдийн тоог, холимог тогтолцоог оруулсангүй гэж одоо үрчийгээд уурлаад урвайгаад ажил хойшоо татаад байх юм байхгүй шүү дээ. Энэ ард түмнээрээ хэлэлцүүлчихнэ л гэж байгаа юм. Ард нийтийн санал асуулгын тухай хуульд ерөөсөө 2 зүйл байгаа юм. Их Хурал бол ард нийтийн санал асуулгыг явуулах тухай эхлээд шийдвэр гаргана. Гаргасан шийдвэрийн дараа хугацаагийн нь товлон зарлана гэсэн ийм л зүйл байгаа юм. Одоо хугацааг товлон зарлана. Үнэхээр тэр 30, 40 тэрбум гараад байгаа одоо өвөл хэцүү, хүйтэн нойтон болно, чирэгдэл ард түмэнд учирна гэж бодож байгаа бол ирэх жилийн Улсын Их Хурлын сонгуультай энэ ард нийтийн санал асуулга явуулж болно, болохгүй юм байхгүй ээ.

Ер нь бол хоёр зам л байгаа. Бид нэг бол ард түмнээсээ асууна, нэг бол гуравдугаар хэлэлцүүлэгт ороод Ерөнхийлөгчөөр батлуулах, ёсчлох. Ёсолно гэдэг нь батална гэсэн үг л гэж ойлгож байгаа. Нэг бол ард түмнээсээ бид одоо асуугаад явъя, дэмжвэл тэр, дэмжихгүй бол одоо яах вэ тэгээд одоо энэ Үндсэн хууль 8 жил хэлэлцэхгүй байдаг юм байгаа биз нэмэлт, өөрчлөлт. Үгүй бол Ерөнхийлөгчөөр ард түмнээс сонгогдсон Ерөнхийлөгчөөрөө дэмжүүлээд явах гэсэн ийм л зүйл байгаа юм. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд буруутай юм юу байгаа юм бэ. Байгалийн баялагтай холбоотой, ялангуяа стратегийн ордуудтай холбоотой. Үндэсний баялгийн сан байгуулья гэж байна. Стратегийн ордуудынхаа дийлэнх олонх буюу 50+1 энэ үр өгөөжийг нь баялгийн сандаа төвлөрүүлж гэж байна. Дээр нь одоо хуулийг чанартай, чанаргүй баталдаг ярьж байна. Нийт гишүүдийн олонхоор буюу 39 гишүүн сууж байж хуулиа баталдаг болъё. Нийт гишүүдийн олонх буюу 39 гишүүн байж байж Засгийн газраа огцруулдаг болъё. 40 гишүүн сууж байгаад 21 гишүүн Засгийн газраа огцруулдаг ийм байдлыг бол больё. Засгийн газрыг 4 жил ажиллуулъя, ажлыг нь хийлгэе. Хийлгэснийх нь дараа хариуцлага тооцъё гэсэн ийм зүйлүүдийг ярьж байгаа юм. Дээр нь давхар дээлийн асуудлыг ярьж байгаа. Ард түмэн бол дээд зэргийн анхаарал тавьж байгаа. Давхар дээлтэй байхаа больё. Яах вэ нэг 4 гишүүнд нь бол тэр 15 сайд байдаг юмаа гэхэд 4 гишүүнд нь давхар дээлийн асуудлыг өгье.

Хамгийн гол зүйл бол Үндсэн хуульд орж байгаа өөрчлөлт нь шүүх засаглалтай холбоотой. Энэ зүйл бол орж байгаа. Харин би Монгол Улсын Ерөнхийлөгчийг Шүүх засаглал дээр ард түмний талд шийдвэр гаргасан гэж бодож байгаа. Яагаад гэхээр шүүхтэй холбоотой 3 заалт орж байгаа. Энэ 3 заалт орсноороо Монгол Улсад шүүхийн засаглал сайжирна. Ийм зүйлүүд байгаа учраас одоо ард түмнээсээ асуугаад явах нь зүйтэй байх аа гэсэн ийм л саналтай байгаа юм. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Санал хэлчхэв үү. Асуулт, дараа нь үгтэй. За Болд гишүүн. Лувсанвандангийн Болд гишүүн асуулт асууна.

**Л.Болд:** Тэгэхээр энэ хоригийг бол Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намын Улсын Их Хурал дахь төлөөлөл бол анхнаасаа энэ хоригийг хүлээн авах нь зүйтэй гэж шийдвэр гаргасан. Одоо намд Их Хуралд байгаа бүх төлөөлөл, намын төлөөллөөс хамгийн түрүүнд. Тэгээд дараа дараа нь бас хамгийн сүүлд Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжчихлээ. Яагаад энийг дэмжих ёстой вэ гэхээр өнөөдөр бид үнэхээр энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг хэрэгтэй өөрчлөлт болгоод гаргая гэвэл үнэхээр гаргах чиглэл рүү л ажиллах ёстой юм. Ерөнхийлөгч хориг тавихдаа хууль яриад байгаа юм. Хууль ярьж байхад бид нар намын бодлого ярьж өнөөдөр энэ хоригийг эсэргүүцэх бол маш осолтой. Өөрөөр хэлбэл энэ яг дордуулсан долоон өөрчлөлтийн замаар явж байна гэсэн үг. Яах вэ та нарт бол энэ Үндсэн хуулийг хэрэгжүүлээд батлах ямар нэгэн ард түмний санал асуулга хийх гэж байгаа энэ тогтоолоо хууль бус гээд байгаа энэ тогтоолоо гүрийх бололцоо бий. Гэхдээ цаана нь Цэц. Тэгээд хамгийн гол Монголын ард түмэн энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөд чинь итгэхгүй. Ямар өөрчлөлт орж байгааг Батнасан гишүүн сайхан тайлбарлаад байна. Гэхдээ яг одоо хийгдэж байгаа хэлбэрийг нь хараад л энийг чинь ард түмэн Үндсэн хуулийн эсрэг гэмт хэрэг болж байна л гэж харна.

Тийм учраас энэ хоригийг бол авахаас өөр арга зам байхгүй ээ. Аваад одоогоор харин ёстой эцсийн шатны зөвшилцлөө хийгээд, энэ дотор оролцох ёстой Ерөнхийлөгч, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын төлөөлөл, энэ гол намууд өөрснөө энэ юун дээрээ үнэхээр суугаад гарцаа олох ёстой байхгүй юу. Яагаад вэ

гэвэл энэ ард түмний язгуур эрх ашгийн асуудал. Ийм бололцоо байна уу, үгүй юу. Энийг энэ намуудын удирдлага, энэ төрийн өндөрлөгүүдийн төлөөллүүд хариулмаар байгаа байхгүй юу. Өнөөдөр бид бол энд ямар нуугдаж тоглож байгаа биш, хүүхдүүд энд эрхэлж наадаж, хоорондоо одоо хэрүүл маргаан болж байгаа биш. Бид өнөөдөр Монголын Үндсэн хуулийг ярьж байгаа байхгүй юу. Үндсэн хуулиа бүгдээрээ хүлээн зөвшөөрчихсөн, бүгдээрээ ойлгочихсон, бүгдээрээ үнэхээр энэ бол Монголын ард түмэнд сайн зүйл авчрах нь ээ гэдэг итгэл үнэмшлээ авч л батлахаас биш одоо бидний ердийн баталдаг хууль шиг үнэхээр яавч байж болохгүй байхгүй юу. Тэр дордуулсан долоо чинь ерөөсөө тэр шүү дээ. Тэр бол зөвхөн албан тушаалын дайнаас үүссэн өөрсөндөө эвтэйхэн, өөрснөө хэвээрээ үлдэх гээд уул нь Ардчилсан холбоо, эвсэл 4 жил үнэхээр буруу замаар будаа тээсэн. 4 засаг солиод үнэхээр ард түмнээ маш хүнд байдалд оруулсан. Тэгээд тэрний үр дүн сонгуулиар яаж гарсныг ард түмэн 50 суудлаас нэг суудал болгож шийтгэсэн байхгүй юу. Та нар ингээд албан тушаалын төлөө алалцаад бай. Бид та нарыг тэгвэл алаад өгнөө гэж. Яг энэнтэй адилхан үүнээс хойш ингээд бүх Их Хурлууд дээр үнэхээр намууд өөрчлөгдөж, гишүүд өөрчлөгдөж, үнэхээр ёс суртахуунтай, ёс зүйтэй ийм парламент бүрдээд явах ёстой байсан замыг тэр хуулийг нь өөрчлөөд хаяж байгаа байхгүй юу.

Хуулийг нь яаж өөрчилсөн гэхээр нөгөө Ерөнхий сайдад ямар нэгэн зөвхөн намын хараа хяналт, ард түмнээр сонгогдсон Ерөнхийлөгчийн хараа хяналтыг байхгүй болгочихсон. Их Хурлын гишүүд нь бүгдээрээ давхар дээл өмсөх бололцоотой болгоод. Ингээд нөгөө Засгийн газрынхаа албан тушаалуудыг сайд нараа хуваагаад булаацалдаад авдаг энэ юмаа ингээд бүр Үндсэн хуульд тусгаад авчихсан. Их Хурлынхаа ирцийг бууруулчихсан. Аливаа хууль дээрээ яаж байхад амархан гээд ерөөсөө нэг 50 хувийн ирцтэй болгоод тэгээд энэ бүх асуудлуудаа энэ бүх заварсан юмаа хийдэг болсон.

Дээр нь парламентыг байнгын ажиллагаатай парламент биш болгочихсон. Бүтэн жил хуралддаг байсныг ердөө жилдээ тал нь хуралддаг, тал нь хуралддаггүй. Өөрөөр хэлбэл гишүүд бол ажлын чанар бол, ажлын чадвараа бүрэн алдсан. Ингэж бид нар өнөөдөр Монголын төрийг хорлосон тэр дордуулсан долоо чинь өнөөдрийг хүртэл бүх асуудлын эх үндэс байгаа шүү. Бүх нууц санал хураалтыг би бас нууц санал хураалтын цаана ямар үр дүн байдаг гэхээр ердөө Монголын төрийн дархлаа алдагдсан. Энэ Их Хурал гэдэг чинь ач холбогдол нь 180 градус эргэсэн байхгүй юу. Нэг минутаа шууд авчихдаг юм билүү.

**Г.Занданшатар:** Болд гишүүнд нэмэлт нэг минут өгье.

**Л.Болд:** Тэд дархлаа нууц санал хураалтад яагаад алдагдсан гэхээр үнэхээр хүлээн зөвшөөрөгдсөн хүн л гардаг ёстой байхгүй юу. Их Хурлын дарга, удирдлага, Ерөнхий сайд, Засгийн газрын огцруулах асуудал дээр. Одоо ил болгочхонгуут бүх юм сайхан болно гэсэн яасан засаг огцорсоор л байгаа шүү дээ. Бүх хуйвалдаанд Их Хурлын даргаа сольсоор л байгаа шүү дээ. Энэний цаана тэгэхээр юу болсон бэ гэхээр энэ танхимд чинь Монголд чинь хонгил гэж юм бий болоод, зөвхөн бөлдөг цуглуулдаг ийм л уралдаан бий болсон шүү дээ. Одоо бол энэ парламент гэж үнэхээр ард түмнээс сонгогдсон Их Хурлын гишүүн энд өөрийн итгэлээрээ шийдвэр гаргах эрхийг энэ дордуулсан долоо хаасан. Яагаад гэвэл тэр хүний санал нь ил. Тийм учраас тэр хүний бөлдөг л хэрэгтэй. Тэр хүн тэгээд тэр бөлдөгнийхөө дагуу бол саналаа өгдөг. Ердөө л энэ шүү дээ. Үр дүн энэ байхгүй юу. Энэ бүгдийг өнөөдөр бид нар засах бололцоо энд бол байгаа юм. Энэ Үндсэн хуулийн өөрчлөлт. Одоо бол харин та нар бол энэ дээр үнэхээр маш том алдаа руу

явж байна шүү. Тийм учраас одоо ухамсарлацгаа, ард түмнийхээ төлөө, ард түмнээ төлөөлж сонгогдоод сууж байгаа гэдгээ дахиж нэг бодоо, тэгээд зөв шийдвэр гаргаасай. Хоригийг аваасай гэж хүсэж байна.

**Г.Занданшатар:** Бямбацогт гишүүн асуултад хариулна.

**С.Бямбацогт:** Яах вэ Болд гишүүн бас чухал асуудал хөндөж байна л даа. Хуулийн бас үндэслэлүүдийг нь бид нар яриад байгаа юм л даа. Үндсэн хуульд одоо оруулах нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн өөрийнх нь хуулийн хэллэг. Үндсэн хуулийн 68, 69 дүгээр зүйлээс Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт гэсэн болохоос би Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай хууль гэсэн тийм заалт ерөөсөө байдаггүй. Яг л энийг бариад одоо 2000 оноос, 1999 оноос хойш энийг бариад Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталж барьсан, энийг бариад үе үеийн парламент Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Их Хуралд өргөн мэдүүлж байсан. Монгол Улсын Ерөнхийлөгч ч гэсэн яг энийг бариад л Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл саналыг Их Хуралд 7 сарын 16-нд өргөн мэдүүлсэн.

Тийм болохоор энэ маань хуулийн зөрчил биш юмаа гэж бид нар хэлээд байгаа юм энэ. Гэтэл одоо болж байсан, болж байсан бүх юм болж байна, болж байна, сайхан болж байна гэж явж байгаад гэнэтхэн одоо харин болохоо больчихлоо шүү гээд ингээд яриад эхлэхээр жаахан зохимжгүй байгаад байгаа юм л даа. Тэгээд үүний цаад талд нь хамгийн гол нь дахиад энэ хоригийг хүлээгээд авчих юм бол хоригийг хүлээж авсантай холбоотойгоор гуравдугаар хэлэлцүүлэг хийгдэнэ. Гуравдугаар хэлэлцүүлэг дээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн 19 зүйл, 34 заалт маань унаад эхэлбэл одоо сая таны ярьж байгаа нөгөө бөлдөгдүүлэхгүй байх, давхар дээлгүй болох тийм үү, энэ одоо шударга шүүхтэй болох асуудлууд, Дархан, Эрдэнэтийг, 21 аймгуудыг хот болгох асуудал, төвлөрөл хэт их Улаанбаатар руу төвлөрсөн төвлөрлийг сааруулах, орон нутгийн эрх мэдлийг хуваарилах асуудал, нөгөө дордуулсан долоон өөрчлөлтийн, ялангуяа одоо бүр таны оруулсан санал байгаа шүү дээ. Байгалийн баялгийн өгөөж нь, үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогддог байна 6.2-т оруулсан тийм үү. Энэ заалтууд маань унаад эхлэх юм бол яанаа гэдгээс айгаад байгаа юм л даа. Бид нар 57 гишүүний босгыг давуулаад, энэ зүйл, заалт болгоныг Их Хурлаар батлуулах гэж ямар их юм болов. Ёстой нөгөө ногоо ургаж байхад эхэлсэн одоо намар ингээд навч унаж байна. Энэ болтлоо зунжингаа бид нар өдөр шөнөгүй, нойр хоолгүй, хагас, бүтэн сайнгүй ажилласан, зөвшилцсөн, ярилцсан. Ингэж байж нэг юм боосон төслөө буцаагаад одоо Энхболд дарга ч гэсэн хэлж байна. Үнэхээр одоо бас боосон агуулгатай бид нар ярихгүй агуулгын хувьд хэдийгээр зарим зүйл заалт ороогүй ч гэсэн Ерөнхийлөгч бол агуулгын хувьд бас дэмжиж байгаа. Өдий хүртэл явсныг бас ойлгож байгаа гэж.

Гэтэл дахиад гуравдугаар хэлэлцүүлэг хийгдвэл энэ зүйл, заалтууд маань унаад эхэлбэл яах вэ гэдгээс л айгаад байна л даа. Гурван парламент дамжаад, сүүлийн 20-иод жил яригдаад ийм болтлоо явсан юмыг бид нар уначих вий гэдгээс жаахан болгоомжлоод тэгээд. Тийм учраас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэж тавьж байгаа энэ 5 үндэслэлийг чинь одоо 4 үндэслэл нь бас болохгүй байна. За яах вэ ганц нэг үндэслэлүүдийг 5 дахь үндэслэл дээр нь тэр 25.1.16 ард нийтийн санал асуулга явуулахдаа энэ асуудлыг бид нар бас яаж, хэрхэн анхаарч болох вэ гэдгийг бас бодмоор байгаа юм.

Тийм болохоор хамгийн гол нь одоо тавьж байгаа үндэслэл маань нэг хууль зүйн шаардлага хангахгүй байгаад байгаа учраас бид нар ийм үндэслэлээр бид нар хүлээгээд авчих юм бол эргээд гуравдугаар хэлэлцүүлэг хийгдвэл саяны одоо бас танд, та бидний одоо хүсэж байж одоо маш их олон жил зүтгэж, зүдэрч байж оруулсан энэ одоо олон шинэчлэл Үндсэн хуулийн бас төр маань төр шиг болох, улс маань улс шиг хөгжих, ард түмэн нь бас байгалийн баялгийнхаа өгөөжөөс хүртдэг болох, энэ шударга шүүхтэй болох, давхар дээлгүй, давхар дээлээ тайлах гэх мэтийн одоо томхон өөрчлөлтүүд маань алга болчих вий гэдгээс л нэг жаахан болгоомжлоод л одоо Үндсэн хуулийн энэ хоригийг хүлээж авах боломжгүй гэж бас үзэж байгаа юмаа гэдгийг бас хэлье. Тэгээд Хууль зүйн байнгын хороо бас үндэслэлээ тайлбарлах байлгүй дээ. Лүндээжанцан гишүүн бас нэмж тайлбар хийх байх аа.

**Г.Занданшатар:** Бат-Эрдэнэ гишүүн асуух гэж байна. Эрхэм гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ асуулт асууна. Багшаасаа.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой, ялангуяа одоо 2000 оны үеийн дордуулсан долоон өөрчлөлттэй холбоотой үүнийг одоо засаж залруулах, сэргээх, энэ өөрчлөлтийг бол хийх ёстой гэдэг бол одоо бараг 20-иод жил ярьж байгаа ийм зүйл л дээ. Тэгээд түрүүн гишүүдийн ярьж байгаатай бол санал нэг байгаа. Нэлээн хэд хэдэн одоо бас ахиц нааштай энэ томоохон өөрчлөлтүүд бол энд орсон гэдэгтэй бол санал нэг байгаа. Ер нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай энэ хуулийг одоо Их Хурал дээр ярьсан цагаас бол энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэдэг бол нийгмийн хүрээнд зөвшилцөл, ойлголцлоор шийдэх ёстой асуудал аа. Ерөнхийлөгчийн санал, байр суурь хаана байна, АН-ын зөвлөл хаяад гараад явчихлаа. Улс төрийн намууд, төрийн бус байгууллагууд энэ бусад саналуудыг та бүхэн маань хаана авав аа гэдэг талаар бол би маш тодорхой зарчмын байр суурь илэрхийлж байсан.

Үүн дээр бол одоо бид энэ 2016 оны сонгуулийн мөрийн хөтөлбөр дэвшүүлсэн мөрийн хөтөлбөртөө маш тодорхой заачихсан, Үндсэн хуулийг бол ард түмнээсээ асууж байж шийдвэрлэнэ гээд ингээд заачихсан байгаа. Бусад улс орнуудын жишиг ч бас тийм байгаа. Үндсэн хуульд ямар нэгэн нэмэлт, өөрчлөлт оруулах юм бол ард нийтийн санал асуулга явуулж байж тэгээд одоо 50-аас доошгүй хувь нь дэмжсэн ийм тохиолдолд бол өөрчлөлт оруулдаг ийм жишиг байна. Тэгээд энэ бүхнийг харгалзаж үзэж байж одоо Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой асуудлыг ярих ёстой гэдэг ийм зарчмын байр сууриа бол эхнээс нь, Ардчилсан намын зөвлөл одоо ард нийтийн санал асуулга явуулъя гэж одоо албан тоот бичиг өгөхөөс хаа байсан өмнө одоо би энэ Их Хурлын чуулганы танхим дээр энэ байр сууриа илэрхийлж байсан. Энэ шаардлагаа тавьж байсан. Ингээд бол юм нэлээн бүр том зөвшилцлийн ажлын хэсэг гараад, тэгээд энэ хоёр дахь хэлэлцүүлэг юмнууд нь явж байгаад дахиад эргээд одоо ийм байдал руу орчихлоо. Энэ бол зөвхөн намайг ч биш Их Хурлын гишүүд нэлээн олон хүмүүсүүд бас ялгаа байхгүй ийм ацан шалаанд орчихсон байгаа байх л гэж би ингэж бодож байгаа. Миний хувьд бол яг л одоо ийм ацан шалаанд байна.

Энэ чинь одоо Ерөнхийлөгчийн институт эндээс одоо гараад явчих юм бол тэгээд Ардчилсан намын зөвлөл одоо сөрөг байр суурьтай, дахиад одоо ойлголцол байхгүй ийм байдалд хүрэх юм бол тэгээд энэ их нүр их ажил чинь бол талаар болох гээд байна шүү дээ. Гэтэл нөгөө талд нь ард нийтийн санал асуулга явуулахгүй, энэ асуудлыг одоо шийдэх юм бол энэ шиг одоо буруу зүйл байж болохгүй. Би бол ерөөсөө одоо ард нийтийн санал асуулгыг явуулах ёстой гэдэг

бүр эхнээс нь ийм тууштай байр суурь, итгэл үнэмшилтэй байгаа. Би энэ дээрээ л байгаа. Сүүлд нь одоо энэ 2016-2020 оны Улсын Их Хурлын гишүүд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Ард нийтээсээ одоо асуугаагүй ээ. Ард нийтийн санал асуулга явуулах тухай хууль байсаар байтал энэ хуулийн дагуу санал асуулгаа явуулаагүй ээ гэдэг ийм юманд бол би орохгүй гэж би ийм байр суурьтай байгаа.

Тэгээд өнөөдөр бол Ерөнхийлөгчийн Тамгын газраас Ерөнхийлөгчийн тавьж байгаа хоригийг хууль зүйн үндэслэл талаас нь нэлээн дэлгэрэнгүй тайлбарлалаа. Тэгэхээр энэ Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авахгүй байх тэр хууль зүйн үндэслэл талынх нь юмыг одоо надад нэг хэлж өгөөч ээ. Би энийг бол яг Лүндээжанцан багшид би хандаж асуух гээд байгаа юм. Ингэж байж одоо нэг харьцуулж бид нар чинь итгэл үнэмшил бий болох хэрэгтэй байна шүү дээ.

**Г.Занданшатар:** Лүндээжанцан дарга Төрийн байгуулалтын байнгын хороо, хууль санаачлагч.

**Д.Лүндээжанцан:** За энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэсэн Үндсэн хуулийн 6 дугаар бүлэг дотор 68, 69 дүгээр зүйлд туж Үндсэн хуульд түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн нэгэн адил хүчинтэй байна гээд ингээд заачихсан учраас бид болохгүй байгаа юм. Тухайн үедээ 1990 онд Үндсэн хуулийн нэмэлтийн хууль гэж байсан. Энэний дагуу оруулъя гээд би бас тэр 2010 оны Үндсэн хууль санаачлагчийн нэг байгаа юм. Чимид багш, С.Төмөр гэж гишүүн энэний анхны эх нооргон дээр нь ажиллаж байсан. Тэгээд Энхтүвшин дарга бид нар санаачлаад ингээд гаргасан. Тэр үед бол хуулиар оруулъя, хуулийн хэлбэртэй байя гээд. Ингээд энэнээс хойш одоо Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал яригдахаар л нэрийн асуудал яригддаг юм. Ингээд 3 парламент дамжаад Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэж Үндсэн хуулиараа явъя өөр зам алгаа. Хуулиар гээд тэгэхээр бол одоо болохгүй байна. Constitutional акт гэж. Англид бол 3, 4 актаас бүрдэж байгаа юм Үндсэн хууль нь бол шинжтэй акт. Америкт бол Үндсэн хууль тэгээд нэмэлт, өөрчлөлтүүд гээд явж амин дэмтэй нь. Би хэл ээдрээд байна. Тэгэхээр 26 нэмэлт, өөрчлөлт орсон. Тэгээд ер нь яг энэ хуулиа ингээд бичихдээ ингээд биччихсэн. Энүүгээрээ явъя гээд.

Хууль гээд одоо хамгийн сүүлд Нямжавын Батбаяр нарын 47 гишүүн хууль санаачлаад бид нар бол 2 өдөр бүтэн энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэх үү, хууль гэх үү гэдэг дээрээ маргаан болсон. Ингээд үе үеийн парламентын гишүүд Үндсэн хуулийгаа Үндсэн хуулиа л барья. Хэрвээ Үндсэн хууль, хууль хоёр зөрчилдөх юм бол Үндсэн хуулиа барьдаг зарчмаараа Үндсэн хуульд бас тэр зарчмыг нь суулгаад өгчихсөн юм. Үндсэн хууль зөрчсөн хуулийг баримталж болохгүй ээ гээд. Тэгээд яг энэ нэрийн хувьд бол зөрчихсөн. Тэгээд одоо энэ хууль гэдэг сая одоо хоёр, гурван жилийн өмнө манай ажлын хэсэг ажиллаад бас энэ Б танхимд хуралдаад за яах вэ нэрэн дээрээ яах вэ гээд. Ингээд бас хоёр, гурван хоногийн яриа болж байгаад Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэж явахаас өөр арга алгаа гээд. Энийг засах гээд одоо манай Нямбаатар гишүүн нарын гишүүд хууль санаачилна гээд. Тэр үед ямар асуудал яригдсан гэхээр бол хэрэв Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд өөрчлөлт оруулбал Үндсэн хуульд дур зоргоороо халдах үүд хаалгыг нээ гэдэг эсэргүүцэл гараад нэлээн юм болсон. Сошиалд бөөн юм болсон.

Тэгээд ер нь ч одоо өөрчлөлт оруулах нь Үндсэн хуулийн дархлааг бол сулруулах, бууруулах болзошгүй байна гээд Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлт

оруулах журмын хуулиа халдахаа больё. Бүх шаардлагыг нь бариад явъя. Харин нэрэн дээр бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэдэг нэрээрээ явъя гэж ингэж л тогтсон юм. Оросоо гэдэг хуульч бол 3 жил энийг ярьж байгаа юм. Тэгээд тэр болгонд нь бид хариулт өгөөд одоо ингээд сая намуудын 5 хоногийн хэлэлцүүлэг дээр хүртэл ойлголцлоо гээд ингээд. Нарантуяа гишүүн энэ хууль орж ирэхэд бас асуулт тавьсан. Тэрэнд нь бид ийм хариулт өгөөд ингээд яваад ирсэн. Тэгэхээр үеийн парламентын гишүүд одоо ингээд гарын үсгээ зураад, нэмэлт, өөрчлөлт гэдэг үгээр нь явахгүй бол Үндсэн хууль, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль гэж 3 юмыг бичих нь болох нь байна шүү дээ.

Хэрвээ одоо Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль гээд гаргачих юм бол Үндсэн хууль, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хоёр нь л Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь л Үндсэн хуулийн адил хүчинтэй байна. Нөгөөдөх нь бол хүчингүй юм байна шүү дээ гэж харагдахаар бас болчих асуудал үүсчхээд байгаа юм. Энэ мэтчилэнгийн ийм зүйлүүд болоод Үндсэн хуулийн цэцээс бид нар бол одоо... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Нэг минут нэмье.

**Д.Лүндээжанцан:** Үндсэн хуулийн цэцэд бол очиж саналаа авах ёстой байдаг юм байна. Энэ хуулийн дагуу 1999 оныхыг чинь аваагүй гэдэг юугаар унасан шүү дээ процедурын алдаагаар. Тэгээд тэр өдөр нь энэ Бямбацогт, Содбаатар бид 3 өдөр яг ингээд өргөн барьсныхаа дараа шууд очиж Цэцийн гишүүдэд өргөн барьсан. Цэцийнхэн одоо хэд хоногийн дараа зөвлөгөөн гэдгээ хийгээд, за Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалын дагуу явуулах нь зүйтэй гээд тэгээд ирүүлсэн. Тэрнээс биш нэрийн асуудлаар бол бид зориуд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэж яг тэр төслөө бол одоо 62 гишүүний төслийг Цэцэд бол одоо өргөн мэдүүлсэн байгаа. Ийм байдалтай л яваад ирсэн ийм түүхтэй юмаа.

Хоёрдугаарт, нэг болгоомжлол байдаг. Намын хуульд намын нэрийн асуудал гарсан л даа Улсын дээд шүүх дээр. Улс төрийн намын хуульд улс төрийн намын нэрийг ашиглахгүй ээ гээд заачихсан байгаа юм. Цагаан дээр хараар бичсэн. Тэгээд Монгол Ард... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Тэр нь Үндсэн хуульдаа нийцүүлнэ гээд тэд шийдвэр гаргачихсан. Шүүх шийдвэр гаргачихсан гэж. За Аюурсайхан гишүүн асуулт асууна.

**Т.Аюурсайхан:** Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хоёрдугаар хэлэлцүүлгийг хийж дуусаад бид энэ танхимдаа бүгдээрээ ард нийтийн санал асуулгаар эцэслэн шийднэ гээд шийдвэрээ гаргачихсан байгаа. АН-ынхан болохоор ард нийтийн санал асуулгаар явуулаач ээ гээд яриад байсан. Өнөөдөр болохоор ард нийтийн санал асуулга хэрэггүй ээ, ард нийтээр асуух шаардлагагүй. Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж аваад энэ танхим дотроо гуравдугаар хэлэлцүүлгээ хийгээд дуусъя гээд ингээд яваад байна. Тэгээд энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг би бас төгс төгөлдөр болсон, одоо 100 хувь бүрэн санасан бодсоноор болсон гэж хэлж чадахгүй ээ. Гэхдээ энэ хэдэн саруудад бид одоо зүтгэн зүтгэн байж, болохгүйг нь хасах, болж байгаагийг нь дэмжих, ецэ зөв зүйл тусгахын тулд зөндөө ажиллаж ажиллаж байгаад ард нь асуудлуудын ард гарсан. Бүхэлдээ энэ нэмэлт, өөрчлөлтийг харах юм бол энэ бол буруу зүйл ороогүй ээ.



100 хувь зөв биш сайн биш ч гэсэн ямар ч байсан нэг хэсэг асуудлыг шийдэж чадсан.

Нэгдүгээрт, байгалийн баялагтай холбоотой маш том асуудлыг бид тэмцэн зүтгэн байж стратегийн ач холбогдолтой орд газрын дийлэнхийг нь, үр ашгийн дийлэнхийг нь ард түмэнд хүртээнэ гэдэг ийм заалт бол хүнд замаар явж бүтсэн байгаа шүү дээ. Улсын Их Хурлыг хариуцлагажуулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах, Улсын Их Хурлын шийдвэр гаргах механизмыг нь сайжруулах, Засгийн газрын сайд нарын давхар дээлийн асуудлыг 100 хувь биш ч гэсэн 70 хувь шийдчихлээ. Төсвийн хараат бус байдлыг шийдчихлээ. Хотуудынхаа эрх зүйн байдлыг бэлдээд бий болгоод өгчихлөө. Энэ Үндсэн хуулийн өмнөх одоогийн хүчин төгөлдөр Үндсэн хуулиараа Монгол Улс нийслэл, аймагт хуваагдана, нийслэл нь дүүрэгт, аймаг нь сумдад гэснээс болоод энэ одоо өнгөрсөн үеийн бүтээн байгуулалтын Эрдэнэт, Дархан, аймгуудын төвүүд сайхан сайхан хотууд чинь байхгүй бүгд сумд болчихсон. Төв суурин газрыг хөгжүүлэе гэх юм бол хотын хөгжлөөр хөгжих ийм гарц заавал хэрэгтэй. Эрдэнэтчүүд хүлээлттэй, дарханчууд хүлээлттэй. Бусад одоо аймгийн төвүүд хүлээлттэй байдаг.

Шүүхийг хараат бус болгох асуудлыг шийдчихсэн харьцангуй. Би бол 60 хувь гэж хэлж чадна. Гэхдээ нэг хүний хараатаас харьцангуй болиулсан. Шүүх шударга байна уу, бүгдээрээ шударга бус гэж хэлж байгаа шүү дээ авлигажсан. Шүүгч гаргасан шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээх ёсгүй ээ гээд тэр Салхитын мөнгөний ордын шүүх хуралдааныг шүүсэн. Үүнээс улбаалаад Монгол Улсын Ерөнхийлөгч өөрөө одоо чөлөөлчихсэн ийм шүүгч ингээд хараад та нар миний гаргасан шийдвэрийн төлөө хэн ч намайг шүүх эрхгүй шүү дээ нөхдүүдийгээ ингээд сууж байгаа шүү дээ олон нийтийн өмнө гарчихсан. Тэгвэл шүүхийн сахилгын хороо гээд, шүүхийн хариуцлагыг нь бий болгоод, шүүгчийг гаргасан шийдвэрийнх нь төлөө шалгадаг шаардлагатай бол, эгүүлэн татдаг ёс зүйн хариуцлага хүлээдэг ийм юмыг бид нар тусгачхаад сууж байгаа шүү дээ.

Ерөнхийлөгч хэт их эрх мэдэлтэй байгаа. Үндсэн хуулиараа олгоогүй асар их эрх мэдлийг 60, 70-аад эрх мэдлийг органик хуулиар эдлээд сууж байна шүү дээ. Тэрийг нь бид нар болиулсан. Гэтэл өнөөдөр энэ одоо хэрвээ хоригийг бид нар хүлээж авах юм бол, ард нийтээрээ санал асуулга явуулахгүй юм бол энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт чинь бүгдээрээ унана нөхөд өө, байхгүй болно. Энэ өөрчлөлтүүдийг бид нар хийж чадахгүй. Өнөөдөр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөө эцэслэн баталчихсан бол аль хэдийнэ Ерөнхийлөгч хориг тавиад Цэцэд өгчихсөн байгаа. Харин эцэслэж батлаагүй ард нийтээрээ санал асуулгах гээд яваад байгаа учраас хориг ч тавьж чадахгүй, Цэц дээр ч очиж чадахгүй ингээд өөрөөр хэлбэл энэ ард нийтийн саналаа өгдөг ийм дархлаанд нь хамгаалагдаад өнөөдрийг хүртэл бид нар авч яваад, ард нийтийн санал асуулга руугаа явуулъя гэсэн юм. Гэтэл энийг нь татаж аваад одоо бол тийм учраас зөвхөн тогтоолд нь, тойрсон тогтоолд нь хориг тавиад, Цэцэд өгнө гээд явж байгаа юм.

Нэг минутаа авна шүү. Би асуулт асууна. Тэгээд энэ ерөнхий энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг яагаад эсэргүүцээд байна вэ гэх юм бол хэсэг бүлэг одоо хүмүүс байна. Нэгдүгээрт, Ерөнхийлөгч шүүхээ бүрэн атгахыг хүсэж байна. Үндсэн хуулиар олгоогүй 60, 70 эрхийг органик хуулиараа эдлэхийг хүсэж байна. Хоёрдугаарт, дараа нь Ерөнхийлөгч болж 2021 онд Ерөнхийлөгч болж энэ их эрх мэдлийг эдэлье гэж сэрүүн зүүдэлж байгаа хүмүүс эсэргүүцэж байна өнөөдөр хоригийг хүлээж авна гээд. Гурав, давхар дээлтэй болж байж 100 хувь давхар дээлтэй болж байж Засгийн газрын гишүүн сайд болъё гэж шунаж байгаа хүмүүс

байна. Дөрөв, байгалийн баялгийн стратегийн ач холбогдолтой байгаа баялгийн үр ашгийн дийлэнхийг нь ард түмэндээ хүртээе гэдгийг эсэргүүцээд хувьдаа завших гээд байгаа этгээдүүд энэ өөрчлөлтийг зөвшөөрөхгүй байгаа юм. Тав, барьцаанд орсон хүмүүс байна. Барьцаалагдсан улс төрчид өнөөдөр шийдвэр гаргаж болохгүй.

Тийм учраас дахиж нэг минут авъя эрх байгаа надад. Асуулт үлдчихлээ. Ингээд тийм учраас би бас энэ Батзандан, Болд хоёр нөхөртөө хандаж хэлмээр байна. Бид ямар замыг тууллаа. Шүүхийг яаж хараат бус, шударга болгоё гэж зүтгэж тэмцлээ. Яаж энэ шүүгч, тэргүүн шүүгч нарын эсрэг зоригтой нэр усыг нь хэлж байж та хоёр хэрэг түвэгт орооцолдож байж хүртэл тэмцлээ. Яаж энэ одоо Улсын Их Хурлыг хариуцлагдажуулах, байгалийн баялгийнхаа үр шимийг ард түмэндээ өгөхийн тулд баялагтай эзэн Монгол бүлгийг хүртэл байгуулаад яаж тэмцэж байлаа. Тэгээд одоо энийг та хоёр нураах гэж байна шүү дээ. Ингээд явах юм бол бид нарын одоо ярьсан зорилго биш болоод одоо зам салах энэ зааг дээрээ ирчихлээ шүү дээ. Эндээ та хоёр маань дахиж бодооч ээ.

Ард нийтийн санал асуулга руугаа явуулаач ээ энийгээ. Ард нийтээр нь хэлэлцүүлээч ээ. Бид нар зүтгэж зүтгэж оруулсан маш сайн өөрчлөлтүүд энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөд чинь байгаа шүү дээ. Ерөнхийлөгчид яагаад асар их эрх мэдэл өгөх гээд байгаа юм. Шүүхийг яагаад хараат байлгах гээд байгаа юм. Яагаад дараа дараагийн шилээ дарсан горилж байгаа энэ Ерөнхийлөгчид горилж байгаа хүмүүс энэ эрхийг.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Бямбацогт гишүүн. Бямбацогт дарга асуултад хариулна.

**С.Бямбацогт:** Аюурсайхан гишүүний бас хэлж байгаатай санал нэг байгаад байгаа юм. Бид нар олон жил 2000 онд Үндсэн хуулийн одоо дордуулсан долоо гэж хэлдэг өөрчлөлт хийгдсэнээс хойш энэ Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулъя. Энэ дордуулсан долоог засъя, цаашдаа бас засах залруулах зүйлс олон байна гэж сүүлийн одоо 10 гаруй жил ярьж ярьж, ярьсаар байгаад одоо АН-ын 47 гишүүн гарын үсэг зурж байсан 2015-аас 2015 онд. 2016, 2019 онд сая одоо 62 гишүүн гарын үсэг зураад Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ахлуулсан Үндэсний зөвшилцлийн комисс байгуулаад, Улсын Их Хуралд суудалтай бүх намын төлөөллийг оролцуулаад, мөн одоо бас парламентад суудалгүй 30-аад намынхныг одоо оролцуулсан бүтэн 7 хоногийн турш хэлэлцүүлэг зохион байгуулаад, тэгээд тал талаасаа бас ярилцаж нэг бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй гэж ярилцаж ярилцаж өнөөдөр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл маань анх 24 зүйлтэй, 54 заалттай өргөн баригдаж байсан бол одоо 19 зүйлтэй, 34 заалттай болж нэлээд багассан ийм байдалтайгаар эх нь батлагдаад байгаа хоёр дахь хэлэлцүүлгээр.

Энэ батлагдсан эхийг хориг хүлээж аваад гурав дахь хэлэлцүүлэг рүү явах юм бол 57 гишүүний босгыг давуулах гэж төрийн албаны тухай зүйл, заалтууд ямар асуудал болж, юу болж байлаа. Улс төрийн намтай холбоотой зүйл, заалтууд, Ерөнхий сайд нь бас кабинетаа өөрөө бүрдүүлдэг байх ёстой гэсэн дэвшилттэй заалтууд, 57 гишүүний босго давахгүй ганц хоёрхон гишүүнээр, гурав, дөрөвхөн гишүүнээр Их Хурлын босго давахгүй байсан та бүхэн сайн санаж байгаа байх. Одоо тэгвэл энэ 19 зүйл 34 заалт чинь бүгдээрээ нэг бүрчлэн гурав дахь хэлэлцүүлэг дээр 57 гишүүний босго давах ёстой болно. Ингэхээр тэгээд ерөөсөө 6.2-оос авхуулаад байгалийн баялгийн өгөөжийг стратегийн ордыг ашиглахдаа байгалийн баялгийн өгөөжийн дийлэнх нь ард түмэнд хүртэх ёстой гэсэн заалтаас

эхлээд унаад эхэлнэ. Тэгээд нөгөө давхар дээл тайлахгүй одоо Их Хурлын гишүүд нь давхар дээлтэй сайд байхыг хүсдэг нь яваад эхэлнэ. Дахиад нөгөө шударга биш, шударга бус шүүхтэй байхыг хүссэн хүмүүс нь унагаагаад эхэлнэ.

Ингээд эцэстээ бидэнд юу үлдэх вэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс авах юм үлдэхгүй болно л доо. Ийм л юм руу явчих гээд байгаа учраас одоо хоригийг авахад хэцүү байна, хүнд байна гэдэг асуудлыг ярьж байгаа юм. Бас одоо АН-ын нөхөд маань зөв ойлгооч ээ. Бос гэхээр нь одоо босдог, суу гэхээр нь суудаг бүх юмыг одоо санаанд нийцүүлэх гэж зунжингаа үзлээ нээрээ. Одоо таалагдахгүй байгаа юм байлгүй одоо мэдэхгүй нээрээ. Одоо аргаа барж байна нээрээ ёстой. Тэрнээс бүх юм нь таалагдахгүй байна гэж ард нийтийн санал асуулга яв гэхэд нь ард нийтийн санал асуулгаар явъя л гэлээ. Өөрснөө батал гэхэд нь өөрснөө баталъя гэсэн чинь ард нийтийн санал асуулгаар явуул гэсэн. Одоо буцаагаад одоо бид Их Хурал өөрөө батлах ёстой гээд ийм асуудал гаргадаг. Их Хурал батлахаараа одоо ийм л юм болно шүү дээ бас тэгээд. Ийм байдлаар бид нар уул нь жаахан эвлээд явчих юм бол бүтчих байх. Тэгээд одоо ингээд эвдрээд явах юм бол тэгээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг өмнөх 4 жил ч ярьж байсан, өнөөдөр ч ярьж байсан. Цаашдаа дахиад 8 жил ярих эрхгүй болно. Энийг бас бүгдээрээ бодоосой бас тийм. Өнгөрсөн 10 гаруй жил ярьсан.

Одоо өнөөдөр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлаар босго давуулж чадахгүй бол бид нар дахиад 8 жил ард түмнийхээ санал асуулгаар баталж чадахгүй бол дахиад 8 жил ярих эрхгүй болно. Бид нар үндсэндээ сүүлийн одоо энэ төрийн гажуудлыг энэ улс орноо бодох асуудлыг засъя, залруул гэж ярьж байгаа юм болгон Үндсэн хууль л болохгүй нь гэж ярьж байгаа шүү дээ. Хэрвээ тийм бол одоо Үндсэн хуульдаа өөрчлөлтөө хийгээд засчихмаар байна. Бүгдээрээ одоо энэ дээр санал нэгтэй байдаг. Ганцхан энэ нь таалагдахгүй байна, тэр нь таалагдахгүй байна. Ийм учраас тэгэх ёстой, ийм учраас ингэх ёстой гээд ингэж явсаар байтал одоо тэгээд өөлөхөд нэг өндөг ч гэсэн өөтэй л дээ. Өөлөх юм бол мэдээж бас өөлөх юм байгаа байх тийм. Бүгдээрээ 100 хувь сайхан гэж одоо хэлж чадахгүй ээ мэдээж. Өөлөхөөр өндөг ч гэсэн өөтэй. Ийм байдлаар битгий өөлж хандаач ээ. Тэгээд одоо нэгэнтээ өдий хүртэл боогоод бүгдээрээ хамтын санаачилга, 3 парламент дамжаад, Монгол Улсын Ерөнхийлөгчөөр Үндэсний зөвшлийн комисс ахлуулаад, улс төрийн парламентад суудалгүй намуудаа оролцуулаад өдий хүртэл ард түмнээр хэлэлцүүлээд ирсэн юмыгаа бас нэг боогоод цааш нь гаргачих юмсан гэдэг үүднээс л одоо та бүхнийг бас бодоосой гэдгийг л хэлье.

**Г.Занданшатар:** Одоо эрхэм гишүүн Жадамбын Энхбаяр асуулт асууна.

**Ж.Энхбаяр:** 1992 онд батлагдсан Үндсэн хууль маань Монгол Улсын нийгмийн амьдралыг зохицуулаад 30-аад жил өнгөрлөө. Энэ хугацаанд энэ улс орны өнөөгийн байдалтай холбоотойгоор ер нь Монголын ард түмэн нийтээрээ одоо энэ байгаагаараа байж болохгүй ер нь өөрчлөгдье гэдэг л нийт хүсэл тэмүүлэл, уур амьсгал бий болсон өөрчлөгдье. Яаж өөрчлөгдөх юм. Олон салбарт олон янз бүрийн санал оноо гараад ирсэн. Тэр бүх асуудал өөрчлөлтийн гол түлхүүр нь Үндсэн хууль дээр л ирж бууж байсан шүү дээ. Тэгээд зайлшгүй Үндсэн хуулийн өөрчлөлт хийж байж өнгөрсөн 30 жилийнхээ нийгмийн амьдралыг нэг сайн дүгнэж байж тэгээд цаашдаа бага алдаа оноотойгоор улс орноо хөгжүүлэх бодлогоо гаргахад шинэ Үндсэн хууль зайлшгүй юмаа гэдгийг л улс төрийн бүх намууд энэ ордонд ярьсан, мэдэгдсэн, хуралдсан чуулсан, хэлэлцүүлсэн. Монгол

Улсын бүх л салбарын төлөөлөл оролцсон. Бүх хуульчдыг л дайчилсан. Бүх ард түмнээрээ хэлэлцүүлсэн. Орон нутагт ажиллацгаасан.

Би энэ 2000 оны 3 сарын 15-ны 19 жилийн өмнөх Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хараад сууж байна л даа. Тэгээд энэ 2000 онд хийгдсэн 1999 оны 12 сарын 23-нд хийгдсэн Үндсэн хуулийн тэр өөрчлөлт нь Цэцээс санал аваагүй, Ерөнхийлөгчтэй зөвшилцөөгүй, сонгогчид олон нийтээр хэлэлцүүлээгүй тул гэдгээр энэ Үндсэн хууль зөрчсөн гэсэн ийм дүгнэлт гарч байсан. Одоо тэр хуулийг батлахад оролцсон манай Лүндээжанцан, Нямдорж гишүүд энд сууж байна. Энэ хоёр гишүүн маань түрүүн Цэцэд бас Улсын Их Хурлыг төлөөлж итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байсан. Тэгээд тэр сургамжид дээрээ үндэслээд бүх ард түмнээрээ хэлэлцүүлээд, Цэцэд өргөн мэдүүлээд, Ерөнхийлөгчтэй зөвшилцөж, Ерөнхийлөгчид ажлын хэсгээ ахлуулаад ингээд асуудлуудаа боогоод ороод ирлээ шүү дээ.

Үнэхээр өнөөдөр бид нарын хамгийн том зүйл бол энэ засаглалын ойлгомжгүй байдал байгаа шүү дээ. Бүх өөрчлөлтийн гол цөм эндээ. Их Хурал нь Засгийн газар юм шиг болчихсон. Засгийн газар нь Их Хурал ч юм шиг. Ерөнхийлөгч нь Ерөнхий сайд ч юм шиг. Энэ нэг 3 толгойн учрыг жаахан олох л асуудал шүү дээ. Тэгээд энийгээ дагаад энэ шүүх, орон нутгийн удирдлагын асуудал байсан. Энэ бүх өөрчлөлтийг л базаад, ойлголцолд овоо оруулаад дөхүүлээд ирсэн. Тэгэхээр асуулт ийм байна. Тамгын газрын даргаас.

Ерөнхийлөгчийн хоригийг Улсын Их Хурал хүлээж авбал ямар улс төр, нийгмийн үр дагавар үүсэх гээд байгаа юм. Энэ дээр Ерөнхийлөгчийн зүгээс ямар одоо дараагийн санаачилга, үйл ажиллагаа явагдах вэ. Хэрвээ энэ хуулийн хоригийг хүлээж авахгүй бол мөн ямар алхмууд хийгдэх гэж байна. Энийгээ нэг гол нь нээлттэй хэлмээр байна. Лүндээжанцан гишүүнээс асуумаар байна. Хуулийн эх барьж байгаа хүний хувьд. Энэ нийгэм, эдийн засгийн зайлшгүй өөрчлөлтийг бид хийхгүй бол юу болох юм. Үндсэндээ энэ хийгдэж амжихгүй бол бид 20, 21, 24 он гээд үндсэндээ одоо байгаа эрх зүйн орчин, одоо байгаа орон нутаг, одоо байгаа шүүх, эрх мэдэл, одоо байгаа засаглалын энэ ойлгомжгүй байдлаараа л цаашид нь явна шүү дээ. Энийг Монголын нийгэм тэсэх үү. Тэгэхээр энэ нийгмийг зайлшгүй одоо энэ шаардаад байгаа тэр өөрчлөлтийг л Улсын Их Хурал энэ тэр хүлээсийг нь тайлж тэр өөрчлөлтийг хийж байж улс орон чинь нэг амгалан тайван болоод, бас нэг амьсгаа аваад ингээд цаашаа ирээдүйгээ нэг төлөвлөх, харах нэг ийм шинэ сонголтоо нэг хийгээд явах бололцоо бүрдэх юм болов уу л гэж бодох юм.

Тэгэхээр хийж чадвал юу болох юм, хийж чадахгүй бол юу болох юм. Ямар улс төр, нийгмийн эдийн засгийн үр дагавар болох юм. Энийг Ерөнхийлөгч нь яаж хараад байгаа юм. Энийг Энхболд дарга, хууль эх барьсан хүний хувьд Лүндээжанцан гишүүн та энийг энэ талаас нь тайлбарлаж өгөөч.

**Г.Занданшатар:** 80 дугаар микрофон Энхболд дарга асуултад хариулна.

**3.Энхболд:** Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Хүлээж авбал яах вэ гэж. Бүрэн авч болно, хэсэгчлэн авч болно. Хоёр зам байгаа. Хууль хэлбэртэй байна гэдгийг үл тоогоод 25.1.16-г хэсэгчлэн авах юм бол тогтоолдоо засвар хийгээд цаашаа явж болно. Хууль хэлбэрээр байх ёстой юм байна, Журмын хууль зөрчсөн байна гэх юм бол шинээр хэлэлцэнэ гэсэн үг. Хууль хэлбэртэй өргөн бариад. 6 сарын 6-нд эхэлсэн нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой Лүндээжанцан гишүүний бланк дээр хэвлэснээс хойш нийт 17 арга хэмжээ

Ерөнхийлөгчийн зүгээс оролцсон байгаа юм. 6 сарын 6-аас эхлээд л санал аваагүй шүү гээд эхлээд явуулсан. 6 сарын 11 болохоор албан бичгээр мэдэгдсэн байна. Гишүүд 17-ноос 6 сарын 28-ны хооронд тойрогтоо санал сонсохоор явсан байна. Дараа нь 7 сарын 2-нд Е/39 албан тоотой наадмын өмнө яарахгүй шүү, наадмын дараа үргэлжлүүл гээд тэгээд наадмын дараа Ерөнхийлөгч хажуугийн санал оруулсан гээд ингээд 17 үйл ажиллагаа явуулаад, 17 дахь нь болохоор энэ 73 дугаар тогтоолын хориг байгаа юм. Тэгэхээр энэ бол Ерөнхийлөгч огт оролцоогүй биш оролцоод тухай бүрд нь залруулахыг оролдоод яваад байгаа юм. Хүлээж авах юм бол ийм хоёр сонголт байгаа.

Хүлээж авахгүй бол хэн нэгэн хүн Цэцэд өргөдөл өгөөд унах магадлалтай гэж хэлээд байгаагийн учир нь 2000 онд хийсэн алдаагаа яг давтаад байгаа юм. Одоо 2000 оны хүчингүй Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгосон Үндсэн хуулийн цэцийн байр суурь бол одоо ч гэсэн хэвээрээ л байгаа өөрчлөгдөөгүй. Энэ хооронд харин 2010 онд батлагдсан Журмын тухай хуулийн дагуу Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэлэлцүүлэг явсан бол харин юм хэлэхгүй байх. Гэтэл энэ хуулийнхаа бүх заалтыг зөрчөөд баталчихсан учраас унахад их эмзэг болчихоод байгаа юм. Тийм учраас хүлээж авахгүй явах юм бол бүхэлдээ хүчингүй болох, хүлээж авах юм бол засвар хийгээд одоогийн тохирсон түвшиндээ батлах боломж байна гэж Ерөнхийлөгч харж байгаа.

**Г.Занданшатар:** За Лүндээжанцан дарга асуултад хариулна.

**Д.Лүндээжанцан:** Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Үндсэн хуулийн 68 дугаар зүйл дээр санал асуулгыг Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16-д заасан үндэслэлийн дагуу явуулна гээд ингээд давхар заачихсан. 68 нь бол тусгайлсан заалт. Тэгээд энийг давхардуулах шаардлагагүй ээ гээд үзсэн юм. Энийг бол Ерөнхийлөгч бол энийг бас давхар зааж өгөх ёстой л гэж ингэж үзсэн. Уул нь бол энэ 68 дээрээ 25-ынхаа 1.16-г ишилсэн л байгаа юм. Би бол олон таван юм яриад яах вэ. Одоо ийм л байдалтай.

Ер нь бол энэ нэмэлт, өөрчлөлт бол 1992 оныхоо Үндсэн хууль Монголын ард түмний хамтын бүтээл болсон. Зөвшилцлийн дээд баримт бичиг. Энийгээ цааш нь үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалыг баяжуулаад, тэгээд ардчиллаа гүнзгийрүүлээд бэхжүүлээд явъя. Тэгээд энэ хий эргээд байгаа зүйлээс нэг гаръя. Тэгэхгүй одоогийн нөхцөл байдалд бас Цэц дээр нөгөө 2000 оны долоон нэмэлт, өөрчлөлт чинь үүсчихсэн, хэрэг үүсчихсэн байгаа байхгүй юу. За ингээд ажиллагаа хийгдээд, ингээд энэ тэр ингээд сэргээд ирээд, энэ хууль нэмэлт, өөрчлөлт гарч чадахгүй бол 2020 оны Их Хурал, Засгийн газар ер нь яаж ажиллах болоо гэхээс бол би бол их эмээж байгаа юм. Тэгээд энэ эцсийн эцэст тэр Их Хурал, Засгийн газар яаж ажиллах нь хамаа алгаа. Эцсийн эцэст энэ улс орон, ард түмэн л хохирдог байхгүй юу. Энэ дотор бол нийгмийн шинжтэй зүйлүүд тусгаагүй энэ тэр гэж яриад байгаа юм. Төрийн эрх мэдлийн хяналт тэнцэл нь сайжраад, хариуцлага бүх шатандаа сайжраад явчих юм бол аяндаа хүний эрх, эрх чөлөөний баталгаа чинь л хангалт нь дээшлэх ёстой л байхгүй юу.

Тэгээд энэ 4 залуу надтай нэг уулзсан саяхан. Их зүйлийг бодсон тэр хүмүүсийн уулзалтаас. Бидний хийж байгаа энэ ажил бол одоо нэг их буруу замаар яваагүй юм байна даа гэж ингэж байна лээ. Дорвитой өөрчлөлт хийсэнгүй гэж шүүмжлээд байгаа юм. Маний санасан хэмжээнд зарим зүйл хүрээгүй, санаа онооны зөрүү байгаа боловч энэ нэмэлт, өөрчлөлтийг бол дэмжихээс аргагүй байгаа юм. Өөрөөр хэлбэл бид 24 оныг бодож байна гэж тэгж байна лээ. Тэгэхээр

энэ одоогийн бид арайхийж нэг юм боосон юмаа 2020 оны парламент гарч ирээд, тэгээд хийгээд, тэгээд одоо нийгмийн зөвшилцөлд хүрээд, ингээд одоо цаашаа яваад, журамдаа орно гэхэд бол бас л их эргэлзээтэй байгаа юм. Өнөөдөр тэгвэл одоо түрүүний таны хэлснээр нээрээ ард түмэн даах болов уу, үгүй болов уу гэж. Энэ парламентын засаглал тусгаар тогтнолын баталгаа болсон парламентын засаглал чинь явцгүй юм байна, хэрэггүй юм байна. Монгол орон өөр замаар явах ёстой юм байна гэдэг л тийм юм руу хүргэх тийм хөрс суурь болчих вий гэдгээс би хамгийн их айж байгаа юм. Тийм учраас бид түүхийн өмнө хүлээх хариуцлага гэж юм байна. Энэнийхээ дагуу л одоо явж байгаа юмаа гэдгийг хэлье. Тэгээд одоо аль болохоор зөвшилцөж, зөв гарц олж, зөв явахын төлөө л ажиллаж ирсэн. Одоо чадах ядахаараа бид нар чинь тал талаасаа хичээгээд ажилласан. Одоо яг юм л тулчхаад байгаа юм.

**Г.Занданшатар:** Энхбаяр гишүүн нэг минут тодруулна.

**Ж.Энхбаяр:** Монгол Улсын Ерөнхийлөгч энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөх хэрэгтэй нь процессын алдаа гаргасан гэж яриад байна шүү дээ. Энэ дээр одоо Хууль зүйн байнгын хороо тайлбар өгөөдхөөч. Ямар алдаа гаргаад, үнэхээр алдсан гэж та хүлээн зөвшөөрч байна уу, үгүй юу. Бас Лүндээжанцан гишүүн энэ дээр бас тайлбар өгөөдхөөч. Бид нар бас одоо санал хураана. Итгэл үнэмшилтэй болмоор байна. Үнэхээр процессын алдаа гарсан байна. Тэрийг нь засаад залруулаад энэ явах бололцоо байна уу, үгүй юу. Эсвэл үгүй юу. Энэ дээр одоо манай Улсын Их Хурлын энэ хуулийнх нь бас тайлбар өгмөөр байна. Үнэхээр процессын алдаа, хуулийн алдаа байгаа юм уу. Хууль зүйн байнгын хороо өгмөөр байна. Төрийн байгуулалтын байнгын хороо өгмөөр байна. Аягүй жижиг асуудал ярьж байна шүү дээ. Агуулгын хувьд болж байна, ерөнхийдөө агуулгын хувьд Үндсэн хуулийн өөрчлөлтийг дэмжиж байна. Гэхдээ процессын энэ алдааг засах ёстой гэж. Үнэхээр тийм зүйл яг байна уу. Энийг яаж үзээд байгаа юм.

**Г.Занданшатар:** Лүндээжанцан гишүүн эхлээд хариулна. Дараа нь Нямбаатар гишүүн процессын алдаа гарсан уу, үгүй юу гэдэг асуулт дээр, Хууль зүйн байнгын хорооны даргаас асуусан.

**Д.Лүндээжанцан:** Би түрүүн Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулчихсан юм. Үндсэн хуульд одоо бидний мөрдөж байгаа Үндсэн хуулийн 68, 69 дүгээр зүйлд туж Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлт гээд биччихсэн юм. Ерөөсөө ингээд тайлбарлахад жаахан хэцүү, ингээд яг тулгаад тулгаад биччихсэн.

Тэгээд 4-т нь Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн нэгэн адил хүчинтэй байна гээд ингээд биччихсэн байхгүй юу. Тэгэхээр бид бол одоо хуулийн хэлбэрээр өөрчлөлт оруулна гээд Журмын хуулийг гаргачихгүй юу. Тэгээд одоо хуулийн хэлбэрээр нь бол явуулсан. Хуулийн бүтэц, зохион байгуулалт, хэлэлцэх журам энэ тэрийг нь бол яг хуулийн хэлбэрээр, яг нэрийн хувьд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэдэг нэрээр явахгүй бол Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль гээд нэрлээд явчихаар Үндсэн хууль, Үндсэн хууль .../минут дуусав/

**Г.Занданшатар:** За, Лүндээжанцан гишүүн нэмэлт 1 минут өгье.

**Д.Лүндээжанцан:** Үндсэн хуульд нэмэлт оруулах тухай хууль гээд ийм гурван эгнээ юм болоод тэгээд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт гэдгээсээ тусдаа асуудал үүсэх гээд, ингээд үүнийг нь үе үеийн 3 парламент дамжиж байна

шүү дээ 2010 оны хууль батлагдсанаас хойш, нэр нь дээр тэгээд явъя гээд, Цэц дээр Ариунболд гэдэг хүн мэдээлэл гаргаад, Цэцийнхэн яг тэр хэсэг дээр Их Хурлын бүрэн эрхийн асуудал гээд орхисон байгаа юм, бага суудлын хуралдаанаар. Цэц ингээд дэмжээд байгаа юм биш үү үүнийг хүлээн зөвшөөрөөд байгаа юм биш үү гэж ярихаар манай хуульчид, тийм биш ээ, яг Үндсэн хуулиа барихгүй бол ганцхан даргатай, энэ бол Үндсэн хууль гэдэг дарга. Тэгэхээр энэ Үндсэн хууль гэдэг Үндсэн хууль, ердийн хууль буюу органик хууль хоёр зөрчилдвөл яг тэр хэсэг дээр бол Үндсэн хуулиа барина гэдэг зарчмыг барихаас ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** За Нямбаатар гишүүн.

**Х.Нямбаатар:** Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5.2.4-т Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэр нь зөвхөн хууль байна гэсэн ийм зохицуулалт байгаа. Энэ удаагийн нэмэлт, өөрчлөлтийн үндсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг барихдаа хамгийн түрүүнд удирдлага болгож байгаа хууль бол сая Лүндээжанцан даргын хэлсэнчлэн Үндсэн хуулийн 68 дугаар зүйл, 69 дүгээр зүйлийг удирдлага болгож байгаа. 68, 69 дүгээр зүйлд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачлагчийг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн Цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно гэдэг бас өргөн мэдүүлэх нэг ийм сонголттой зохицуулалт байгаа. Бид бол хууль санаачлах эрх бүхий субъектүүд, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа гаргасан. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Нямбаатар гишүүнд 1 минут.

**Х.Нямбаатар:** Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүй саналаар ард нийтийн санал асуулга явуулж болно. Санал асуулгыг Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16-д заасныг үндэслэлийн дагуу явуулна гэсэн энэ хүрээнд өнөөдөр ард нийтийн санал асуулга явуулахаар бид нар шийдвэрээ гаргасан. Энэ гаргасан шийдвэрт өнөөдөр Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьсан. Тавьсан хоригийн үндэслэл нь ард нийтийн санал асуулгатай хамаарах заалт нь нэг байгаа, бусад заалт нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл хэлбэрээр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцээгүй гэдэг асуудлаар хориг бичигдэж ирсэн.

Эцэст нь хэлэхэд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нэг, хоёрдугаар хэлэлцүүлэг хийгдсэн болохоос биш Үндсэн хуулийг эцэслэн батлаагүй тохиолдолд хоригийн агуулга нь эцэслэн баталсан Улсын Их Хурлын шийдвэрт тавьж байгаа хориг гэдэг агуулгаараа өнөөдрийн.. /минут дуусав/

**Г.Занданшатар:** За, Дондогдоржийн Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

**Д.Эрдэнэбат:** За баярлалаа. Энэ Ерөнхийлөгчийн хоригийг бид юу гэж харж байгаа вэ гэхээр энэ зэрэмдэг болгосон Үндсэн хуулиа засах, алдаагаа засах боломж гарч байна гэж би харж байгаа.

Үнэхээр Үндсэн хууль нийгмийн зөвшилцлийн гэрээ, хүний эрх, засаглалын тогтолцоог зөв тодорхойлоход чиглэгдсэн юм бол үүнийг бүх нийтийн зөвшилцөл хэлбэрээр явуулж байж л эцсийн үр дүнгээ харна гэсэн байр суурь өнөөдөр хүртэл хэвээрээ байгаа л даа. Тийм учраас энэ хоригийг дэмжих нь зүйтэй гэж бид үзэж байгаа. Яагаад гэвэл гарц юм гэж.

Яах вэ, хоригийг хүлээж авахгүй гэсэн шийдвэр гарч болно. Тэгэхдээ энэ нь өөрөө буцаад яг мухарт гүн шигдэх ийм юм нөхцөл байдал байгаа учраас бид үүн дээр ярилцах нь зүйтэй, зөвшилцөх нь зүйтэй гэдэг байр суурийг өнөөдрийг хүртэл баримталж ирсэн. Тэгэх нь ч зөв. Хоригийг хүлээж авсны дараа ийм хууль задарчих юм гэдэг ийм хоосон, өөрсдийгөө айдаст автуулах нь би буруу гэж харж байгаа. Би Бямбацогт гишүүнийг ойлгож байна. Баахан махийгаад л 57 гишүүнийг цуглуулах гэж ямар их үйлээ үзлээ, одоо ингээд орчих юм бол бүх юм задарчихна гэж. Задрахгүй байх нөхцөл бололцоо бол энд маш олон байгаа. Мэдээж Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт дээр авах юмнууд байгаа, огт хөндөж болохгүй, жишээлбэл баялагтай холбоотой асуудал.

Шүүхтэй холбоотой асуудал, хот, тосгоны эрх зүйтэй холбоотой асуудал, Улсын их хурлын гишүүний хариуцлагатай холбоотой асуудал гэдгийг нэгэнт ороод хэлэлцүүлэгт орсон авууштай зүйл байгаа гэдгийг бид үгүйсгээгүй.

Хоригийг хүлээж авснаараа үүнийг унагаая гэж хэн ч яриагүй. Зүгээр л өөрсдөдөө зохиомол ажил үүсгээд байгаа юм. Бид энэ Үндсэн хууль зэрэмдэг биш, энэ Ерөнхийлөгчийн хориг дээр түшиглээд алдаагаа засаад явах юм бол энэ Үндсэн хууль чинь бүтэн болчих юм биш үү гэдэг энэ зөвшилцлийг бид хүсэж байгаа. Энэ ямарваа нэгэн улс төрийн намын эрх ашиг гэдэг бол нэлээн хол сонсогдоно. Үнэхээр би яагаад энэ хуулийг Үндсэн хуулийг зэрэмдэг болсон юм бэ гэхээр бидний анхны Үндсэн хуулийн өөрчлөлт нь 27 жил биднийг зовоож ирсэн, энэ засаглалын 3 толгойтой энэ засаглалаа цэгцэлье л гэсэн шүү дээ.

Үнэхээр энэ орон ардчилсан Парламентын улс орон мөн бол Ерөнхийлөгчөө Улсын Их Хурлаасаа сонгодог больё л гэсэн шүү дээ. Ерөнхий сайдын илүү power-г өгье л гэсэн шүү дээ. Улсын Их Хурлыг бүрдүүлж байгаа суурь сонголтоо бид нар зөв хийгээд 76 жижиг эрх ашгийг улсын хөрөнгө оруулалтыг үрэн таран хийдэг 76 бие даагч шиг байхаа больё л гэсэн шүү дээ. Мэдээж ард түмний дэмждэг юм бий, дэмждэггүй юм байгаа гэдгийг бид ойлгож байгаа. Тэгэхдээ ард түмний ойлгохгүй юм их байгаа шүү дээ энэ дотор чинь.

Одоо ард нийтийн санал асуулга явуулъя гэнгүүт нь ард иргэдийн ойлгоогүй ард иргэдээс ямар юм асуух гээд байгаа юм бэ гэдэг нь өөрөө маш их бүрхэг болсон шүү дээ. Тийм учраас Ардчилсан нам өөрийн оруулсан энэ зарчмын гол үндсэн хуулийн амин сүнснүүд нь ороогүй учраас энэ Үндсэн хуулийн



хэлэлцүүлэгт орохгүй, ийм буруу зүйлээр ард нийтийн санал асуулга явуулах нь буруу л гэж байгаа шүү дээ.

Тиймээ бид шаардсан. Яагаад шаардсан гэхээр энэ хоёрдугаар хэлэлцүүлгийн дараа бидний хүсээгүй Үндсэн хуулийн төсөл болчих вий гэдгээс болгоомжлон үүнийгээ ард нийтээс асуугаарай гэж шаардсан шүү дээ.

Тийм учраас бусдад буруугаа тохих гээд байгаа юм шиг, ардчилсан нам тэгсэн, нэг ч ард нийтээр асуулгаад хэдүүлээ ингэчихье, болохгүй бол Цэцээ нэг тийш нь болгоод, энэ хууль нь хуучнаараа үлдээсэй гэсэн ийм арчаагүй логигоор бид нар явах нь зөв юм уу. Би буруу гэж харж байгаа. Хэрвээ ийм зэрэмдэг хууль байснаас Үндсэн хууль нь хуучнаараа байсан нь хамаагүй дээр.

**Г.Занданшатар:** Асуултаа асууя, 1 минут нэмж тодруулъя.

**Д.Эрдэнэбат:** Хуучнаараа явсан л хамаагүй дээр. Бид тэгж харж байгаа. Процедурын алдаа гарсан шүү дээ. 73 дугаар тогтоол дээр ард нийтийн санал асуулга явуулах хуулийн нэг заалт зөрчигдсэн шүү дээ. 21-45 хоног гэдэг заалт. Шийдвэр гармагц 21-45 хоногийн дотор ард нийтийн санал асуулга явуулна. Шийдвэр гарсан, тогтоол дээр шийдвэр гаргачхаад тогтоолынхоо шийдвэрийг гаргачхаад өдрийг нь заагаагүй шүү гэж би Их Хурлын даргад тухайн үед нь хэлсэн шүү дээ. Наадах чинь алдаа боллоо шүү гэж. Алдаа шүү дээ. Тэгээд өөрсдийнхөөрөө гүрийгээд байх юм. Тэгээд бид нар адаг сүүлд нь энэ Ерөнхийлөгч хориг тавингуут энэ мухардлаас гарахын тулд зөвшилцье гэсэн болохоос биш бид нар үүн дээр өөрсдийнхөө эрх ашгийг, улс төрийг хийгээгүй шүү дээ.

Ард түмний эрх ашиг байхгүй юу. Нямдорж гишүүн зөв л хэлсэн шүү дээ. Бүгдээрээ зөвшилцөхгүй бол наад хууль чинь явахгүй. Явахгүй ингэвэл. Би харин үнэнийг хэлчихье.

**Г.Занданшатар:** За, Байнгын хорооны дарга Бямбацогт гишүүн асуултад хариулна. Дараа нь Лүндээжанцан дарга, дараа нь Нямбаатар гишүүн.

**С.Бямбацогт:** За яах вэ, заавал юу гэдэг юм бүрэн төгс төгөлдөр болгоно гээд төгс төгөлдөр болохгүй бол байрандаа байж байг гэж бодож болохгүй л байх даа. Хагас ч гэсэн урагшилж байвал, хагас алхам ч гэсэн бас ахиж байвал бидэнд хэрэгтэй л байх л даа.

Нэгэнтээ бид нар Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг хийх гээд 10 гаруй жил оролдоод өдий болтол яваад чадахгүй байгаа, харин өнөөдөр бас хүрсэн түвшин, шийдсэн шийдлээ чамлахаар чанга атга, ямар ч байсан нэг удаадаа зориод зүтгээд иймэрхүү өөрчлөлт хийчихлээ. Дараад нь харж байгаад дахиад нэг зүтгээд, өөр дутагдалтай, өөр засах ёстой асуудлаа засах юм сан гээд бага ч гэсэн урагшаа тэмүүлж л амьдрах ёстой байх аа. Тэгэхгүй бол өнөөдөр бүрэн гүйцэд санасанд хүрэхгүй байна, тийм учраас буцааж ухаръя гэдэг бас зөв зарчим биш байх гэж бодож байгаа юм л даа.

Тэр үүднээсээ та бүгдийг ойлгоод,заавал асуудлыг гацаах барих гэдэг өнгөнөөс биш хагас ч гэсэн бидний зорьж байсан, бүтээх гэж байсан бидний хийж чадаагүй хүмүүс Ардын намын нөхдүүд хийлээ гээд хамтраад яваасай, Монгол улсынхаа төлөө бид нар нэг л улс, нэг л эх орон, нэг л эрх ашиг байгаа болохоос биш бусдаар Ардын намын улс төр, ардын намын эх орон гэж байхгүй, Ардчилсан намын гэж. Тийм болохоор том утгаараа улс орныхоо хөгжлийг, том утгаараа улс орноо ард түмнээ бодоод алхах юм сан гэсэн бодол аль алинд нь байгаа.

Гэтэл нэг нь хагас алхаад, би бүтэн алхах ёстой байсан, тийм учраас буцаад байрандаа, шавартаа шигдээд, доороо хий эргээд байж байя гэж бодох буруу байхаа гэж бодож байна.

Тогтоолд хоёр заалт орсон, нэг нь санал асуулга явуулах, нөгөөдөх нь Үндсэн хуулийн эхийг батлах. Энэ хоёр л Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд хоёуланд нь тодорхой заасан юм.

17.1 дээр Улсын Их Хурал төслийнхөө, энэ хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар хэлэлцээд тухайн нэмэлт, өөрчлөлтийг ард нийтийн санал асуулгаар оруулах нь зүйтэй гэж Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй саналаар тогтвол ард нийтийн санал асуулга явуулах тухай тогтоол гарна гээд. Тогтоол гарна. Үүний дагуу бид нар ард нийтийн санал асуулга явуулах тогтоолоо гуравны хоёр буюу 94.8 хувийн саналаар гаргасан юм.

Хоёр дахь нь 17.3 дээр хоёр дахь хэлэлцүүлгээр зүйл, хэсэг заалт бүрээр тус бүрээр санал хурааж, шийдвэрлэсэн төслийг ард нийтийн санал асуулгад оруулах, эх болгон баталж, уг эхээр ард нийтийн санал асуулга явуулна гээд. Энэ хоёр дахь тогтоол, 17.3-аар бид тогтоолоо баталсан юм. Тогтоол оо. Одоо бид нар гуравдугаарт нь санал асуулгыг хэзээ хэрхэн яаж зохион байгуулах вэ гэдэг тогтоол гарах ёстой. Энэ тогтоол нь үлдчихээд байгаа юм.

Энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль дээр маш тодорхой заасан байгаа. Тийм болохоор бид нар 17.1-д заасны дагуу, 17.3-т заасны дагуу тогтоолынхоо хоёр заалтыг баталсан. Одоо гурав дахь тогтоолоо одоо батална. Үүгээр гурав дахь заалтаар нь, үүгээр бид нар ард нийтийн санал асуулгыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай ард нийтийн санал асуулгыг хэзээ явуулах вэ, хэрхэн явуулах вэ, ямар зардал мөнгөтэй явуулах вэ, яаж явуулах вэ үүн дээр нь төрийн үүрэг болсон.

Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, бүх шатны иргэдийн хурал, засаг дарга, төрийн албан хаагчид Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн эхийг сурталчлах, олон нийтэд түгээж хүргэх үүргийг хүлээнэ гэсэн заалттай.

Энэ заалтыг нь хүртэл оруулаад бид нар гурав дахь тогтоолоо батлах юм. Одоо хоригийн асуудал нэг тийш болсны дараа гурав дахь тогтоолоо батлаад түүн дээрээ хэзээ, хэрхэн, яаж ард нийтийн санал асуулга явуулах вэ гэдэг тогтоолоо

батлах юм. Энэ бас хийгдээгүй байгаа. Тэгэхээр хууль зөрчсөн гэж ойлгож байж магадгүй, энэ бол хийгдэх процесс нь үлдсэн байгаа, хууль ямар нэгэн хууль зөрчөөгүй байгаа гэдгийг бас хэлье.

**Г.Занданшатар:** Лүндээжанцан дарга хариулах уу, Тамгын газар хариулах уу тэр хоригийг хэсэгчилсэн хүлээж авч болох уу, бүхэлд нь хүлээж авах уу, бүхэлд нь хүлээж авах юм бол хууль гээд юу яасан, түүн дээр Тамгын газрын Цогтсайхан гуай хариулах уу албан ёсоор хэлж.

Хориг хэсэгчлэн тавьж болно, хэсэгчлэн болон бүхэлд нь тавина гэж байгаа болохоос биш хэсэгчлэн авна, бүхэлд нь авна гэсэн юм байхгүй гэж хуульчид тайлбарлаад байгаа юм. Авбал тэр чигээрээ л авна.

Энхболд дарга дараа нь тайлбарлана. Цогтсайхан тайлбарлах уу.

**Н.Цогтсайхан:** Үндсэн хуульд Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлын шийдвэрт бүхэлд нь буюу хэсэгчлэн хориг тавина гэсэн заалттай. За, дэгийн хуулийн 31 дүгээр зүйлд Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах эсэх асуудлаар санал хураалт явуулна. Хэрэв хэсэгчлэн хориг тавьсан бол түүнийг нь зүйл заалт бүрээр нь хурааж шийдвэрээ гаргана. Тэгэхдээ зэрэг бүхэлд нь хоригийг хүлээж авах эсэх асуудлаар санал хураалт явагдана.

**Г.Занданшатар:** Энхболд дарга хариулах уу. Хэсэгчлэн авах уу үгүй юу гэдэг чинь зарчмын асуудал болж байна.

**З.Энхболд:** Хоригийг яаж хүлээж авах нь Их Хурлын бүрэн эрх л дээ. Нэг хэсэг нь зөвшөөрөөд нэг хэсэг нь зөвшөөрөхгүй, яаж үүнийгээ гаргах вэ гэдэг талаас нь харах юм бол арга олдох байх, ерөөсөө хоригийг нь унагаачхаад тэр чигээрээ явъя гэвэл арга бас харагдахгүй л байх л даа.

**Г.Занданшатар:** За, Батзандан гишүүн асуулт асууна.

**Ж.Батзандан:** За тэгэхээр Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлын тогтоолд хориг тавьсан байгаа. Ард нийтийн санал асуулга явуулах тухай Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолд хориг тавьчхаад байна.

Эрх баригч нам хоёрхон гарцтай байгаа. Хоригийг хүлээж авбал гурав дугаар хэлэлцүүлгээр батлах нэг гарц байгаа, өөр ямар ч гарц байхгүй. Эрх баригч нам гуравдугаар хэлэлцүүлгээр баталж чадахгүй гэж санаа зовоод нэлээн айдастай байх шиг байна. Хоригийг хүлээж авахгүй гэдэг шийдвэр гарвал Үндсэн хуулийн цэцтэй ноцолдохоос өөр аргагүй байдалд орж байгаа. Үндсэн хуулийн цэцээ дээд суудлаараа шийдвэр гаргачихвал энэ Үндсэн хууль гацаанд орж байгаа юм. Ийм гарцгүй байдалд л 64 суудалтай эрх баригч нам маань орчхоод байна. 19 зүйл 34 заалтыг чинь 10-г нь ШИНЭ нам, Шударга иргэдийн нэгдсэн эвсэл дэмжиж байж, уг нь хоёрдугаар хэлэлцүүлгийг чинь гаргаж өглөө шүү дээ.

Баялгийн сан, стратегийн ордуудын үр өгөөжийн дийлэнх нь монголын ард түмэнд оногдох ёстой гэдэг заалтыг бид оруулсан. Бид үүнийг 100 хувь дэмжиж байгаа. Шүүхийн сахилгын хороо шүүхийн шинэчлэлийг хийсэн. Үүнийг 100 хувь дэмжиж байгаа. Хууль батлах босгыг өндөрсгөж өгсөн. Үүнийг 100 хувь дэмжиж хамгаалах ёстой гэдэг байр суурьтай байгаа. Улсын Их хурлын гишүүн хариуцлага алдсан тохиолдолд эргүүлэн татах тогтолцоог оруулж өгсөн. Үүнийг 100 хувь дэмжиж байгаа. Төсвийн хяналтын механизмыг сайжруулсан, томоохон дүүрэг, сумуудыг хот болгох, хотын статустай болгох асуудлыг оруулж өгсөн гээд олон чухал сайн заалтууд байгаа.

Шударга иргэдийн нэгдсэн эвсэл бол энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг ард нийтийн санал асуулгаар оруулаад батлаад дэмжээд явах нь зүйтэй гэдэг ийм байр суурьтай байгаа. Гэтэл та бүхний хийсэн алдаанаас болоод Үндсэн хуулийн Цэц дээр очиж энэ нэмэлт, өөрчлөлт чинь унах шинжтэй болчихлоо. Танай намын бүлэг эв нэгдэлгүй байгаагаас болоод энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт чинь унах гэж байна. Бүлгийн шийдвэр чинь хоригийг хүлээж авахгүй гэж гарсан гэсэн. Коридороор дүүрэн хоригийг хүлээж авна гэсэн гишүүд явж байна. Эхлээд үүнийхээ учрыг ол. Сөрөг хүчний энэ 7 хүнийг, дээрээс нь ШИНЭ намын 2 руу битгий муухай хар. Бид ард нийтийн санал асуулгын талд байна. Эхлээд та нар минь, 64 суудалтай эрх баригч нам минь учраа олоодох, гараад. Биднийг буруутгах яах вэ та нар учраа ол, өөрсдөө гарч.

Ер нь энэ нэмэлт, өөрчлөлтийн төсөл чинь гацаанд орсон. Гацаанаас гарах уу үгүй юу гэдэг зөвхөн танай эрх баригч намаас, Монгол Ардын намаас хамаарч байгаа юм. Тийм биз, түүнээс биш наашаа хараад муухай хараад байх шаардлага байхгүй шүү гэж би хэлэхийг хүсэж байна. Ер нь эрх баригч намын дотоод зөрчил ужгирч нэлээн хүнд байдалтай болж байна. Залуучууд нь ахмадуудынхаа үгийг сонсохгүй болсон байна. Ахмадууд нь залуучуудаа тоохгүй болсон байна. Наад байдал чинь Монголын төрийг хямрааж байна. Эрхэм эрх баригч ардын намынхан. Одоо та нар гараад учраа ол. Та нар учраа олоогүй цагт Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт явахгүй нь ээ. Бодит байдал ийм л байна. Эрх баригч намынхан дахин хуралдаад учраа ол гэж би зөвлөмөөр байна.

**Г.Занданшатар:** За гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Дараа нь хоёр асуулт байна. Үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ бүртгүүлнэ. Одоо хоёр асуулт байгаа шүү. Болд гишүүнээр, Нямдорж, за өнөөдөр ч, үүний дараа Терроризмг санхүүжүүлэхийн эсрэг хуулийн заавал хэлэлцэхгүй бол энэ долоо хоногт болохгүй байгаа шүү.

Нарантуяа гишүүнээр тасаллаа. Жавхлан гишүүнийх хэн дарсан байна. Хоригийн хугацаа тулсан байна. Хугацаатай юмыг 18.00 цаг гэхэд батлахад, Жавхлан гишүүн, товчхон товчхон үгээ хэлээд явахгүй бол 18.00 цагаас өмнө санал хураалт явуулна, таслаад шууд санал хураалт явуулна шүү. За одоо Эрдэнэбат гишүүн үг хэлнэ.

**Д.Эрдэнэбат:** За баярлалаа, гишүүд ээ намуухан байх уу. Ерөнхийлөгчийн хоригийг бид процедурын алдааг би түрүүн хэлсэн. Хуулийн дагуу зөрчилдөж байгаа заалтуудаа зөв ойлголцох зайлшгүй шаардлагатай гэж Ардчилсан нам үзэж хоригийн асуудлаар Ерөнхийлөгчтэй болон Их Хуралд суудалтай улс төрийн намууд зөвшилцөх шаардлагатай гэж Ардчилсан нам энэ саналыг гаргасан. Энэ бол бидний хоёр дахь санал байсан.

Энд ямарваа нэгэн намын эрх ашиг юм уу, хувь гишүүний эрх ашиг огт байгаагүй гэдгийг бид хариуцлагатай хэлмээр байна. Энэ зөвшилцөл өнөөдөр үргэлжилж байгаа гэж бид ойлгож байгаа. Ганцхан үргэлжлэх нь цааш явах уу үгүй юу гэдэг нь өнөөдрийн энэ хоригийг хүлээж авах үгүй эсэхээс онцгой шалтгаалж байгааг бид бүхэн мэдэж байгаа. Түүнээс биш зарим гишүүдийн ярьдгаар танай манай намын ойлголт, хэн нэгнийхээ улс төрийн эрх ашгийг дээгүүр тавих ойлголт энд огт байж болохгүй. Болохгүй. Хэрвээ энэ хоригийг бид нар хүлээж авахгүй гэж Их Хурал шийдвэр гарах юм бол энэ Үндсэн хууль цаашдаа явахгүй, хуучнаараа явна гэдэг нь ойлгомжтой болно. Тийм учраас бидний эцсийн найдвар юу гэхээр энэ хуулийнхаа алдааг засаад Ерөнхийлөгч, энэ улс төрийн суудалтай намууд, суудалгүй намууд бүгд ойлголцоод үүнийгээ эцсийн боломжийг ашиглах гээд үзье л гэсэн зүйл шүү дээ.

Хэрэв улс төрийн эрх ашгаа бодвол Ардчилсан нам энд огт дуугарахгүй байгаад, та нар бантангаа зуур аа гээд явах шиг хялбар юм алга. Гэхдээ Ардчилсан нам өнөөдөр үнэхээр ардчиллыг, ардчилсан Монгол улсыг бий болгохдоо түүчээлэн оролцсоныхоо хувьд сонгодог парламентыг хүндэлдэг, ардчилсан улс байхыг зорьдгийнхоо хувьд өөр тогтолцоо руу орохгүйн төлөө энэ хуулийг зөв засаглалын тогтолцоо руу оруулахын төлөө саналаа гаргасан юм.

Энд хэн нэгэн гишүүний санал гэж байгаагүй. Харамсалтай нь энэ маань улам бүдгэрч байгаа нь бидний санаа зовж байгаа зүйл шүү гэдгийг би гишүүддээ хэлмээр байна.

Тийм учраас энэ цаг, минутаас хойш танай манай намын тухай асуудал энэ Үндсэн хууль дээр хэдүүлээ цэг тавья. Хэрвээ энэ хоригийг хүлээгээд авчих юм бол бүх юм задраад унана гэдэг айдсаасаа бүгдээрээ салъя. Энэ бол бидэнд тохиож байгаа цорын ганц боломж. Энэ парламентад гэж хэлье. Үнэмлэхүй олон та нар гэж би зүтгүүлэхийг больё. Хэдүүлээ бид нар цөөхүүлээ байгаа ч гэсэн хамтарч байгаад үүнийгээ нэг удаа эр зориг гаргаад хийчих юм бол энэ улс орны Ардчилсан Монгол улсын баталгаа болох нөхцөлийг нэмэгдүүлэх гэж байгаа учраас би Та бүгдийг үүн дээр ухаалаг хандаач гэж хүсэж байна.

Тийм учраас өнөөдөр энэ хоригийг бид нар хүлээж авах нь зүйтэй. Би Монгол Улсын Ерөнхийлөгчийг энэ Ардчилсан Монгол Улсын төлөө байгаа гэдэгт эргэлзэхгүй байгаа. Огт эргэлзэхгүй байгаа. Тэгэхдээ олон янзын санаа бодол энэ нийгэмд сүлэлдэж байгаад бид нар хэн нэгэн рүү нааж зүтгүүл гэж хардаж сэрдэх эрх бид нарт байхгүй. Яагаад гэвэл өнөөдөр бид нар энэ төрийн хамгийн дээд байгууллага. Энэ 76 гишүүний энэ кноп энэ Монгол улсын хувь заяаг шийднэ.

Хэрвээ шийдэж чадахгүй, хэн нэгэнд хардалт байна, бид итгэхгүй, бид итгэлцэхгүй энэ танай намын юм, энэ манай намын юм, маргааш сонгууль болох гэж байна гэвэл энэ л байдлаар хандах юм бол энэ хууль явахгүй. Тийм учраас би нийт гишүүддээ уриалж байна. Энэ хуулийн хоригийг хүлээж авъя. Бүгдээрээ дахиад нэг зөвшилцөөд үзье. Оролдох хэрэгтэй бид нар. Ингээд эцсийн үр дүн Монгол Улсын ирээдүйн төлөө, энэ ардчилсан парламентаа хамгаалахын төлөө гараасай гэж найдаж байгаа шүү гэдгийг та бүгдэд хэлье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** За, Нямбаатар гишүүн.

**Х.Нямбаатар:** Ярихдаа бол маш сайхан ард түмэндээ хайртай болно. Ард түмэндээ эрхээ шилжүүлбэ, ард түмнээсээ асууя, ард түмэн энэ Үндсэн хуулийг батлах эсэх эрхийг нь ард түмэндээ өгье гэхээр үгүй гэнэ, тэгсэн мөртөө ард түмэндээ хайртай, хэрвээ Ерөнхийлөгчийн хоригийг авахгүй бол, авахгүй бол Цэц үүнийг чинь буруутгана гэнэ, Цэцийн урдаас гарах шийдвэрийг урьдчилаад яриад тохирсон, та нар энэ 27 жилийг яг ийм болгож бүтээсэн шүү.

Хэдэн супермаркетаас өөр юмгүй улс болгосон шүү. Бүх өмч хувьчлал, бүх өмч хувьчлал, бүх газар нутаг, газрын доорх баялгийг хэсэг бусад хүмүүс хувааж авцгаасан. Үндсэн хуулиараа Засгийн газраа 1.6 жилийн настай болгосон. Гадаад улс орнуудад Засгийн газар хоорондын комиссын хуралд очиход сайд нь хэдэнтээ солигдсон ийм л дүр зурагтай, тогтворгүй төрийг энэ хорин хэдэн жил бүтээсэн.

Өнөөдөр жаахан тогтвортой болгоё, шүүхээ улс төрөөс хараат бус болгоё, үндэсний баялгийн сан байгуулъя гэхээр үгүй гээд суучихдаг. Энэ цаг хугацаа харуулна.

Энэ хоригийг өнөөдөр олон хүн авахаар шинжтэй харагдаж байна. 2000 оны өөрчлөлтийг Үндсэн хуулийн Цэц дээр шийдсэн гэж яригдаж байна. Ингээд 1996 оны 1996-2000 оны засаглалын тогтворгүй байдал улс төрийн хямрал руу энэ хоригийг хүлээж авсан хүмүүс хөтөлж аваачлаа шүү гэдгийг би энэ дашрамд хэлье.

Би тэгээд нэг хүний зурагтай номыг та бүхэнд харуулъя. Энэ хүн 100 жил адлагдаж хараагдаж байгаа хүн. Бадамдорж гэж хүн. Эрдэнэшанзав Бадамдорж гэж хүн. Тэгэхээр өнөөдөр эсрэг санаа хоригийг хүлээж авах санал гаргасан бүх хүмүүс цаашдаа энэ хүн шиг адлагдана шүү. Би үүнийг хариуцлагатай хэлье. Яагаад гэвэл үүний дараа улс төрийн болон засаглалын маш олон тогтворгүй байдлууд үүснэ. Нөгөө бүх зүйл бахь байдгаараа үлдэнэ. Нөгөө улс төрчид нь шүүхээ захирдаг, бизнесийн бүлэглэлүүд нь баялгаа хувааж эдэлдэг, яг энэ байдал чинь хэвээр үлдэнэ, өнөөдөр энэ хориг дэмжиж санал өгсөн бүх хүмүүс Эрдэнэшанзав Бадамдоржийн хувь заяа хүлээж байгаа шүү.

**Г.Занданшатар:** Баделхан, Хавдисламын Баделхан гишүүн үг хэлнэ.

**Х.Баделхан:** За баярлалаа, Бид өнөөдөр Үндсэн хуулийн өөрчлөлтийн асуудал яриад байгаа. Маргаад байгаа. Гэхдээ энэ бол сүүлийн 16 жилийн дотор

яригдсан зүйл дотроосоо бид нар нэлээн амжилтад хүрсэн байгаа. Амжилтад хүрсэн. Энэ дотроо олон хүний оюун ухаан шингэсэн байгаа. Монголын ард иргэдийн санал бодол, энд шингэсэн байгаа. Би энэ Их Хурлын Үндсэн хуулийн өөрчлөлтийн асуудлаар орон нутагтаа 3 удаа очоод уулзалт хийсэн. Иргэдийн саналыг авчраад энд ажиллаж байгаа ажлын хэсэгт өгсөн. Нэлээн олон санал бол энэ дотор туссан байгаа. Би сая очоод иргэдтэй уулзлаа.

Тэгтэл энэ өнөөдрийн бид нар өөрчилж байгаа зүйл дотор энэ чинь болохгүй байна, тэр чинь болохгүй байна гэж яг хэлж байгаа тийм тодорхой зүйл байхгүй байна. Ер нь иргэд дэмжиж байгаа. Бид нар энэ өөрчлөлтөөр олон асуудлыг шийдэж байгаа. Их Хурлыг хариуцлагдажуулах асуудлыг шийдэж байгаа. Хуулийн босгыг өндөрсгөж байгаа. Засгийн газрын тэр давхар дээлийг нь тайлж байгаа. Одоо олон жил яригдсан, улс төржсөн намын тухай асуудлыг бид нар үүгээрээ бас шийдэж байгаа. Бүр жирийн иргэдийн яриад байсан хот, тосгодын тухай асуудлыг бид энэ Үндсэн хуулиар шийдэж байгаа.

Байгалийн баялгийн асуудлаар ер нь шийдсэн. Хамгийн гол нь шүүх, шүүхийн хараат бусын асуудлаар бид нар Сахилгын хороо байгуулаад ер нь ингээд шүүгээд үзэх юм бол олон асуудлыг бид нар шийдсэн байна. Энэ дотроо эрдэмтэд, мэргэд Монголын ард иргэдийн бүгдийнх нь оюун ухаан энэ дотор орсон гэж би хувьдаа үзэж байгаа.

Энэ өөрчлөлт орсон зүйлүүдийн дотор яг энэ чинь болохгүй байна шүү, энэ буруу байна гээд хэлж байгаа нэг ч зүйл байхгүй байна. Тийм учраас энэ 35 өөрчлөлт бол ер нь бас шүүгээд үзэхэд гайгүй өөрчлөлт болсон байна гэсэн миний хувийн бодол ийм байна.

Бүгдийг нь төгс өөрчилнэ гэсэн ойлголт байхгүй л дээ. Гэхдээ дэвшил гарсан байна гэж. Тийм учраас бид нар анхнаасаа Үндсэн хууль бол ард түмний хууль. Ард түмнээр хэлэлцүүлнэ. Ард түмнээр батлуулна гэсэн хэлснээрээ л тэгээд энэ гарсан өөрчлөлтөө бид нар ард түмнээр хэлэлцүүлээд батлуулаад явах нь зүйтэй, энэ бол дэвшил авчирна гэсэн санал бодолтой байгаа би. Баярлалаа.

**Г.Занданшатар:** За, Баасанхүү гишүүн. Октябрийн Баасанхүү гишүүн үг хэлнэ.

**О.Баасанхүү:** За баярлалаа. Энэ 2016 оны парламентын үр дүнд 3 нам нэг бие даагч энэ парламентыг бүрдүүлсэн юм л даа. Тэгээд гурван нам гэж байгаа боловч нэг нам нь бүлэггүй болоод, хоёр бие даагч гарсан. Нэг нам нь 65 байж байгаад нэг хүнээ алдаад 64 болсон. Тэхдээ 64 гэдэг чинь миний ойлгож байгаагаар энэ хоригийг авна уу, байна уу, сөрөг хүчнээсээ хамаарна уу эс хамаарна уу тэгээд л та нар хүсвэл Үндсэн хуулиа батлаад, хүсэхгүй бол болиод явах эрхийг ард түмэн өгсөн шүү дээ. Ард түмэнд ямар ч буруу байхгүй.

Ардчилсан нам, Хувьсгалт нам, бие даагчид бас ямар ч буруу байхгүй. Тэгсэн хэрнэ өнөөдөр юу гэдэг юм, хориг авах гэж байгаа хүн Шанзав Бадамдорж

шиг болж харагдах гээд, хориг аваагүй хүмүүс нь бол эх оронч болж харагдах гээд, би бол ямар утгаар хориг авах нь зөв гэж бодож байгаа вэ гэвэл одоо ард түмнээс энэ хахир өвөл асууя гэвэл ард түмэн чинь ирц нь хүрэх үү, эс хүрэх үү ойлгомжгүй байдалтай болоод байна л даа.

Хүрэхгүй гээд гацвал энэ ард түмний буруу, та нарт бид гоё юм хийгээд өгсөн чинь та нар өөрсдөө үүнийгээ саналаа асууж чадаагүй гээд ард түмнээ муулах гээд байдаг. За хүрчихлээ, одоо ороод ирээд дэмжихгүй гэвэл бас дахиад адилхан, өө та нарын буруу, яагаад гэвэл хэчнээн гоё болгох гэсэн чинь та нар өөрсдөө дэмжээгүйг өгсөн гээд ард түмнийг буруутгах гээд дайраад байдаг, ард түмнээс асуувал тодорхой юмыг асууя гэж би бодоод байна л даа. Тодорхой зүйлийг.

Тэр тодорхой зүйл маань өнөөдөр юу вэ гэхээр энэ яриад байдаг байгалийн баялаг уу, Их Хурлын гишүүдийн тоо юу, эсвэл сонгуулийн тогтолцоо холимог байх уу гээд тодорхой юм дээр ард түмэн тодорхой хариу өгнө. Түүнээс биш 19 бүлэг 34 зүйлийг бүгдийг нь уншаад энэ та нар гоё болжээ, эсвэл та нар муухай болжээ гээд дүгнэлт хийж чадахгүй, бас л нөгөө профогандаар явна. Тархи угаалтын хүрээнд. Тэгэхээр ийм байдалтай байгаа учраас та нарыг нөгөө төлөөллийн ардчиллын хувьд наадахаа батлаад зөв юм бол цаашаа яв, буруу юм бол больё гээд үзээд байгаа юм. Тэгэхээр Ерөнхийлөгч боломж өгсөн гэж хараад байгаа юм.

Ерөнхийлөгчийн харин миний төслийг харахаар дандаа юмыг бүхэлд нь блоколдгоо одоо болимоор байгаа юм. Төсөв дээр хориг тавихаар төсвийг бүхэлд нь блоколчихлоо гээд хэлэнгүүт за талыг нь аваад талыг нь больчихгүй юу гээд байдаг. Одоо энэ Үндсэн хуулийг бас ярингуут дахиад л хориг тавингуут нь заримыг нь аваад заримыг нь больчихгүй юу гээд байдаг.

Хууль зөрчсөн заалт байна. Бас хуулийн дагуу шийдэх ч заалт байна. Тэгэхээр одоо яаж хэсэгчлэн авах вэ гэдэг гарцыг нь Их Хурлын дарга чиглэл өгөөд санал хураавал ямар вэ гэсэн тийм горимын шинжтэй санал байна. Өөрөөр хэлбэр хоёр удаа санал хурааж болох уу гэж. Эхнийх нь бүхэлд нь хоригийг хүлээж авъя гэдгээр нэг санал хураагаад, хоёрт нь хэсэгчилснээр хураая гэж аваад, яадаг юм ингэхгүй бол Ерөнхийлөгчийнхөө алдааг бид нар засаж өгөхгүй бол том хүн том л юм тавина гэсэн юм шиг дандаа үүнийг хуулийг бүхэлд нь дандаа хориг тавьснаас болоод хуулийн эрэг шураг нь ажиллахгүй байдал руу ороод байна. Тийм учраас дараагийн хориггоо тавихдаа яг тийм тодорхой, эсвэл бүхэлд нь нэг талдаа баймаар байна. Бүхэлдээ авъя, бүхэлдээ ав, яах гээд байгаа юм бэ гээд л болоо. Тэгэхгүй бол заримыг нь авсан ч яах вэ, заримыг нь аваагүй ч яах вэ гээд ингээд яриад байх юм бол энэ төрөөр тоглож байгаа юм шиг болох гээд байна.

Тийм учраас хоригийг хэсэгчлэн авъя гэдэг би горимыг гэдэг юм уу одоо хувийн санал байна. Ер нь бид нарын саналтай саналгүй Ардын намынхан маань ард түмэндээ хүлээсэн хоёр үүргээ биелүүл л дээ, нэг нь Үндсэн хуулиа батлаад өг, та нарыг 65 болгосон, хоёр дахь нь ард түмний амьдралыг сайжруулаад өг, одоо 6 сар үлдлээ, амьдралыг нь сайжруулах бас бололцоо боломж байна шүү. Түүнээс



биш нөгөө буруу нь ард түмэн болоод явмааргүй байна шүү гэдгийг анхааралдаа авна уу. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Эрхэм гишүүн Төмөрбаатарын Аюурсайхан үг хэлнэ.

**Т.Аюурсайхан:** Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг төслөө ард нийтээр бас дүнгээ тавиульъя гэдэг ийм шийдвэр гаргаад явж байна. Ерөнхийлөгчийн энэ ард нийтээр асуух шийдвэр дээр хориг тавьсан байгаа. Шулуухан хэлэхэд Ерөнхийлөгчийн хоригийг хүлээгээд авах юм бол Үндсэн хуулийн энэ оруулаад байгаа нэмэлт, өөрчлөлт цаашид явахгүй. Шууд зогсоно.

Яагаад гэвэл зөвшилцөл гэж дахиж хийгдэх боломжгүй. Зөвшилцлөөр Ардчилсан нам юу хүсэж байна вэ гэвэл гишүүдийн тоог 108 болгох, бүрэн эрхийн хугацааг 5 жил болгох, намын жагсаалтаар сонгогддог болгох энэ тогтолцоог шахаад байгаа юм. Ийм шахалт зөвшилцөл явах юм бол би жишээлбэл би энэ хэлэлцүүлэгт оролцохгүй. Ийм хүмүүс өчнөөн байгаа, Их Хуралд. Гуравны нэг байтугай байгаа. Тэгэхээр энэ зөвшилцөл чинь явагдахгүй. Энэ бол маш тодорхой.

Нөгөө талаас шүүх дээр байгаа асуудлыг шүүхийн хараат бус байлгах заалтуудыг хас, багасга, Ерөнхийлөгчийн эрхийг хассан энэ зүйлүүдийг болиулж эрхийг нь нэм гэдэг шахалтууд чинь орж ирнэ зөвшилцөл нэрийн цаана. Үүнийг чинь би жишээлбэл зөвшөөрөхгүй. Ийм гишүүд гуравны нэг байтугай байна. Ингээд 57 чинь хүрэхгүй.

Ингээд юу харагдаж байна вэ гэвэл энэ зөвшилцөл чинь явагдсангүй гэдэг үндэслэлээр гуравдугаар хэлэлцүүлгийн чинь ард эцэслэн батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр чинь Ерөнхийлөгч хориг тавина, тодорхой. Хориг тавиад цаашлаад Үндсэн хуулийн цэцэд өгнө. Одоо бид нар яаж байна вэ гэвэл эцэслэн батлаагүй, ард нийтээрээ батлуулъя гэдэг утгаар өөрөөр хэлбэл ард нийтийнхээ дархлаа дотор нэмэлт, өөрчлөлтөө өлгөйдөөд, тийшээ аваачих гээд ингээд зүтгээд яваад байгаа байхгүй юу.

Түүнийг нь замаас нь таслан зогсоогоод энэ дотроо шийд гээд, ард нийт юу гэж ойлгох юм, эрхээ эдлэх гээд хүлээгээд байна шүү дээ. Гэтэл янз бүрийн нэрээр цоллуулсан хүмүүс эцсийн хэлэлцүүлгээ энд хийгээд зөвшилцөл нэрийн цаана хуйвалдаад, ингээд эндээ нугаслахыг зөвшөөрөхгүй шүү дээ. Дэмжихгүй. Тэрийг нь ашиглаад ард нийтийн дэмжлэггүй болгоод, дээр нь энэ Их Хурал дээр зөвшилцөлгүй болгож байгаад энэ нэмэлт, өөрчлөлтийг чинь байхгүй болгох гээд байна шүү дээ.

Ард нийтийн санал, Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авахгүй бол яах вэ гэх юм бол бид ард нийтийн санал асуулгаа товлон. Ирэх жил санхүү мөнгө яривал ирэх жилийн сонгуультай хамтатгаад хийж болно. Санхүү мөнгөө танаад хугацаа сонгоё гэх юм бол хавар юм уу намар хийж болно. Ингээд явах юм бол Ерөнхийлөгч энэ нэмэлт, өөрчлөлтийн төсөл дээр хориг тавих боломжгүй чадахгүй, Цэц хэлэлцэж чадахгүй, яагаад гэвэл эцэслэж батлаагүй яваад байна. Харин энэ

тогтоолоо Цэцэд өгөх байхгүй юу. Цэц дээр хараг л дээ, хэн яагаад унагаах гээд байгаа юм. Ард нийт нэг талдаа эрхээ эдлэх гээд хүлээгээд байдаг, нөгөө талаас нь үүнийг нь унагаая гээд байдаг, үүнийг нь хараг.

Ийм нөхцөл байдал үүсээд байгаа юм. Тэгээд ер нь ойлгомжтой, хоригийг хүлээж авна гэдэг нэг талд гишүүдийн нэрс сонгогчид нь харж байгаа, ямар хүмүүс байна, манай ШИНЭ намын дарга Батзандан маань ард нийтийн санал асуулгаа дэмжье гэж хэлсэнд би талархалтай байна.

Ард нийтээрээ дүгнэе гэж байгаад талархалтай байна. Яагаад гэвэл нөгөө талд, нөгөө бид нарын хүчээр авч хаях гэсэн, жагсаж цуглаад өргөөд хаяъя гэж зүтгэсэн Миеэгомбын Энхболд чинь ингээд нөхөдтэйгөө байж л байгаа. Нөгөө хонины хонхрын гээд байгаа нөгөө нөхөр чинь байж л байгаа.

Яг хот, тосгоны ялгараад л энэ санал хураалт дээр хэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг нугаслах, хэн ард нийтийн санал асуулга руу явуулахгүй байгаа нь гараад л ирнэ. Тийм учраас тэнд тийм бүлэглэлтэй нэг болоод цаашлаад явах ийм асуудал байж болохгүй гэдгийг ойлгоод, зарим гишүүд нь ард нийтийн санал асуулга руу явуулья гэдэг дээр бас талархалтай байна.

Тэгээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бол дахин хэлэхэд 100 хувь хүссэн санаснаар болоогүй ч гэсэн маш тодорхой асуудлуудыг байгалийн баялаг, Шүүхийн хараат бус байдал, Улсын Их Хурлын хариуцлага, гишүүдийн хариуцлага, давхар дээл, төсвийн хараат бус, хот тосгоны эрх зүй гээд нэлээн олон чухал заалтуудыг бид нар шийдчихээд явж байгаа юм.

Энэ бүгдийг эсэргүүцэх эсэргүүцэлтэй тулгараад өнөөдөр хориг бас нэлээн эрсдэлтэй эвгүй явж байна л даа. Гэхдээ яах вэ эцсийн дүнд санал хураалтаар шийднэ. Ямар ч байсан ард нийтийн санал асуулга руугаа энэ өнөөдрийн авч гарсан асуудлуудаа явуулья гэдэг ийм байр суурьтай байна. Ерөнхийлөгчийн хоригийг дэмжихгүй байна. Байнгын хорооны саналыг дэмжихгүй байна.

**Г.Занданшатар:** Эрхэм гишүүн Содномзундуйн Эрдэнэ гишүүн үг хэлнэ.

**С.Эрдэнэ:** За баярлалаа. Юуны өмнө эхлээд нэг зүйл хэлмээр байна. Энэ гишүүд бие биеийнхээ бүрэн эрхэд халддагаа болимоор байна. Тэгвэл тэгж харагдана шүү, ингэвэл ингэж харагдана шүү, одоо бараг түрүү Нямбаатар нэг Эрдэнэшанзав Бадамдоржийн ном барьчаад хүн дарамтлаад, одоо Аюурсайхан болохоор урвагч дүлзэнгээр нь дуудаад хүмүүсийг нэр устай нь зарлаад, энд хэн ч хэнээсээ илүү эрх дарх эдлэхгүй шүү. 76 Их Хурлын гишүүн бол бүгдээрээ ард түмнээсээ сонгогдсон тэгш эрхтэй гишүүд байгаа. Хэн ямар асуудалд яаж хандах нь тухайн гишүүний бүрэн эрхийн асуудал. Түүнийг нь янз бүрээр гуйвуулаад л, микрофон ашиглаж улс төр хийгээд л, түүгээрээ яах гээд байгаа юм, рекэтлэх гээд байгаа юм уу, яах гээд байгаа юм. Одоо намын дотооддоо хэнийгээ яаж хаана жагсаж, цуглаж авч хаясан чинь та нарын л асуудал шүү дээ.

Өөрсдөө дотооддоо зодоон хийчхээд түүнийгээ ард түмний нэр барьж цайруулаад, шударга үйл хийсэн юм шиг, та нар дотроо бие биеэ аваад хаясан, үүнийг зайлуулчихвал амьдрал сайхан болно гээд Монгол улс хөгжих юм ярьцгаагаад байсан. Тэгээд өнөөдөр сайхан болоод хөгжсөн юм хаана байгаа юм. Улам л дордож байна шүү дээ. Улам л амьдрал байхгүй болж байна. Өнөөдөр долларын ханшийг хар, махныхаа үнийг хар, цахилгаан эрчим хүчнийхээ үнийг хар, нэмэгдээгүй татвар байна уу, нэмэгдээгүй хураамж байна уу, ард түмэн чинь цаана чинь ядарч байна, туйлдаж байна шүү дээ, юу та нарын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, бантан шиг юм хийчхээд тэрийгээ их гоё одоо эх оронч сайхан юм хийгээд, түүнийг нь хүн батлахгүй, Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьсан ч юм шиг, ийм юм ярьдгаа больё.

Яг үнэндээ бол гадагшаа гараад амьдралтай танилц л даа. Та нар дэлгүүр хоршоо ордог юм уу. Зах дээгүүр явдаг юм уу та нар. Гэр хорооллоор ордог юм уу. Яваад амьдрал үз л дээ. Ямар байна амьдрал цаана чинь. Ийм юм ярихын оронд бие биеэ шантаажлаад, хэрвээ тэгж санал өгвөл тэгж харагдана шүү, ард түмэн харж байгаа шүү гээд, яадаг юм харж л байг, яадаг юм тэгээд Их Хурлын гишүүн өөрийнхөө итгэл үнэмшлээр саналаа өгнө шүү дээ. Тэрийг чинь дарамтлаад шантаажлаад байх хэрэг байхгүй л байхгүй юу. Ийм зүйлийг нэгдүгээрт хэлмээр байна.

Хоёрдугаарт, би түрүүн хэлсэн шүү дээ. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн анх орж ирж байсан санал дотор бас гялайж гялтайх юм байсан юм. Ганц нэг юм байсан. Бүгдийг нь өөрсдөө унагаасан шүү та нар. Бүгдийг хасаж унагааж хаячхаад одоо Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хоёр дахь төсөл гээд байгаа юм чинь холион бантан шиг юм байгаад байгаа шүү дээ. Юун Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах. Юун ахиж дэвших, ийм юмаа баталбал нэгдүгээрт, Улсын Их Хурлын бүрэлдэхүүнийг батлуулах боломж бүрдэхгүй гэж харчхаад хоёрдугаарт, дараа нь үүрэг хариуцлагаас зугатахын тулд та нар ард нийтийн санал асуулгаар энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлуулаад дараа нь юу гэж хэлэх байгааг би мэдэж л байна шүү дээ та нарыг.

Ард түмэн л баталсан шүү дээ. Бид нар батлаагүй, ард түмэн баталсан шүү дээ. Ард түмнээсээ асуухгүй юу, асуу та нар, ийм улс төрийн зальтай башир аргаа хэрэглэдгээ боль. Энд хэрвээ юм хийж байгаа бол хариуцлагаа хүлээж сур. Үүрэх ёстой тэр үүргээ, хариуцлагаа үүрч сур л даа. Тэгж байж улс төр хийнэ шүү дээ.

Тэгээд одоо аль нэг улс төрийн нам руугаа, сөрөг хүчин рүүгээ хамаг юмаа чихээд л, хоёрдугаарт гэвэл хэн нэг хүнийг цоллоод л, би одоо гайхаад байгаа юм. Аюурсайхан бол Миеэгомбын Энхболдын татаасаар гарч ирсэн биз дээ. Одоо юм л бол муу бол баруун хойд талын хар овоотой гэдэг шиг л үргэлж нулимж дэвсэж байх юм. Одоо болиоч, болохгүй юм уу. Чи залуу хүүхэд байж боль л доо чи. Арай дэндэж байна, доголлон ч бай. Тэгээд бүрэн эрхийн асуудлыг одоо онцгой авч үзээрэй. Ёс зүйн дэд хорооны даргаа, энэ асуудал хариуцсан. .../минут дуусав/

**Г.Занданшатар:** Одоо эрхэм гишүүн Лувсанвандангийн Болд үг хэлнэ.

**Л.Болд:** За баярлалаа. Эхлээд энэ зөвшилцлийг хийхийн тулд өнөөдөр энэ хоригийг авч дэмжих ёстой гэдэг байр суурийг бид илэрхийлсэн. Үүний цаана ганцхан зорилго байгаа юм. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт өнөөдөр бүтээсэй, болоосой зөв гараасай л гэдэг л ганцхан үзэл санаан дээр бид нар өнөөдөр очсон.

ШИНЭ нам бол анхнаасаа Үндсэн хуульд өргөн барьж байсан Үндсэн хуулийн бодлого хэрэгжиж байсан, өнөөдөр Их Хурал дээр хэлэлцэж байсан энэ бүх асуудал дээр маш эсрэг байр суурьтай байсан.

Бид хэзээ энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бол дэмжих байр сууринд шилжсэн бэ гэхээр баялгийн заалт орж ирсэн тэр цагаас, өөрөөр хэлбэл энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөр хэрвээ Монголын ард түмэн баялгийнхаа тэр тусмаа стратегийнхаа ордын эзэн болж чадахгүй бол энэ Үндсэн хуулийн ёс төдий, хэлбэр төдий өөрчлөлт хэрэггүй гэдэг байр суурь дээр хатуу байсан шүү.

Бид эцсийн шатанд 20 гаруй гишүүн бараг бослого гаргаж байж, энэ Үндсэн хуулийн энэ хэлэлцүүлэг дээр баялгийн заалтаа 100 хувь чадаагүй ч, гэхдээ 70 хувьтай энэ заалтаа баталсан. Одоо энэ Үндсэн хууль цаашдаа өөрчлөлт гарах эсэх нь тэр заалт дээр очиж шийдэгдэнэ. Тэр 20 гишүүн энэ заалттайгаа хамт энэ Үндсэн хуулийг батална. Дээр нь мэдээж олон гишүүдийн ярьж байгаа заалтууд байгаа. Тэр бүгд бол сайн муу, дутуу дулимаг янз бүрийн юм бий, гэхдээ бүхэлдээ бол баялгийн заалтаа титэм болгоод орох юм бол энэ Үндсэн хуулийг дэмжихэд бэлэн байна гэдэг асуудал байгаа юм.

Эцсийн эцэст одоо бол хоригийг авах авахгүй гэдэг талцал өнөөдөр хэрэггүй. Өнөөдөр бидэнд юу хэрэгтэй вэ гэхээр энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт үнэхээр ард түмэнд баялгийг өгөх ийм шийдвэр болж чадах уу үгүй юу гэдэг ийм зөвшилцөл хэрэгтэй. Тийм учраас түрүүн Батзандан гишүүн хэлж байсан. Үнэхээр энд бид нар хуваагдаад, кнопоор асуудал шийдэх гээд байгаа асуудал биш, Байнгын хорооны нэг нь дэмжсэн, нэг нь дэмжээгүй, угаасаа энэ чинь нээлттэй байгаа шүү дээ. Одоо бол олонхын бүлэг, цөөнхийн зөвлөл Ардчилсан намтай, мөн Ерөнхийлөгчтэй энэ асуудлаа зөвшилцөж, шийдлээ хэрэгжүүлээд өнөөдөр энэ хоригийг шийдэх ийм нөхцөл байдал бүрдэнэ гэж бодож байгаа.

Ерөнхийлөгчийг бид өнөөдөр хориг тавьж, энэ Үндсэн хуулийн процесс цаашдаа яваасай, зөв яваасай гэж нааштай алхам хийж байгаа гэж харж байгаа. Анхнаасаа Ерөнхийлөгч бол дандаа гадна талд нь үлдээгээд, яг л дордуулсан долоо шиг процесс явсан шүү дээ.

Тэгэхээр Ерөнхийлөгч үнэхээр алхам хийсэн байхгүй юу. Алхам хийгээд энэ Үндсэн хуулийн дундуур нь орж ирээд, саналаа өгөөд, хэлэлцүүлээд, бүх зүйлийг хүлээн зөвшөөрүүлээд дээрээс нь ажлын хэсэг байгуулаад, тэнд нь ахлагчаар нь ажиллаад, ажлын хэсгийг олон удаа хуралдуулаад ингээд бүх үйл явц чинь явсан

байхгүй юу. Ерөнхийлөгч байсан учраас. Одоо та нар хоригийг нь авахгүй гэхээд Ерөнхийлөгч та одоо бидэнд хэрэггүй, бид Ерөнхийлөгчгүй, Ардчилсан намгүй, цөөнхгүй ингээд бид нар явчихна, ард түмнээр санал асуулга хийхээр ард түмэндээ найдаж байна гэдэг ийм үл бүтэх, үл гүйцэлдэх ийм санаанд өнөөдөр хууртагдаж, өөрсдийгөө буруу замаар чиглүүлж чирч болохгүй.

Үүнийг цөмөөрөө нийлж байгаад юуны төлөө бид Монголын төлөө гэж бүгдээрээ сонгогдсон хүмүүс байгаа шүү дээ. Ерөнхийлөгч ч ард түмнээс сонгогдсон, энд байгаа бүх гишүүд тэгж сонгогдсон. Энэ дотор Монголын дайсан байхгүй.

Тэгээд цөмөөрөө зөвшилцөөд энэ Үндсэн хуулиа үнэхээр ард түмэнтэй нэгдээд гаргавал гаргая, үгүй бол үнэхээр тэр баялгийн заалт унагаах гэж байгаа бол хэрвээ үүний цаад процесс ерөөсөө Үндсэн хуулийг унагаах гэж байгаа бол бид энэ бүх процессыг зогсоод харин тэр дордуулсан долоон заалтыг яаралтай хүчингүй болгох, энэ шаардлагыг бидний зүгээс хатуу тавих болно гэдгийг та бүхэнд мэдэгдэж байна.

**Г.Занданшатар:** За, 6 цаг болж байна, ажлын цаг тарж байгаа учраас энэ дараагийн асуудлыг хэлэлцэж дуустал Их Хурлын чуулганыг сунгая гэсэн саналтай байна. Гишүүд, олонх дэмжиж байгаа учраас хуралдааны цагийг сунгалаа. Одоо Лүндээжанцан гишүүн үг хэлнэ.

**Д.Лүндээжанцан:** Энэ үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулах, хэлэлцэх ард нийтийн санал асуулгад тулж ирсэн энэ процессыг, түүхийг яриад хэрэггүй байх гэж бодож байна.

Аль болохоор бид бүхэн ойлголцож зөвшилцөх, тэгээд энэ амаргүй замаар, бартаатай замаар л явж хэдийгээр удаан явлаа л даа. Тэгэхээр энд тултал л явахаас өөр аргагүй. Ард нийтийн захиалга байгаа. Ялангуяа энэ манай залуу үеийн захиалга байна, бид ямар нийгэмд амьдрах вэ гэдгээ харж байгаа байхгүй юу. Үүний замыг нь засах хэрэгтэй байна л даа бид бүхэн. Энд бүх хүний хариуцлага, үүрэг хариуцлага байгаа.

Тэгээд одоо бидэн дээр процессын алдааны тухай яриад байгаа юм, дэлхий эргэдэг гэдэг шиг, ямар ч байсан дэлхий эргэдэг гэсэн ч хэдийгээр дэлхий эргэдэггүй гэж хүчээр байсан ч гэсэн яг бид бол энэ хуулийн дагуу л явсан гэж үзэж байгаа. Таван асуудал дээр үнэхээр гишүүд болоод олон түмэн ч гэсэн дэмжихгүй байгаа юм.

Ерөнхийлөгчийг Улсын Их Хурлаас сонгодог болох, Ерөнхий сайд сайд нараа томилох, чөлөөлөх, холимог тогтолцоо, гишүүдийн тоо, бүрэн эрхийн хугацаа гээд тэгээд энэ нэг хэсэгт нь бол санаанд нь хүрэхгүй байгаа нь үнэн. Гэлээ гэхдээ бидний оруулсан энэ манай нийт манай Их Хурлын өнөөгийн байгаа 75 гишүүний ямар ч байсан боосон байгаа төсөл дотор бол түрүүчийн гишүүдийн ярьдаг шинэчлэл, өөрчлөлтүүдийг авчрах зүйл бишгүй байна.

Нэг нэгээр нь задлаад яривал урт хугацаа орох учраас. Үүнийг бид хийвэл 2020 оноос эхлээд үр дүнгээ өгнө. 4-5 жилийн дараа үр дүн нь харагдаад эхэлнэ гэж бид харж байгаа юм.

Үүнийгээ ингэж хийж чадахгүй үрэн таран болгох юм бол ёстой харамсалтай байна, харамсаад ч барахгүй бид бүхэн бүгдээрээ хариуцлагаа хүлээх ёстой болж байгаа юм. Энэ дотор одоогийн оруулж байгаа төслүүд дотор янз бүрээр л шүүмжилж байна. Бидэнд ярих цаг олох байх гэж бодож байна. Энэ заалтууд бол цөм амьдралаас ургаж гарсан заалт. Тэр дордуулсан долоо гээд байгаа зүйлийг чинь зассан заалтууд байгаа жишээ нь, хамгийн наад зах нь. Ингээд яривал олон зүйл байна. Бид аль болохоор хатуу үг бие бие рүүгээ чулуудахгүй, аль болохоор ойлголцлын төлөө явъя гэдэг байр сууриар хандаж ирсэн. Цөмөөрөө үүнийгээ гаргахын төлөө гэж ярьж байгаа юм. Яг амьдрал дээр тулаад очихоор маш их ашиг сонирхол байдаг юм байна.

Үүнийг анх гаргаж ирсэн цагаас эхлээд л нэгдүгээр эрх ашиг бол Монгол улсын эрх ашиг, хоёрдугаарт нь ард түмэн, одоо болон дараа үеийн, тэгээд тэр намын эрх ашиг гэдэг бол 4-5-д л орно, хувийн эрх ашиг нь хамгийн сүүлд тавиач гэдгийг би гуйж хүсэж ажиллаж ирсэн, тэр зарчмыг. Энэ ашиг сонирхлын эрэмбэ гэдэг бол чухал байгаа юм. Бид бүхэн эндээс үргэлж санаа зовж байгаа, энэ заалтууд амьдрал дээр хэрэгжээд эхлэхээр ямар эрсдэл үүсэх бол гэдгээс байнгын санаа зовж байгаа. Харин эрсдэл багатай гаргахын төлөө явж ирсэн.

Ийм учраас гишүүд маань та нар 10 дугаар сарын 30-31 –нд гэж тооцоог нь бодоод санал асуулгаа явуулъя гээд бид нар оруулаад ирсэн шүү дээ.Одоо ингээд .../минут дуусав/

**Г.Занданшатар:** Батзандан гишүүн, Жалбасүрэнгийн Батзандан гишүүн үг хэлнэ.

**Ж.Батзандан:** За баярлалаа. Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсан ч хүлээж аваагүй ч зовлон тийм амархан арилах шинжгүй харагдаж байна. Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж аваад гуравдугаар хэлэлцүүлгээр энэ баялгийн асуудал чинь давж гарч ирнэ гэдэгт би лав итгэхгүй байна.

Стратегийн ордуудын үр өгөөжийг ард түмэнд дийлэнхийг нь хүртээнэ гэдэг энэ заалтыг оруулах гэж мөн их тэмцэл болсон доо. Болбол үүнийг унагах гэж л олон хүн дотроо, ялангуяа олигархууд, манангийнхан энэ чиглэлд бодож байх шиг байна.

Би одоо хэдхэн минутын дараа санал хураалт явах гэж байна, Ерөнхийлөгчийн хоригийн асуудлаар. Том ажлын хэсэг гэж байгаа. Зөвшилцлийн ажлын хэсэг гэж байгаа. Гараад нэг уулзаж болдоггүй юм уу. Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ахлуулсан ажлын хэсэг гэж байгаа, энэ ажлын хэсгүүд нь гараад

санал хураалтаас өмнө ойлголцол руу явж болдоггүй юм уу гэдэг ийм саналыг хэлэх гэж байгаа юм.

Шинэ намын хувьд өнгөрсөн 30 жилийн завхралыг засахын тулд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг дэмжиж байгаа. Ялангуяа Монголын томоохон ордууд, хэдхэн сарын өмнө хэдхэн гэр бүлд очсон байсныг зогсоохын төлөө бид тэмцэж байгаа.

Эрдэнэт бүхэлдээ Худалдаа хөгжлийн банканд. Цагаан суварга бүхэлдээ мафийн мэдэлд, нэг бүлийн мэдэлд. Нэг гэр бүлийн мэдэлд 4 стратегийн орд нь очсон ийм улс дэлхий дээр Монголоос өөр байхгүй. Уул уурхайн томоохон ордуудаа гаднынхны мэдэлд, Хятадуудын мэдэлд 100 хувь өгдөг улс Монголоос өөр байхгүй. Үүнийг өөрчлөх гэж л Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт явсан гэж би ойлгож байгаа. Энэ ч утгаараа баялгийн сан, стратегийн ордуудтай холбоотой эзэмшил өмчлөлтэй холбоотой заалтууд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр орж ирсэн юм. Энэ заалтаар би ШИНЭ нам эцсээ хүртэл хамгаалах болно гэдгийг та бүхэнд хэлэхийг хүсэж байна.

Шүүхийн сахилгын хороо, шүүхийн ерөнхий зөвлөл, шүүх засаглалын салбарт хийж байгаа реформ шинэчлэлээ ШИНЭ нам эцсээ хүртэл хамгаална. Эцсээ хүртэл хамгаална.

Төсвийн хулгайг зогсоохын тулд төсвийн сахилга бат, төсвийн хяналт, төсвийн орлого зарлагыг тодорхой хэмжээнд байлгах, нэмэгдүүлэхгүй байх хязгаарлалтуудыг дэлхийн жишиг болсон заалтуудыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр оруулсан. Эдгээр заалтуудаа хамгаалахын тулд ШИНЭ нам эцсээ хүртэл тэмцэнэ гэдгээ Та бүхэн хэлье.

Ингээд эрх баригч намыг санал хураалтаас өмнө зөвшилцлийн ажлын хэсгээ нэг хуралдуулаад, энэ том нийгмийн гэрээг Монгол улсын тулгуур болсон, амин сүнс болсон энэ хуулийнхаа асуудлыг дахиад нэг Ерөнхийлөгчтэйгөө зарим нэг гомдол мэдүүлээд байгаа сөрөг хүчний хэдэн гишүүдтэйгээ уулзаад яривал яасан юм бэ гэсэн саналыг тавьж байна.

**Г.Занданшатар:** Цэндийн Нямдорж гишүүн үг хэлнэ.

**Ц.Нямдорж:** Би татлаа.

**Г.Занданшатар:** Сандагийн Бямбацогт гишүүн үг хэлнэ.

**С.Бямбацогт:** Ер нь бас сайн ярьсан л даа. Зөвхөн өнөөдөр ярьж байгаа биш. Өнгөрсөн бүтэн сар, өнгөрсөн бүтэн зун, өнгөрсөн хоёр жил, өнгөрсөн 10 жил Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг ярьж байгаа. Өдий хүртэл боогоод ирсэн төслөө цааш нь явуулчих юм сан гэсэн сонирхол хүн болгонд байгаа байх. Зарим нэг нөхөд маань явуулахгүй байх сонирхол ч байж магадгүй.

Хамгийн гол нь гурав дахь хэлэлцүүлэг хийгдэх юм бол сая Батзандан гишүүний хэлж байгаа, зарим гишүүдийн хэлж байгаа нэлээд олон юм болж байж боосон, цэгцэлсэн тодорхой асуудлыг шийдсэн шийдлүүд маань үрэн таран болчих вий гэдгээс болгоомжилж байгаа юм.

Тийм үүднээсээ бид нар Ерөнхийлөгчийн хоригийг бас авахгүйгээр ард нийтээс асуугаад явчихвал яасан юм бэ гэдэг дээр байр сууриа илэрхийлж байгаа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бид нар шийдэж байгаа хэдэн асуудлыг хэлье.

Үндсэн хуулийн 6.2-т төрийн өмч тийм үү, төрийн нийтийн өмч болон байгалийн баялагтай холбоотой тодорхой заалт орж ирж байгаа. Байгалийн баялгийг тогтвортой нэгдмэл бодлогогүйгээр ашиглаж ирсэн дутагдлыг арилгая. Цаашдаа төрөөс тодорхойлсон урт хугацааны хөгжлийн бодлогыг баримтлан байгалийн баялгийг ашиглая, ингэж ашиглахдаа байгалийн эко системд эрсдэл учруулахгүй байя, байгалийн тэнцвэртэй байдлыг хангая, одоо ба ирээдүй үеийнхний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангая, стратегийн ордыг ашиглахдаа бас стратегийн ордын үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногддог байлгая гэх мэтийн тодорхой заалтыг оруулж өгсөн.

Сонгуультай холбоотойгоор, сонгууль болохоос нэг жилийн өмнө сонгуулийн хуулийг баталдаггүй байя. Урд нь сонгууль болохоос 6 сарын өмнө нэг сонгуулийн хуулийг батлахгүй байя гэдэг мөртөө хоёрхон сарын өмнө сонгуулийн хуулийг өөрчилж баталж байсан туршлага бидэнд байгаа. Ийм байдлаар эрх барьж байгаа нам өөрсдийнхөө үзэл бодолд нийцүүлж, өөрснөө давуу байдлыг бий болгохын тулд сонгуулийн хуулийг баталдаггүй байх заалтыг Үндсэн хуульд суулгаж өгсөн.

Төсвийн хариуцлага, хөгжлийн бодлоготой холбоотой Монгол Улсын урт, дунд, богино хөгжлийн бодлогоо тодорхойлдоггүй, Монгол Улс маань төрийн өөрийн гэсэн хар хайрцгийн бодлоготой байя, үүнд нь гишүүд өөр өөрсдийн дур сонирхлоор үзэмжээрээ ханддаг, 76 Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэдгийг больё.

Төсвийн зарлагыг нэмэгдүүлэхгүй байх тал дээр бас тодорхой заалтыг Үндсэн хуульд суулгаж өгсөн. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцөх ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн гаргасан Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлаар санал асуулга явуулахгүй байх ёстой Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалд халдах аливаа оролдлогыг үл зөвшөөрнө гэсэн томхон заалтыг оруулж өгч байгаа. Улсын Их Хурлын гишүүдийн хариуцлагатай холбоотой бас тодорхой заалтыг оруулж өгч байгаа.

Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй бол Үндсэн хууль зөрчих юм бол эргүүлэн татдаг болох заалтыг бас оруулж өгч байгаа.

Улсын Их Хурлын гишүүд бас Засгийн газрын гишүүний ажлыг давхар хашдаг байдлыг цэгцэлье, давхар дээл, давхар дээлээ даадаггүй асуудал, үүнийг



шийдье гэдэг тодорхой заалт оруулж ирсэн. 4-өөс илүүгүй гишүүн Засгийн газрын гишүүн байж болохгүй Улсын Их Хурлын гишүүний гэдэг заалт оруулж өгсөн.

Шүүхийн ерөнхий зөвлөлтэй холбоотой, урьд нь хуулиар Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг дур дураараа өөрчилдөг байсан дутагдлыг арилгая. Үндсэн хуульдаа тодорхой зааж өгье. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тоог 10 байя, 5-ийг нь шүүгч дотроосоо өөрсдөө сонгодог байя, 5-ийг нь хараат бус байдлаар гаднаас сонгодог байя, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг өөрсдөө шүүгч нар дотроосоо сонгодог байхаар ийм шүүхийг аль болох хараат бус үйл ажиллагаа явуулдаг байх заалтыг оруулж өгсөн.

Мөн Шүүхийн сахилгын хороог Үндсэн хуульд оруулж өгч, шүүгчийн хариуцлага, сахилгын тогтолцоог тодорхой тогтвортой болгох, ийм бие даасан бүтцийг бий болгож өгөх, 21 аймгийн төв, Дархан, Эрдэнэт гээд хотуудыг хот шиг хот болгох, 1992 оны Үндсэн хуулиар бүгд сум болсон байгаад байгаа, энэ асуудлыг шийдэх, хотуудад, орон нутагт эрх мэдлийг шилжүүлэх, төвлөрөлийг сааруулах ийм тодорхой асуудлуудыг... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Эрхэм гишүүн Загдхүүгийн Нарантуяа үг хэлнэ.

**3.Нарантуяа:** За баярлалаа. Бид бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг анхнаасаа хийлгэхийн төлөө, үүнийг батлуулахын төлөө өнөөдрийг хүртэл энд байгаа гэж би ойлгож байгаа.

Сая энд гишүүд яриад байна л даа. Үндсэн хуулийн төслийг ард нийтийн санал асуулгаар явуулах Улсын Их Хурлын 73 дугаар тогтоолыг хориг тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг авахаар энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал тэр чигээрээ зогсоно гэж тайлбарлаад байгаа нь би бол дутуу ойлгож, хэлж байгаа үг байна гэж бодож байгаа.

Эсрэгээрээ харин хоригийг авахгүй бол энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт чинь ард нийтийн санал асуулга чинь өөрөө бүр мухардалд ороод гацаад байна гэдэг энэ хоёрхон нүүдлийн дараах үр дагаврыг яагаад харахгүй байгаа юм бол гэж үүн дээр л харамсаад байна л даа. Яг өнөөдөр хоригийг авахгүй, 73 дугаар тогтоол, энэ хэвээрээ үлдье гэж бодъё. Ямар бодитой эрсдэл үүсэх учраад учрах билээ гээд бодохоор 73 дугаар тогтоолоор нэгдүгээрт ард нийтийн санал асуулга явах юм шиг, түүгээр энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хоёрдугаар хэлэлцүүлгийн эх ноорог ингээд батлагдчих юм шиг төсөөлөөд байгаа байхгүй юу.

Бодит байдал дээр энэ чинь өөр байна шүү дээ.

Бид нар гараад санал асуулгаа явуулъя, санал асуулга чинь нэгдүгээрт, 73 дугаар тогтоол чинь анхнаасаа олон хуулийн зөрчил гаргасан учраас гараад л Үндсэн хуулийн цэц юм уу олон маргааныг, олон иргэд гаргах бодит эрсдэл байна. Дээрээс нь санал асуулгаа явуулъя гэхээр ирц чинь хүрэх үү. Гуравдугаарт,

хамгийн гол эрсдэл нь санал асуулгаар та нарын оруулсан нэмэлт, өөрчлөлтийг ард иргэд за гэж дэмжих үү үгүй юу гэдэг.

Ийм эргэлзээтэй олон асуудал байгаа байхгүй юу. Эрүүл ухаанаар бодоод үзвэл. Эсрэгээрээ хоригийг авахгүй гээд эргэж бид нар энэ Үндсэн хуулийнхаа өөрчлөлтийг цааш нь явуулах механизм нь хоригийг авахгүй байж, байж хоригийг авч байж 73 дугаар тогтоолдоо засвар оруулж дахиж явуулах асуудал байгаа. Үүнийг одоо хуульч хүн бол, Бямбацогт дарга маш сайн мэдэх ёстой. Ойлгож байх ёстой.

Бид нар энэ үүссэн нөхцөл байдлыг мухардлаас гаргах нөхцөл байдлыг бий болгох гэж л өнөөдөр зөвшилцөх санал гаргаад л, Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавиад л ингээд байгаа шүү дээ. Түүнээс агуулга дээр нь Ерөнхийлөгч хориг тавиагүй. Агуулгыг өөр сайн сайжруулах боломж байвал зөвшилцье гэдэг саналыг Ардчилсан нам тавьсан. Олон гишүүд энэ дотроос эсрэгээрээ Ардчилсан нам Ерөнхийлөгчтэйгөө нийлж байгаад маш сайхан өөрчлөлтийг зогсоогоод байгаа юм шиг ингэж зүгээр нэг бодлогогүй, заалны улс төр хийж болохгүй. Үүнийгээ сайн харах хэрэгтэй.

Би бол энэ олон нийтийн санал асуулгыг жинхэнэ утгаар нь явуулах ёстой гэж үзэж байна. Явуулахдаа тулбал бид нар энэ хоригийг хүлээж авч байгаад, үнэхээр энэ танхимд шийдэж чадаагүй Монголын нийгмийн захиалга болж байгаа энэ парламентын засаглал, гүйцэтгэх засаглалын хоорондох эрх мэдлийн тэмцлээ жинхэнэ сонгодог утгаар нь шийдэх олон орхигдуулсан асуудлаа ард түмнээр асуулгаад шийдэх ёстой гэж бодож байгаа. Ингэж байж бид нар Үндсэн хуульд өөрчлөлт оруулсны эцсийн үр дүн дагавар нь нэмэх гарна. Энэ бол аль нэг намд хэрэгтэй зүйл биш л дээ. Энэ бол Монголын ард түмэнд, Монгол Улсын хөгжилд хэрэгтэй. Энэ танхим дотор бид нар улс эх орныхоо эрх ашгийг бодож ярих ёстойгоос биш зүгээр нэг хэлбэр хөөж яримааргүй байгаа юм. Харамсалтай байна, маш олон гишүүд өнөөдөр энэ хоригийг зөвхөн Ерөнхийлөгчийн хориг гэдэг өнцгөөс нь хүлээж авч энэ зааланд бид нар өнөөдөр хорь гаруйхан хүн энэ хоригийн тухай ярьж байна шүү дээ. Энэ хоригийн цаана ямар их ач холбогдол бүхий агуулгатай зүйлүүдийг бид нар эрүүл ухаанаар хэлэлцэж, шийдвэрлэх байтал зүгээр хөнгөн хуумгайгаар хандаж оролцохгүй, .../минут/

**Г.Занданшатар:** Эрхэм гишүүн Самандын Жавхлан үг хэлнэ.

**С.Жавхлан:** За та бүхэндээ энэ налгар намрын мэнд хүргэе. Миний хувьд энэ хоригийг дэмжиж байгаа юм, нэг талдаа. Яагаад ямар утгаар нь дэмжиж байна вэ гэхээр энэ цаг үеэ олоогүй байна.Одоо өвөлжилтийн бэлтгэл, тариа ногоо, ингээд хүүхдүүдийн ханиад томуу гээд ингээд цааш нь утаа униар гээд ийм зүйлүүд асар их зүйлүүд шахаад хөвөрнө. Тэгэхээр яг энэ цагаар энэ сандруу цагаар ийм зүйлүүдийг санал асуулга явуулна гэдэг бол ирц хүрэхгүй, цаашаа гаргалгаагүй болох ийм асуудал байгаа юм. Тэгээд зөв мэдрэмжтэй цагтаа асууж болно шүү дээ. Хавар сайхан тавиу дэлгэр цагаар маш онц мэргэн асуултуудыг, ямар асуулт асуух вэ гэдэг нь маш их сонин. Түүнээс биш миний хувьд санал

асуулгыг асууж болохгүй, огт асууж болохгүй гэдэг зүйл надад алга байна. Тэгээд Ерөнхийлөгчийн өнөөдөр хоригийг хэлэлцэж байхад өөрийнх нь оруулж ирсэн хоригийг хэлэлцэж байхад энэ Ерөнхийлөгч маань бас хаачив аа, Ерөнхийлөгч маань ирж ажлаа хийгээч, өөрийнх нь тавьсан хоригийг хэлэлцэж байхад ингээд биеэ оторлодог юм уу, эсвэл тэр чигтээ бантан болоод баларцгаа гэж бодоод байгаа юм уу, энэ бол их ойлгомжгүй байна л даа.

Уг нь намрынхаа чуулганы нээлт дээр мөн давхар өнөөдөр ирээд энэ Ерөнхийлөгчийн засаглалыг асуух боломжгүй гэхээр хориг тавьж байгаа юм уу, эсвэл би буруу асуудал тавьжээ гээд хориг тавьж байгаа юм уу, эсвэл энэ асуудал бүхэлдээ хэрэггүй гээд байгаа юм уу, энэ араас нь давхар Их Хурал тарна гээд зөндөө олон ярианууд гараад л, ингэсэн ийм зүйлүүдийг юм дээр Монгол Улсын эв нэгдлийн билэг тэмдэг гэдэг утгаараа, ингэж тангараг өргөсөн гэдэг утгаараа ирээд энэ бүх зүйлүүдээ хэлээд тайлбарлаад, гарц гаргалгааг нь гаргаад ингээд өөрөөс нь үгийг сонсмоор байна л даа. Тэгээд урд талдаа шатрын хүү түлхэж байгаа юм шиг Тамгын газрын даргаа түлхдэг. Тэгээд өнөө хүн нь ирээд наг нуг наг нуг гээд байдаг, тэгээд нэртэйгээр нь ингэж үүргээ умартаж байхын оронд Тамгын газрынхаа даргад ажлаа өгчихмөөр юм. Тэгэхээр дараа дараагийн юм дээр энэ зүйл дээрээ анхаарч ажиллах байх, ажлаа хийгээч гэж би хэлмээр байна. Гялайлаа.

**Г.Занданшатар:** Одоо эрхэм гишүүн Бөхчулууны Пүрэвдорж үг хэлнэ. Алга байна. Одоо Дуламсүрэнгийн Оюунхорол үг хэлнэ.

**Д.Оюунхорол:** За, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн асуудлаар хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор олон гишүүний ярьж байгаа, хариулж байгаа хариултуудыг сонслоо. Нэг зүйлд маш их харамсаж байна.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэдэг бол Үндсэн хууль маань нийгмийн гэрээ гэж ойлгож, бид Үндсэн хуульдаа маш их хүндэтгэлтэйгээр хандаж бүтэн жил ярьсан. За үнэхээр Лүндээжанцан даргаар ахлуулсан ажлын хэсэг, энэ хуулийг боловсруулахаас эхлээд маш хариуцлагатай хандсан. Бид нар олон жил энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай асуудлыг ярьсан.

Өнөөдөр яг ийм эгзэгтэй үед бид нар улс төрийн соёл гаргаж, зөвшилцөл хийж Үндсэн хуулийнхаа хэлэлцүүлгийг явуулж чадаагүйнхээ горьг өнөөдөр бид нар амсаад сууж байна. Үүн дээр бол манай намын, хүний намын ч гэлтгүй бүгд манай Улсын Их Хурлын гишүүд нам харгалзахгүйгээр дүгнэлт хийх цаг нь болсон.

Өнөөдөр үг хэлж байгаа зарим гишүүд маань ярьж байна, хориг авна гэвэл нэлээн муу хүмүүс юм шиг, хориг авахгүй гэвэл сайн хүмүүс болох гэж байгаа юм шиг ийм арчаагүй дүгнэлт хийгээд яриад сууж байгаа залуучуудынхаа яриаг сонсоод ичиж байна.

Ер нь өнөөдөр энэ Үндсэн хуулийн хэлэлцүүлгийг явуулах хэн ямар байр суурьтай байж, яаж асуудалд яаж хандаж, ер нь Үндсэн хуулийнхаа өөрчлөлтийг

жинхэнэ утгаар нь яаж шинэчилж гаргах вэ гэж бодож байгаа тийм арга зам хайж байгаа хүмүүс нь хэд байгаа юм бол. Одоо би тэгж асуумаар бараг санагдаад сууж байна. Эргэлзэж байна.

Тийм учраас өнөөдөр Үндсэн хууль зөвшилцлөөр улс төрийн соёлтойгоор ярилцаж, улс төрийн намууд одоо ядаж өнөөдрийн парламентад сууж байгаа сөрөг хүчин болж байгаа Ардчилсан намтайгаа, Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцөлд хүрч чадахгүйгээр бид нар яаж нийгмийн гэрээний энэ том Үндсэн хуулийнхаа өөрчлөлтийг хийж чадах юм. Бярдана, эсвэл олонхоороо хүч түрнэ гэсэн маягаар энэ асуудалд бид нар хандах ёсгүй байсан.

Энэ Үндсэн хуулийн өөрчлөлт гэдэг бол Үндсэн хууль гэдэг бол Ардын намын 64 хүний шийдэх гэж байгаа асуудал биш. Монголын ард түмнээсээ бид нар асууж шийдвэрлэх ёстой гэдэг дээр энэ зааланд сууж байгаа 75 гишүүн 75-уулаа санал нэг байгаа. Ард нийтийн санал асуулгаа явуулъя, явуулахын тулд бид нар ямар арга замаар яаж явуулах вэ, ямар байдлаар явуулах вэ гэдгээ ярилцъя зөвшилцье, ойлголцье гэж ярьсан.

Би өнөөдрийн орж ирсэн хоригийг, бүхэлд нь тавьсан хоригийг бол хэсэгчлээд хүлээгээд авах тийм боломж байгаа байх гэж бодож байгаа. Хэсэгчилж аваад тэгээд Үндсэн хуулийнхаа нэмэлт өөрчлөлттэй холбоотой ганц нэг заалтыг хоёрдугаар хэлэлцүүлгээ хааж хаяхгүй байж байгаад гурваар хэлэлцүүлэхгүй байж байгаад зөвшилцлөөр бид нар ганц хоёр асуудлаа ярилцаж байгаад ингээд гурав дугаар хэлэлцүүлэг рүү орвол арай дээр байсан юм биш биз ээ гэж бодоод Үндсэн хуулийн хоригийг авах нь зүйтэй гэж бодож байгаа.

Тэртээ тэргүй Монгол Улсын Ерөнхийлөгч гэдэг бол төрийн нэг институт, бид нар өнөөдөр Үндсэн хуулийг Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдлийг илэрхийлэгчийнх нь хувьд хүссэн хүсээгүй ч хэний аль намаас гарснаас нь үл шалтгаалж, бид нар энэ хүмүүстэй зөвшилцлийг хийж байсан уламжлалтай, хийх ч ёстой.

Өнөөдөр бид нар ийм улс төрийн соёлгүйгээр юм яриад бие бие рүү нэр хоч хаяг зүүгээд ямар нэгэн улс төрийн нэмэх хасах оноо авдаг тэр Попт улс төрийн тоглоомоор тоглох гээд сууж байгааг нь буруу гэж бодож байна. Тийм учраас өнөөдөр үүнийгээ сайн ярилцаж байж, тунгааж байж, эргээд энэ Үндсэн хуулийнхаа ард нийтийн санал асуулга явуулах асуудал дээрээ жижигхэн хэмжээний нэмэлт, өөрчлөлтийг тогтоолын төсөл дээрээ өөрчлөлтөө оруулаад зөвшилцөөд, Ардчилсан нам зөвшилцье гэж албан бичгээ ирүүлсэн юм байна билээ, тийм учраас Ардын нам, Ардчилсан намын зөвшилцлийн ажлын хэсгүүд, магадгүй Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар оролцоод, ингээд энэ асуудлаа ярилцаад шийдвэрлэх боломж гарц байгаа, үүний дараа ард нийтийн санал асуулгаа .../минут/

**Г.Занданшатар:** Нэмэлт минут байхгүй, За одоо гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулахад бэлдэнэ үү.

Төрийн байгуулалтын байнгын хорооны саналаар Ард нийтийн санал асуулга явуулах Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Бүгдийг зарлаж цуглуулсан. Цэцийн асуудал сүүлд байхгүй. Санал хураалт явуулья.

Санал хураалтад 53 гишүүн оролцож 19 гишүүн дэмжиж, 35.8 хувийн саналаар хоригийг хүлээж авсан байна. 33.4-өөс дээш биз дээ. Дараагийн асуудалд орно шүү. Хүлээж авсан.

Ард нийтийн санал асуулга явуулах Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зүйтэй гэж үзлээ. Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын хэлснээр хэсэгчлэн хүлээж авч байгаа гэж гишүүдийн хэлсэн гэж ойлгож байна.

Дараагийн асуудалд оръё. Ерөнхийлөгчийн хоригийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг уншиж танилцуулья. Ерөнхийлөгчийн хоригийн тухай Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Улсын Их Хурал 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр баталсан Улсын Их Хурлын 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсугай.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

За тогтоолын төслийг батлах санал хураалт явуулна. Эхлээд тогтоолын төслийг батлах санал хураалт явуулах юм байна шүү. Саяны тогтоолын төслийг батлах тухай санал хураалт явуулья. Ерөнхийлөгчийн хоригийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Ерөнхийлөгчийн хоригийн тухай, энэ дахин санал хураалт явуулах горимын санал гаргаад дахин санал хураалт явуулж болно. За Билэгт гишүүн.

**М.Билэгт:** Сая тогтоол батлахад энэ хурууны хээ орсонгүй. Тэгэхээр дахин, саяын санал хураалтыг хүчингүй болгоод дахиад хураалгаад өгнө үү.

**Г.Занданшатар:** Билэгт гишүүний, Жавхлан гишүүн, Эрдэнэбат гишүүн нарын саналаар энэ санал хураалтыг хүчингүй тооцох санал хураалт явуулья. Тогтоол батлагдахгүй байна даа.

Дэгийн тухай хуулиар 14 хоногийн дотор өнөөдрийн дотор дэгийн асуудлыг нэг тийш нь шийдэх ёстой. Хориг сая 34.8 хувь хоёр хүний саналаар.

Баасанхүү гишүүн горимын санал.

**О.Баасанхүү:** Би ингэж бодоод байна л даа. Хоригийг авах уу үгүй юу гэдэг асуудал шийдэгдсэн. Одоо зүгээр хоригийг хэлэлцэж дуусгах уу үгүй юу гэдэг асуудлыг шийдэх гээд яваад байна шүү дээ. Тэгэхээр хэлэлцэхгүй гэж санал гаргаж байгаа гишүүд бол миний ойлгож байгаагаар Үндсэн хуулийг зөрчье л гэсэн үг. Яагаад гэхээр Үндсэн хууль дээр Үндсэн хууль болон олонх холбогдох хууль дээр 14 хоногийн дотор хэлэлцэнэ гэж байгаа. Тэгэхээр өнөөдөр энэ бол гишүүд өнөөдөр санал гаргахдаа хуулиа дагаж ажиллана гэсэн тангарагтай, хуулийн дагуу өнөөдөр юу вэ гэхээр одоо 14 хоногийн хугацаа чинь болчихлоо, үүнийг 14 хоногтоо ярих уу, яримааргүй байна уу гэдгийг чинь нэг талдаа гаргасан нь дээр.

МАНАН мафийн гар хөл байхаа больцгоо. Жинхэнэ МАНАН мафийн гар хөлүүд гэдэг чинь төрөөр тоглодог, төрөө самардаг, хуулийг дагахгүй байх хүмүүсийг хэлдэг. Тийм учраас горимын санал гаргаад дахиад нэг үзье. Үгүй бол энэ Цэц рүү явж таарна.

Өөрөөр хэлбэл хэлэлцэх асуудал нь Цэц рүү явна уу гэхээс биш хоригийн асуудал Цэц рүү явахгүй шүү гэдгийг би протоколд анхааруулж хэлж байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Их Хурлын Тамгын газар яах юм бэ, та наад юугаа өг л дөө. Горимын санал дахиж хураах уу яах уу? Наадахаа та нар хууль зүйн зөвлөгөө яах юм бэ? Энэ чинь гуравны нэгээр хориг хүлээгээд авсан, тэгэхдээ 50 хувьдаа хүрэхгүй байна л даа. Тогтоолын төсөл нь батлагдахад.

Баасанхүү гишүүний гаргасан саналаар дахиж санал хураах уу, үгүй юм уу, наад хариугаа микрофондоо хэлчхээч дээ. Микрофон чинь асаалттай байна.

**Н.Цогтсайхан:** Сая Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах эсэх асуудлаар санал хураагаад шийдвэрлэсэн. Тэгээд одоо тогтоол гарах ёстой. Тэр тогтоолыг Их Хурал батлах ёстой. Дэгийн хуулийн 31.1-д заасны дагуу 10 хоногийн дотор хэлэлцээд шийдвэрлээд тогтоол батлах ёстой.

**Г.Занданшатар:** Батлах ёстой гээд санал хураалт явуулах гээд байна шүү дээ. Тэгээд санал хураалт дахиж явуулах юм уу гэж асууж байгаа болохоос биш батлах ёстой юу үгүй юу гэж асуугаагүй байна л даа.

**Н.Цогтсайхан:** Батлах саналыг чинь ирц нэгэнтээ тодорхой шалтгаанаар горимын санал гаргаад дахиад санал хураагаад тогтоолоо батлах ёстой.

**Г.Занданшатар:** Санжмятав гишүүн.

**Я.Санжмятав:** За баярлалаа. Би Баасанхүү гишүүнтэй санал нэг байгаа юм. Нэлээд олон гишүүд бас сул гараад явчихсан, сая энд байж байгаад саналаа өгсөн хурууны хээгээр саналаа өгсөн 3-4 гишүүд минийх ороогүй байна, санал орсонгүй гэдэг зүйлүүдээ өөрсдөө гараа өргөөд хэлээд байгаа учраас би энэ удаа дахин өмнөхийг нь хүчингүй болгоод дахин санал хурааж, нэг талдаа багтаасан нь дээр гэж.

Яагаад гэвэл горимыг хүлээж авсан, тогтоолыг нь баталж өгөх үүрэгтэй ийм парламентын гишүүд. Болж өгвөл эзэнгүй картуудыг сугалах ийм нөхцөл байх уу үгүй мэдэхгүй байна. Би үүнийг гишүүний эрхэнд халдсан хэрэг болох байх. Хамгийн гол зүйл байгаа гишүүд нь үүнийгээ батлах ёстой, үүргээ биелүүлье гэж горимын санал гаргаж байна.

**Г.Занданшатар:** Нэгдүгээрт техникийн хэлтсийнхэн картуудын ажиллагаа дээр хяналт тавь. Хоёрдугаарт, орхиод явсан картуудыг яах юм бол бүлгийн дарга нар шийд. Ингээд санал хураалт, Санжмятав, Баасанхүү гишүүн нарын саналаар өмнөх санал хураалтыг хүчингүй тооцсон санал хураалт явуулъя. За, Нямдорж сайд.

**Ц.Нямдорж:** Энэ байхгүй гишүүдийн картыг аваач, байгаа ирцдээ санал хураачих л даа. Хоёрдугаарт, гишүүд минь энэ хоригийг хүлээж авна гээд шийдвэр гарчихлаа шүү дээ. Одоо энэ дээр гөжүүдлээд, давхар улс төрийн ойлгомжгүй байдал үүсгээд хэрэггүй шүү дээ. Ямар учиртай юм. Би та бүхнийг асуудлаа нэгэнт Их Хурлын шийдвэр гарсан учраас Үндсэн хуулиа дагаад тогтоолыг нь баталж өгөхийг уриалж байна. Ийм замбараагүй байдал байж болохгүй. Яагаад ингээд байгаа юм болдоо. Одоо саяынхаа саналыг хүчингүй болгоод, хураалтыг хүчингүй болгоод, дахиад санал хураачихаач.

**Г.Занданшатар:** Санал хураалтаар хүчингүй болгоно шүү дээ. За ингээд Санжмятав гишүүн, Баасанхүү гишүүн нарын саналаар өмнөх санал хураалтыг хүчингүй тооцох санал хураалт явуулна. Байхгүй картуудаа сугалаарай Улсын Их Хурлын Тамгын газар.

Санал хураалт.

Санал хураалтад 52 гишүүн оролцож 28 гишүүн дэмжиж 53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдэж өмнөх саналыг хүчингүйд тооцлоо. Одоо санал хураалт явуулна.

Тогтоолын төслийг батлах тухай. Түрүү уншиж танилцуулсан Ерөнхийлөгчийн хоригийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 51 гишүүн оролцож 30 гишүүн дэмжиж 58.8 хувийн саналаар энэ тогтоол батлагдлаа. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай

гишүүн байна уу. Алга байна. Тогтоолын эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.  
Дараагийн асуудалд орно.

.....  
Өнөөдрийн хуралдааныг өндөрлөө. Гишүүддээ баярлалаа. Сайхан  
амраарай.

Дууны бичлэгээс буулгасан:  
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ  
ГЭРЭЭТ АЖИЛТАН

/Б.БААСАНЖАВ/

/Б.УРАНЧИМЭГ/

/Д.ЭНЭБИШ/



